

unesco

# Хэвлэл Мэдээлэл дэх Хөгжлийн Бэрхшээл ба Тэгш Байдал

Төлөөлөл | Хүртээмж | Менежмент

## Гарын Авлага

НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллагаас 2024 онд хэвлүүлэв,
7,  Фонтенуа талбай, 75352, Парис хот 07 SP, Франц

© UNESCO 2024

ISBN: 978-92-3-000243-5
DOI: https://doi.org/10.58338/TOQJ6537

Уг хэвлэлийг Attribution-ShareAlike 3.0 IGO (CC-BY-SA 3.0 IGO) тусгай эрхтэйгээр Нийтэд нээлттэй байршууллаа (http://creativecommons.org/licenses/by-sa/3.0/igo/). Гарын авлагын агуулгыг ашиглах тохиолдолд ЮНЕСКО-гийн Нийтэд нээлттэй бүтээлийн сангийн зохих нөхцөл, шаардлагыг дагаж мөрдөнө үү. (https://www.unesco.org/en/open-access/cc-sa).

Номны англи нэр: Disability equality in the media: representation, accessibility, management; practical manual

Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас 2024 онд эрхлэн гаргав.

Одоор (*) тэмдэглэгдсэн зургууд нь CC-BY-SA лицензэд хамаарахгүй бөгөөд зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр ашиглах, хуулбарлахыг хориглоно.

Энэхүү хэвлэлд ашигласан зураг дүрслэл, баримт бичгийн танилцуулга зэрэг нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот, бүс нутгийн эрх зүйн байдлын тухай, эсвэл түүний эрх баригчдын эрх зүйн байдлын талаар, эсвэл хил хязгаарыг нь тогтоохтой холбоотой ЮНЕСКО-гийн байр суурь биш болно.

Гарын авлагад илэрхийлсэн байр суурь, үзэл бодол нь ЮНЕСКО-гийн албаны байр суурийг төлөөлөхгүй, зөвхөн зохиогчдынх тул тэдгээрийн өмнө ЮНЕСКО ямар нэг үүрэг хүлээхгүй.

Хавтасны зураг: Beyond Borders Media
График дизайн: Ana Carrasco/UNESCO
Хавтасны загвар: Ana Carrasco/UNESCO
Гар зургууд: Ana Carrasco/UNESCO

Англи хэлнээс орчуулсан: Ж.Өнөмөнх
Хянан тохиолдуулсан: Ж.Хулан
Эх бэлтгэлийг: С.Урангоо

ЮНЕСКО хэвлэв.

# Товч Хураангуй

## Хэвлэл Мэдээллээр Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийн Тэгш Байдлыг Хангах нь

Редакц, мөн редакцын удирдлагын түвшинд эерэг өөрчлөлт бий болсоор байгаа хэдий ч  хэвлэл мэдээллийн олон талт байдлын үзүүлэлт асуудал хэвээр байсаар байна.

Нийгмийн аливаа бүлэг хэвлэл мэдээллийн гадна үлдвэл олон талын байр сууpь, шинэлэг санаанууд гээгдэж, сэдвийг олон янзын өнцгөөс, цогцоор нь гаргаж чаддаггүй. Үр дүнд нь үзэгчдэд бүрэн дүр зураг хүрэх байдал алдагдаж, нийгмийн төлөөллийг тэгш, оновчтой оролцуулах амлалт зөрчигдөх бөгөөд, энэ нь нийгмийн гишүүдийн бие биедээ хандах хандлагад нөлөөлнө. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст яг энэ асуудал тохиолдож байна. Үүний нэгэн жишээ нь дэлхийн хүн амын 16 хувийг бүрдүүлдэг хэр нь хамгийн үл хайхрагдаж буй бүлэг бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс юм. Хэвлэл мэдээлэл ч тэднийг үл анзаарах ба хөгжлийн бэрхшээлийн тухай мэдээлэхдээ хэвшмэл байдлаар дүрсэлдэг. Ингэснээр тэдэнд саад тотгор үүсгээд зогсохгүй эрхийг нь хязгаарлах аюултай. Үүнийг шийдвэрлэхийн тулд хэвлэл мэдээллийн байгууллагууд редакцын бодлого, төлөөлөл сонголтоо сайжруулах, ажилд авах шаардлагаа эргэн харж, хөгжлийн бэрхшээлтэй мэргэжилтнүүд ажиллах боломжтой орчин нөхцөл бүрдүүлэх нь зөв.

Редакцын багууд хөгжлийн бэрхшээлийн талаар тэнцвэртэй, алагчлалгүй сурвалжлахад шууд ашиглах боломжтой зөвлөмжүүдийг энэхүү Практик гарын авлага болон ахисан түвшний сургалтдаа багтаалаа. Контент бүтээгчдэд ч тэр медиа контент, үйлчилгээг хэрхэн хүртээмжтэй байлгах нарийн агуулгыг багтаасан. Менежер эсвэл шийдвэр гаргагч бол энэ гарын авлага танд сэдэл төрүүлж, хөгжлийн бэрхшээлийн тэгш байдал нь хэвлэл мэдээллийн салбарын хөгжилд ямар хувь нэмэртэйг ойлгуулж, орлогын шинэ суваг бий болгоход туслах юм.

**Дэлхийн нийт хүн амын 16%-ийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бүрдүүлдэг.**

Энэ бүтээл нь НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын (2006) хэрэгжилтэд хувь нэмэр болж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг сурталчилж, хэвлэл мэдээллийн хөгжлийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийтэд хамааралтай асуудалд мэдээлэл олж авах боломжоороо дамжуулан утга учиртай оролцоотой байхад нь туслах зорилготой болно.

# Хэвлэл Мэдээлэл дэх Хөгжлийн Бэрхшээл ба Тэгш Байдал

Төлөөлөл | Хүртээмж | Менежмент

Гарын Авлага

# ЮНЕСКО Ахисан Түвшний сургалт
# Хэвлэл Мэдээлэл дэх Хөгжлийн Бэрхшээл ба Тэгш Байдал
# Төлөөлөл | Хүртээмж | Менежмент

ЮНЕСКО энэхүү Практик гарын авлагын хамт Хэвлэл мэдээллээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдлыг хангах ахисан түвшний сургалтын видео цувралыг боловсрууллаа. Эдгээр бүтээлийг редактор, сэтгүүлч, нэвтрүүлэгч, дизайнер, контент менежер, техникийн ажилтан, хүний нөөцийн мэргэжилтэн, удирдлага зэрэг бүх хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдэд зориулав. Мөн сургалтын видеонууд нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын дагуу баталсан мэргэжлийн стандартыг бүрэн хангасан.

Ахисан түвшний сургалтын видео цувралыг сэтгүүлч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн төлөө тэмцэгч хатагтай Софи Морган хөтөлсөн ба ЮНЕСКО-гийн Харилцаа холбоо, мэдээллийн асуудал хариуцсан орлогч дарга, ноён Тауфик Желасси танилцуулж, Люксембургийн Гүнж Мария Тереза, сэтгүүлч, телевизийн нэвтрүүлэгч хатагтай Кристиане Аманпур, ЮНЕСКО-гийн Энхийн төлөө уран бүтээлч хатагтай Жэйн Констанс нар оролцлоо. Энэ цувралыг ЮНЕСКО болон Beyond Borders Media хамтран бүтээв.

## Бичлэгийн жагсаалт

| | |
|---|---|
| 1 | Албан Ёсны Зарлал |
| 2 | Юнеско-гийн Албан Ёсны Илгээлт |
| 3 | Танилцуулга |
| 4 | Хэвлэл Мэдээллээр Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийг Төлөөлөх Байдал |
| 5 | Мэдээ Сурвалжилгаар Олон Талт Байдлыг Гаргах нь |
| 6 | Мэдээ Сурвалжилгаар Дамжуулан Ялгаварлан Гадуурхалтай Тэмцэх нь |
| 7 | Хямралын Үед Хүртээмжтэй Мэдээлэл Түгээх нь |
| 8 | Видео Контентыг Хүртээмжтэй Болгох нь |
| 9 | Аудио Контентыг Хүртээмжтэй Болгох нь |
| 10 | Хэвлэмэл Контентыг Хүртээмжтэй Болгох нь |
| 11 | Дижитал Контентыг Хүртээмжтэй Болгох нь |
| 12 | Олон Талт Байдал, Тэгш Байдал, Оролцоог Хангах Хэвлэл Мэдээллийн Эргэх Хариуцлага |
| 13 | Хэвлэл Мэдээлэл дэх Тэгш Оролцоог Хангасан Менежментийн Практикууд |

**ДАРААХ QR КОДЫГ УНШУУЛЖ СУРГАЛТАА ҮЗЭЭРЭЙ.**

## АГУУЛГА


**Гарчиг** 7

**Танилцуулга** 8

**Практик гарын авлага ба Ахисан түвшний сургалтын тухай** 9

**Редакцын бүтээл ба эрх тэгш хөтөлбөр боловсруулах нь** 11

Эрх тэгш хэвлэл мэдээллийн хөтөлбөрт чиглэсэн редакцын бодлого 11

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс ярилцлага авч, тэдэнтэй харилцах нь 29

Хямрал, нүүлгэн шилжүүлэлт, байгалийн гамшиг, хүрээлэн буй орчны нөхцөл байдлыг сурвалжлах нь 30

**Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа болон контентыг хүртээмжтэй болгох нь** 33

Контентыг хүртээмжтэй хийх эрх зүйн шаардлага 33

Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд хүртээмжтэй байдлыг оруулах хэрэгжилтийн зөвлөгөө 36

Хэвлэл, телевиз, радио, дижитал хэвлэл мэдээллийн хэрэгсэлд авч болох арга хэмжээнүүд 38

**Тэгш оролцоот удирдлагын арга барил** 43

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх олон талт байдал, тэгш байдал, оролцоо 43

Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа, манлайлал, удирдлагын практикт DEI хөтөлбөрүүдийг нэвтрүүлэх нь 44

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудад зориулсан тэгш хамруулсан ажлын байр бий болгох нь 47

**Аргачлалын хүснэгтүүд** 53

**Эх сурвалж** 87

Талархал 87

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар бүс нутгийн түвшинд өгүүлсэн түүхүүд 89

Эшлэл 94

Нэмэлт эх сурвалж 98

Нэр томьёоны тайлбар 99

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдлыг хангах талаар түгээмэл асуудаг 20 асуулт 103

Тэмдэглэл 104

# Танилцуулга

Хэвлэл мэдээлэл олон талт байдлыг эрхэмлэснээр өргөн хүрээг хамарч, өсөн нэмэгдсээр буй хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгчдийнхээ чадамжийг нээнэ. Тэдний зах зээлд оруулах хувь нэмэр, худалдан авах чадварыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хүний суурь эрх, эрх чөлөөг нь хангаж, тэднийг хүчирхэг хэрэглэгчид болгодог.

Хэвлэл мэдээллийн байгууллага болон редакцуудын удирдлагын бүтцэд шинэ өөрчлөлт өрнөж байгаа боловч олон талт байдлыг хангах асуудал одоог хүртэл орхигдсоор байгааг шинэ тутам нэмэгдэж буй академик нотолгоо, бизнесийн стратеги, үйл ажиллагааны тайлан болон нийтийн хэлэлцүүлэг зэргээс харж болохоор байна. Нийгмийн зарим бүлгүүдийг, тэр тусмаа хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгчдийг үл ойшоох нь хэвлэл мэдээлэлд шинэ төрлийн өгүүлэмж, үзэл хандлага, бүтээлч сэтгэхүй, үлэмж давуу тал зэргийг орхигдуулах нөхцөл болж байна. Хэвлэл мэдээлэл олон янзын үзэгчдэд хүрч чадахгүй байх нь нийгэм дэх иргэдийн байр суурь, үзэл бодолд ч нөлөөтэй гэдэг нь гарцаагүй үнэн.[1]

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бол дэлхийн хамгийн гадуурхагдсан нийгмийн бүлгүүдийн нэг. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын мэдээлснээр дэлхийн хүн амын 16 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс. Гэсэн хэдий ч тэднийг үл тоомсорлож, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ч тэдний асуудлыг системтэйгээр орхигдуулсаар байна. Мөн тэдний хэвлэл мэдээлэл дэх дүрслэл нь ихэвчлэн хэвшмэл байдаг бөгөөд энэ нь олон нийтийн үзэл бодолд сөргөөр нөлөөлж, урт хугацаандаа тэдний өдөр тутмын амьдралд нөлөөлж улмаар эрхээ эдлэх боломжийг нь хязгаарладаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэдэгт асар өргөн хүрээг хамрах, нийгмийн хэрэгцээ хангагдаагүй хэрэглэгчид багтана. Сэтгүүл зүй дэх тэдний оролцоо, хувь нэмрийг үнэлж, ойлгож чадвал контентын хэрэглээ, олон нийтийн хэлэлцүүлэг дэх оролцоо болоод салбарын орлогын хувьд ч тэдний үзүүлэх нөлөө их. Тэднийг ийнхүү тэгш хамруулснаар зах зээлд хэрэглэгчийн үүднээс эзлэх хувийг нь нэмэгдүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ч өөрөө үнэнч хэрэглэгчийн баазаа бэлдэж чадна.

Дэлхий дахины өнөөгийн байдал нь хэвлэл мэдээллийн байгууллагуудаас үйл ажиллагаагаа дахин төлөвлөх , нийгэм дэх хариуцлага, чиг үүргээ сэргээн тодотгох , мөн хэрэглэгчидтэйгээ илүү ойртож, тэдний итгэл үнэмшлийг эргүүлэн олж авахыг шаардаж байна. Энэ асуудал технологийн дэвшлийн үр нөлөө нэмэгдэж, мэдээллийн эх сурвалж, мэдээлэл түгээгчдийн тоо олшрох тусам улам л хурцаар тавигдана. Зах зээл хувьсахын хэрээр өмнө нь үр ашигтай байсан бизнесийн загварууд нь хэвлэл мэдээллийн байгууллагуудын урт хугацааны оршин тогтнолыг бататгаж чадахгүй болжээ. Хүн ам зүй, нийгэм, улс төрийн орчин дахь эрс өөрчлөлт, хэрэглэгчдийн үзэл бодол, дадал зуршил, нийгмийн туйлшрал нэмэгдэж байгаа нь хэвлэл мэдээллийн менежмент, үйл ажиллагаанд шинэ туршлагыг нэвтрүүлэх, салбарын үйл ажиллагааг шинэчлэх зайлшгүй хэрэгтэйг сануулсаар байна.

Хэвлэл мэдээллийн төвлөрлийн эсрэг яаралтай хариу арга хэмжээ авах шаардлага ч бас бий. Учир нь хэрэглэгчдийн үзэл бодол, үзэл хандлагыг төлөвшүүлэхэд гол нөлөөтэй мэдээлэл, эх сурвалжийн тоо цөөрч, төвлөрч байна. Санаатай болон санамсаргүй ташаа мэдээллийн урсгал нэмэгдэхийн хэрээр хэрэглэгчдийн үнэн, бодит мэдээлэл авах боломж хумигдаж, найдвартай эх сурвалж үгүйрэх эрсдэлтэй. Иймд одоо хэвлэл мэдээллийн баримталж буй үйл ажиллагааны бодлого, хэв маяг зэргийг эргэн харж, мэдээллийн эх сурвалж, нийгмийн бүх бүлгийн дуу хоолойг дамжуулах индэр нь болж, олон ургалч, олон талт, ил тод, хариуцлагатай байж чадаж буй эсэхэд дүн шинжилгээ хийх хэрэгтэй.

Хэвлэл мэдээллийн олон талт байдлыг хангах нь хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгчдийг илүү сайн таних, контентыг илүү сайн үйлдвэрлэж, ашиглах боломжийг нээх бөгөөд үүгээр зогсохгүй, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд илүү сайн төлөөлөл болох замаар бүтээлч байдал, инновацаа нэмэгдүүлнэ. Нийгмийн түвшинд хэвлэл мэдээллийн байгууллага өөрийн чадавхыг бэхжүүлж, үнэн зөв, шударга, хүртээмжтэй мэдээллээр дамжуулан олон талт байдлыг асуудал болгож хөндсөнөөр оршин буй гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалттай тэмцэх, түүнчлэн нийгмийн хандлагыг өөрчлөхөд тустай. Хэвлэл мэдээлэл саад бэрхшээлийг арилгахад онцгой үр нөлөөтэй бөгөөд ингэснээр бүх иргэд, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрх, эрх чөлөөгөө бүрэн эдэлж, улмаар илүү хүртээмжтэй нийгмийг бий болгоход хувь нэмрээ оруулж чадах юм.

# Практик гарын авлага ба Ахисан түвшний сургалтын тухай

ЮНЕСКО болон олон тооны хамтрагчдын оролцоотойгоор боловсруулсан энэхүү Практик гарын авлага (цаашид “Гарын авлага” гэх) болон Ахисан түвшний сургалтын 13 цуврал бичлэг нь хэвлэл мэдээллийн байгууллагуудыг дор дурдсан хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдлыг хангахад уриалах зорилготой.

**1 дүгээр хэсэг: Редакцын бүтээл ба эрх тэгш хэвлэл мэдээллийн төлөвлөлт** Гарын авлагаар хэвлэл мэдээлэл дэх төлөөллийн гол зарчим болон хандлагуудын талаар эргэцүүлж, хөгжлийн бэрхшээл нь нас, арьс өнгө, хүйс, бэлгийн чиг баримжаа, үндэс угсаа, нийгэм, соёл, улс төрийн байр суурьтай хэрхэн огтлолцож буйг судална. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгсэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үзэл бодол, хэрэгцээ, зан байдал зэргийг хэрхэн төлөөлүүлж, илэрхийлж байгааг үнэлэх практик зөвлөмж /нэг ёсондоо ажлын жагсаалт/ өгнө. Хүртээмжтэй үг хэллэг, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс  эх сурвалж болгон  ярилцлага хийх тусгай аргачлалуудын талаар зөвлөгөөг ч багтаав. Мөн хөгжлийн бэрхшээлийн асуудлыг эрэн сурвалжлахад онцгой анхаарч, хэвлэл мэдээллийн байгууллага аливаа хямрал, байгалийн гамшгийг сурвалжлахдаа үр дүнтэй хариу арга хэмжээ авахын ач холбогдлыг тодотголоо.

**2 дугаар хэсэг: Хэвлэл мэдээллийн бүтээл, үйл ажиллагааг хүртээмжтэй болгох.** Гарын авлагад хэвлэл мэдээллийн контентыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох хууль эрх зүйн шаардлага болон техникийн стандартуудыг тусгасан. Хэвлэмэл, радио, өргөн нэвтрүүлэг, дижитал гээд төрөл бүрийн форматаар бүтээлээ бэлтгэхдээ хүртээмжтэй байдлыг хэрхэн хангах талаар практик зөвлөмжүүдийг багтаалаа.

**3 дугаар хэсэг: Тэгш оролцоонд суурилсан удирдлагын арга барил.** Энэхүү гарын авлага нь хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдэд (редактор, сурвалжлагч, сэтгүүлч, продюсер, менежер, хүний нөөцийн мэргэжилтнүүд болон техникийн баг) ажлын байран дахь олон талт байдал, тэгш байдал, оролцоог хангах бодлого, дадлыг хэрэгжүүлэхэд тусална. Хүртээмжтэй ажлын байр бий болгох, дотоод төлөөллийг сайжруулахын ач тусыг харуулах практик зөвлөмжүүдийг тусгасан. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудад илүү хүртээмжтэй үйл ажиллагааны болон менежментийн арга барилыг нэвтрүүлэх талаар зарим зөвлөмжийг багтаасан болно.

**4, 5 дугаар хэсэг: Аргачлалын хүснэгтүүд.** Энэ хэсэг нь уншигчдад нарийн төвөгтэй ойлголт, шат дараа бүхий үйл ажиллагаа болон журмуудын цогц, тэдгээрийн дараалал, ач холбогдол зэргийг ойлгоход тусална. Мөн богино хэмжээний **кейс судалгаануудаар** хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм, төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудад байгаа сайн туршлагын талаар бүрэн мэдээлэл өгнө. Бусад **унших материал, эх сурвалжуудын дэлгэрэнгүй жагсаалт, нэр томьёоны тайлбар толь, нэмэлт дүгнэлт** зэрэг нь танд шинэ бодлого боловсруулах, дадал нэвтрүүлэхэд хэрэгцээтэй мэдээллийг хүргэх юм.

Энэхүү гарын авлага болон ахисан түвшний сургалтын цуврал нь **редакторууд, сурвалжлагч, нэвтрүүлэгчид, хөтлөгч болон хөтөлбөрийн редакторуудад** хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хэрхэн тэгш хамруулсан, үнэн зөв, бодитой мэдээлэл бэлтгэхэд нь зүг чиг болох юм. Мөн сайтын **редакторууд, контент менежерүүд, дизайнерууд** болон хэвлэл мэдээллийн контент үйлдвэрлэх, техник хангамжийн стандартуудыг хангуулах үүрэгтэй **мэдээлэл технологийн ажилтнуудад** зориулсан зөвлөмжүүдийг агуулсан.
Үүний зэрэгцээ **хэвлэл мэдээллийн байгууллагуудын холбоод, байгууллага тус бүрийн удирдлага, менежмент, хүний нөөцийн ажилтнууд, санхүүгийн мэргэжилтнүүдэд** хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах замаар хэвлэл мэдээллийн салбарт шинэ боломж, орлогын эх үүсвэр бүрдүүлэх арга замыг санал болголоо.

Төгсгөлд нь, уг гарын авлага болон Ахисан түвшний сургалтын цуврал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг дэмжих олон улсын баримт бичгүүд, тухайлбал, Хөгжлийн Бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц (2006) зэргийг таниулж, **улс орнуудын тэргүүн, олон нийт, судлаачид, иргэний нийгэм, хувийн салбарынхныг** үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн хүртээмжтэй байдлыг дээшлүүлэх, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг олон нийтийн хэлэлцүүлэгт оролцуулахдаа хүндэтгэлтэй, эрх тэгш, хүртээмжтэй хамруулж, утга учиртай оролцоо бий болгоход уриалахад хувь нэмрээ оруулна хэмээн итгэж байна.



# Бүлэг I

© megaflopp/Shutterstock.com*

# Редакцын бүтээл ба эрх тэгш хөтөлбөр боловсруулах нь

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь тэгш хамруулах редакцын бодлого хэрэгжүүлснээр нийгмийн олон талт хүлээн авагчдад хүрэх боломжоо нэмэгдүүлж, тэр дундаа нийгмийн хэрэгцээ, төлөөлөл нь үл хангагддаг бүлгүүдэд үйлчлэх чадавхаа сайжруулна.

## Эрх тэгш хэвлэл мэдээллийн хөтөлбөрт чиглэсэн редакцын бодлого

Тэгш хамарсан редакцын бодлого хэрэгжүүлж, эрх тэгш хөтөлбөрөөр хангаснаар хэвлэл мэдээллийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон нийгмийн бусад янз бүрийн хэрэглэгчдэд үйлчлэх чадавхаа сайжруулж чадна. Үүний тулд редакцын сэдэв сонголт, зураг дүрслэл, хэл найруулга, зэрэгт **олон талт байдал, тэгш байдал, тэгш хамруулах** зарчмыг тусгах нь чухал. Мөн редакц дотроо ч төлөөллийг хангах нь уг зарчмын салшгүй хэсэг юм.

Ингэснээр хэвлэл мэдээллийн төлөөлөл нь үл хангагддаг нийгмийн бүлгүүдэд илүү чанартай контент, сайн үйлчилгээ үзүүлэх боломжтой. Түүнчлэн тэдэнд тулгардаг үл хайхрахуйг багасгахаас гадна **эрх тэгш** хандлагыг түгээн дэлгэрүүлнэ. Цаашлаад, хэвлэл мэдээллийн хэрэглэгч, захиалагч болон үйлчлүүлэгчдээ илүү танин мэдэх ба энэ нь орлогын сувгаа төрөлжүүлэхэд ч ач тустай. Үр дүнд нь олон нийтийн итгэлийг хүлээж, ажлын орчинд **тэгш оролцоог хангах** нэмэгдүүлэх замаар **олон ургалч** нийгмийг бүтээхэд гар бие оролцож үнэ цэнийг бүтээж буй хэрэг юм.

## Бүдүүвч зураг 1. Гол зарчмууд ба үр дагаврууд

### ГОЛ ЗАРЧМУУД:

| Олон талт байдал | Тэгш байдал | Тэгш хамруулах |
| --- | --- | --- |
| Олон талт байдал нь хүн бүрийн дахин давтагдашгүй өвөрмөц байдал, хүн хоорондын ялгааг чин үнэнээр, **хүндэтгэж**, нийгмийн олон бүлгүүдийг итгэл үнэмшил, ур чадвар, гарал үүсэл, үнэт зүйл, онцлог шинж зэргээс нь үл хамааран оролцоог хангах сайн дадлыг хэлнэ. Хэвлэл мэдээлэл нь нийгмийн бүх бүлгийн дуу хоолой болж, тухайн нийгмийнхээ олон талт байдлын тусгал болдог. | Тэгш байдал гэдэг нь бусадтай эн тэнцүү эрх эдлэх, нийгмийн боломж нөхцөлийг хүртэх ижил, **тэгш бололцоотой** байхыг хэлнэ. Хэвлэл мэдээлэл нь нийгэмд хоточ нохойн үүрэг гүйцэтгэж, эрхээ эдлэх ёстой болон эрхийг нь эдлүүлэх хариуцлага хүлээсэн этгээдүүдэд эрх, үүргийг нь сануулдаг. | Тэгш хамруулах гэдэг нь хүн бүрд нээлттэй, хүн бүрийг үнэлж хүндэлсэн, аливаа зүйлд харьяалагдах боломжтой орчныг бүрдүүлэх **үйл явцыг** хэлнэ. Хэвлэл мэдээлэл нь нийгмийн бүх бүлгийг хөтөлбөр төлөвлөлт, контент боловсруулалт, ажиллах орчин, үйл ажиллагаа зэрэгцээ тэгш хамруулахын төлөө хүчин чармайлт гаргах нь зүйтэй. |

### ҮР ДАГАВАР

| Олон ургалч байдал | Эрх тэгш байдал | Тэгш хамруулалт |
| --- | --- | --- |
| Олон нийтэд **сонголт** хийх боломж олгож буй хэвлэл мэдээллээр (төрийн, хувийн эзэмшлийн, орон нутгийн) дамжуулан олон янзын хүмүүсийн харах өнцөг, үзэл бодлын ялгаатай байдал болон оршихуйг **хүлээн зөвшөөрч, хүндэтгэх**ийг хэлнэ. | Хувь хүн бүрийн онцлог нөхцөл, тулгарсан тэгш бус байдлыг тодорхойлж, соёлын, түүхийн болон тогтолцооны саад бэрхшээлийг арилгах, нийт иргэдийг **хууль ёс, шударга үнэн**ий зүгт хөтлөх зохицуулалтуудыг хийх зэрэг урт хугацааны хүчин чармайлтыг хэлнэ. Хэвлэл мэдээлэл нь нийгмийн институтүүдийн түвшинд эрх тэгш байдлыг сурталчлахын зэрэгцээ өрөөсгөл хандлагыг бууруулж чадах ба бэлтгэсэн бүтээлүүдээ олон нийтэд хүртээмжтэй, хүндэтгэлтэй байлгах хэрэгтэй. | Нийгмийн бүлэг, хүрээллийг тэгш хамруулах үйл явцын үр дүнг хэлэх бөгөөд түүний **чанар, чадавхыг** харгалзана. Хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран, хэвлэл мэдээллийн салбарын бүхий л мэргэжилтнүүдэд **ээлтэй ажиллах орчныг** хэвлэл мэдээллийн байгууллагууд цогцлоож чадна. |

## *Хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох нь*

Хэвлэл мэдээллийн салбарын мэргэжилтнүүд гол тайлбар, баримтуудыг мэддэг байснаар өөрсдийн бэлтгэж буй агуулгаараа гүн гүнзгий дүн шинжилгээ хүргэж, нийтлэг ойлголцлыг бий болгохын зэрэгцээ хэрэглэгчидтэйгээ нэг ойлголттой болох, харилцаа үүсгэхэд тустай. Хөгжлийн бэрхшээлийн талаар илүү мэдлэгтэй байх нь нийгмийн асуудлыг холбогдох төлөөллийг нь оролцуулан хөндсөн мэдээ, мэдээлэл бэлтгэхдээ ч хамгийн тохиромжтой хандлага, арга барилыг сонгоход хэрэг болно.

Ямар **хандлагыг** сонгож, хэрэглэх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийтэд хэрхэн танилцуулж, хэрхэн **дүрслэхийг** тодорхойлдог. Хэвлэл мэдээллийн

## Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтууд

Хөгжлийн бэрхшээлтэй гэдэг ойлголт нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмд оролцоход саад болж буй хандлага, хүрээлэн буй орчны хязгаарлалтаас үүдэн бий болж буй ойлголт юм. Хөгжлийн бэрхшээлтэй гэдэг нь хүний өдөр тутмын үйл ажиллагаа, түүний дотор ажлаа хийх чадварт нөлөөлж болох эсвэл нөлөөлөхгүй байж болох бие махбод, мэдрэхүйн болон оюуны гэхчлэн янз бүрийн бэрхшээлийг хамардаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын 1 дүгээр зүйлд “Хөгжлийн бэрхшээл”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” зэрэг тусгайлсан тодорхойлолт байдаггүй. Гэхдээ тус конвенц агуулгынхаа хүрээнд тэдгээр нэр томьёог хэрхэн хэрэглэх тухай чиглүүлсэн байдаг. “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтойн бөгөөд бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн, үр дүнтэй оролцох боломж нь хязгаарлагдсан хүмүүсийг хэлнэ” гэжээ.

## Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай баримтууд

- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын (ДЭМБ) мэдээлснээр дэлхийн хүн амын **16 орчим хувь** нь (ойролцоогоор 1.3 тэрбум хүн) ямар нэг хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байна. Хүн амын насжилт, осол гэмтэл, зөрчил мөргөлдөөн, эрчимжиж буй байгалийн гамшиг зэргээс шалтгаалан энэ тоо өссөөр байна.[2]
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн **80 орчим хувь** нь хөгжиж буй орнуудад амьдарч буйг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс мэдээлжээ.[3]
- Дэлхийн хамгийн ядуу, буурай хүмүүсийн **20 орчим хувь** нь ямар нэг хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байгааг Дэлхийн Банк тогтоосон.[4]
- Дэлхийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй **арван хүн тутмын долоо** нь идэвхгүй, өөрөөр хэлбэл ажил эрхэлдэггүй, ажилгүй байдаг бол Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ) мэдээлснээр хөгжлийн бэрхшээлтэй арван хүн тутмын дөрөв нь байдаг.[5]
- **Таван эмэгтэй тутмын нэг нь** хөгжлийн бэрхшээлтэй гэх тооцоолол байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй ихэнх эмэгтэйчүүд үндэс угсаа, шашин шүтлэг, арьс өнгө, амьдран суугаа газар, харьяаллын байдал, нас, гэрлэлтийн байдал, ХДХВ халдвартай эсэх зэрэг олон янзын, хоорондоо давхардсан шинж байдлын хүрээнд нийгмийн хязгаарлалт, саадтай нүүр тулж байна. (НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага).[6]
- Мэдрэхүйн, бие махбодын болон суралцахуйн бэрхшээлтэй охид, хөвгүүдийн сургуульд огт хамрагдахгүй байдал үе тэнгийнхэнтэйгээ харьцуулбал **2.5 дахин** их (ЮНЕСКО).[7]

хэрэгслүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үзэгч, хэрэглэгчдийн ердөө нэгээхэн хэсэг гэж үзэж болох ч хэвлэл мэдээллийн салбарын мэргэжилтнүүд тэдний хэрэгцээ, туулсан зам, эрхийн талаар нийгмийн өргөн хүрээнд мэдлэг, ойлголттой байх нь маш чухал. Зайлшгүй шаардлага нь юу вэ гэвэл хэвлэл мэдээлэл үүргээ гүйцэтгэх явцдаа нийгэмд **зөв ойлголт түгээж**, зорилтот бүлэгт (эрхээ эдлэх ёстой иргэд) эрхийг нь таниулах эрх мэдэл бүхий этгээдүүдийг үүрэг, хариуцлагаа биелүүлэхийг **сануулж**, эрх нь зөрчигдсөн хэн бүхнийг хохирлоо барагдуулах үйлд **уриалах** учиртай.

### *Хэвлэл мэдээллээр дүрслэх нь*

Хэвлэл мэдээллийн байгууллагууд юуг сурвалжлах, тодорхой нөхцөл байдлыг хэрхэн илэрхийлэх, тайлбарлах, боловсруулж, мэдээ болгон хүргэх талаар байнга сонголт хийж байдаг. Хөгжлийн бэрхшээлийн талаарх асуудлуудыг хөндсөн өгүүлэмжийг голцуу дараах хоёр ангилалд хувааж болно:

- Хөгжлийн бэрхшээлийг **хөөрхийлөлтэй, эмчлэх ёстой**, мөн зовлон зүдүүр дагуулдаг, бие даан амьдрах чадваргүй  зүйл мэтээр дүрслэх.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг зүгээр л **хөгжлийн бэрхшээлтэй байсных нь төлөө урам зоригийн** сэдэл болгож харуулснаар тэднийг супер баатрын тавцанд аваачиж, цаашлаад тэдний эрхээ хамгаалахын төлөөх бололцоог хязгаарлаж, урт хугацаандаа амьдралын чанарт нь сөргөөр нөлөөлөх.

Сүүлд дурдаж буй ангилалд олон нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглэсэн сайн үйл хийх, хөгжлийн бэрхшээлгүй хүмүүс өөрсдийгөө азтай, хөгжлийн бэрхшээлгүй төрсөндөө баярлах ёстой мэт бодол төрүүлэх өгүүлэмжүүд багтана. Ихэнхдээ дорд үзсэн, ялгаварлан гадуурхсан, хөгжлийн бэрхшээлтэй хүн байх тухай ердөө таамаг төдий шинжтэй. Хоёр ангилал хоёулаа бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүгд хоорондоо ижил оршихуйтай мэтээр дурдаж, онцлог шинж байдлыг нь ерөнхийлсөн байдаг.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлийн тухай мэдээлэхдээ дараах дөрвөн загварыг (хандлага ч гэж болно) тунгааж, хөгжлийн бэрхшээлийн талаарх хувьсан өөрчлөгдөж буй ойлголтуудыг танин мэдэх хэрэгтэй.[8] Хэвлэл мэдээллийн салбарын мэргэжилтнүүд хөгжлийн бэрхшээлийг хэрхэн тодорхойлж, илэрхийлэх нь олон нийтийн ойлголт, хандлага, харилцах байдалт нөлөөлдөгт онцгой ач холбогдол нь оршдог.

Мөн анагаах ухааны болон буяны үйлд суурилсан арга барилтай холбоотой хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэмд

## Бүдүүвч зураг 2. Хэвлэл мэдээллээр дүрслэх нь

### Анагаах ухаанд суурилсан хандлага

Өвчин эмгэг, хөгжлийн бэрхшээл зэрэг нь бусдаас ялгаатай, илүү их анхаарал халамж шаарддаг, эмчилгээнд хамрагдах ёстой, бие махбодын давшгүй өөрчлөлттэй мэтээр дүрсэлдэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн хэрэгцээг л цохож онцолсноор нийгэм, эдийн засаг, улс төрийн зэрэг бусад, хэрэгцээ эрхүүд нь үл хайхрагдаж, хангагдах боломжгүй болох эрсдэлтэй.

### Буяны үйл, тусламжид суурилсан хандлага

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хохирогч эсвэл тэднийг өрөвдөх сэтгэлийн бай гэж үзүүлдэг бөгөөд зөвхөн хөгжлийн бэрхшээлээр нь голчлон тодорхойлдог. Тэдэнд тэгш байдал гэхээсээ илүүтэй тогтмол хандив, байнгын асаргаа, аливаа саадыг давах урам зориг хэрэгтэй байдаг мэтээр дүрсэлнэ.

### Нийгэм суурьтай хандлага

Бидний эргэн тойронд бие махбодын, хандлагын, харилцааны, нийгмийн саад тотгорууд бий бөгөөд эдгээр нийгмийн тогтсон санаа бодол нь хүмүүсийн ялгаатай хэрэгцээ, шаардлагад нийцдэггүй. Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш нийгмийн харилцаанд оролцохын тулд эхлээд хүрээлэн буй орчны өөрчлөлт хэрэгтэй гэж үздэг.

### Хүний эрхэд суурилсан хандлага

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын адил эрхтэй бөгөөд тэдгээр эрхэд боловсрол, ажил эрхлэлт, эрүүл мэндийн үйлчилгээ болон нийгмийн бусад эрхүүд багтана. Хөгжлийн бэрхшээл нь хүний олон янз байдал, илрэлийн нэг хэлбэр гэгддэг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхэм чанарыг умарталгүйгээр тэдний нэр төрийг хүндэтгэх ёстой.

бусдаас доогуур үзэх явдал байдаг бөгөөд үүнийг **хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дорд үзэх үзэл (ableism)** гэж нэрлэдэг. Энэ нь ерөнхийдөө айдас, таагүй байдал, хорсол, үл ойшоол зэргээр илэрдэг итгэл үнэмшил, дадал зуршлын нэгдмэл байдаг. Ингэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэм чанарыг гутааж, тэдний амьдрал үнэ цэнгүй мэт хандаж ялгаварлан гадуурхдаг. (Бүдүүвч зураг 2-ыг үзнэ үү)

Хэвлэл мэдээлэл нь мэдээ, сурвалжилга бэлтгэхдээ нийгмийн болон хүний эрхийн загварыг харгалзан бэлтгэх нь зүйтэй ба үүнд хэвлэл мэдээлэл нь **хүний нэр хүнд, олон талт байдал болон хүндлэлийг**

## Хүний эрхэд суурилсан хандлага

Нийгмийн төлөөлөл хангагдаагүй бүлгийн талаар илүү гүнзгий ойлголттой байж, тэдэнд өрөвч нинжин сэтгэлээр хандах нь сэтгүүл зүйн чанарт зарим талаараа ач холбогдолтой байж болох ч, тухайн бүлгийг нийгмийн баялагт хувь нэмэр оруулах идэвхтэй иргэн болгон чадавхжуулж, татан оролцуулж чадахгүй. Хүний эрхэд суурилсан хандлагыг баримталснаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрсдийн эрхээ мэдэж, шаардах боломжийг таниулж, уриална. Хөгжлийн бэрхшээлийн асуудлыг үнэн зөв, шударга, тэнцвэртэй тусгах нь олон улсын стандартыг бүрэн хүлээн зөвшөөрч, хүний эрхэд суурилсан хандлагыг редакцын бодлого, хөтөлбөрт системтэй нэгтгэхээс эхэлнэ. Үүнд **оролцоо, хариуцлага, ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш байдал, чадавхжуулах, хууль ёсны байх** гэсэн таван үндсэн зарчмыг редакцын бодлого, практикт голчлон нэвтрүүлэх ёстой.

Хэвлэл мэдээлэл нь хүний эрхэд суурилсан хандлагыг хэрэгжүүлснээр хүмүүс амьдралын чухал сонголтуудаа мэдээлэлд суурилж хийх эрх, эрх чөлөөтэй гэдгийг нь таниулахад хувь нэмрээ оруулна. Мөн хэрэглэгчдийн зан байдал, туршлагыг өөрчлөх, хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэхэд ч тус болно. Энэхүү хандлага нь уг суурьтаа **хүний бүх эрх нь салшгүй, харилцан хамааралтай, харилцан уялдаатай байдгийг харуулдаг. Урт хугацаандаа, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд төлбөртэй уншигчдыг** бэлтгэж, төрийн үйлчилгээний зар сурталчилгаа, контент синдикат, маркетинг, арга хэмжээ, ивээн тэтгэлэгт контент, хамтын ажиллагаа, өгөгдлөө мөнгөн эргэлтэд оруулах зэрэг олон төрлийн орлогын сувгийг нээж, салбартаа хөрөнгө оруулалт татах болно.

хэвшүүлэх замаар нийгэмд байгаа сөрөг хандлага, ялгаварлан гадуурхлыг арилгаж, үзэгчдэд эерэг хандлагыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах боломжтой.

**Хүснэгт 1-ийг үзнэ үү.** Хүний эрхэд суурилсан хандлагыг сэтгүүл зүйд хэвшүүлэх нь

Гарын авлагын туршид гол ойлголтууд, үйл ажиллагаа, дүрэм журам зэрэгт ямар аргачлалаар дүн шинжилгээ хийснийг 4-р хэсэгт байх хүснэгтүүдэд тоймлон харууллаа. Эдгээр нь уншигчдад агуулга хоорондын зүй тогтол, тэдгээрийн үр нөлөөг илүүтэй ойлгоход тустай.

### *Хүртээмжтэй редакцын бодлого, эрх тэгш хэвлэл мэдээллийн хөтөлбөрт чиглэх нь*

Сэтгүүлчид хөгжлийн бэрхшээлийн талаар сурвалжлахдаа сайн жишгийг дагаж эсвэл өрөвч нинжин сэтгэлээр хандаж болох ч бодитой, сайн үр дүн гаргана гэвэл **редакцын цогц бодлого, үйл ажиллагаа, хөтөлбөр төлөвлөлтийн үйл явцыг** нийт байгууллага даяараа ягштал мөрдөх зайлшгүй шаардлагатай. Гарын авлагын 4 дэх хэсгийн аргачлалын хүснэгтүүдэд хоёр ч төрлийн “Хийх ажлын жагсаалт”-ыг хавсаргасан. Тэдгээрт редакцын агуулгыг илүү хүртээмжтэй, ач холбогдолтой, үнэн зөв болгох, түүнчлэн хэвлэл мэдээллийн хөтөлбөр төлөвлөлтөөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдлыг хангахын тулд редакцын багийн ашиглаж болох, хэрэгжүүлэх зарим аргыг дурдсан.

**Хүснэгт 2-ыг үзнэ үү.** Хөгжлийн бэрхшээлд ээлтэй редакцын бодлого

**Хүснэгт 3-ыг үзнэ үү.** Эрх тэгш хэвлэл мэдээллийн хөтөлбөр боловсруулах нь

### *Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст оноож буй дүр, тэднийг дүрсэлж буй байдал*

*Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй гэдэг нэг хэмжээсээр л тодорхойлж, хэвшмэл дүрээр төлөөлүүлж байна.*

Аливаа мэдээ, сурвалжилга болон контент бүтээхдээ хөгжлийн бэрхшээл бол нийгмийн зүгээс бий болгосон тодорхойлолт гэдгийг санах нь чухал. Иймд хэвлэл мэдээллийн хэрэгсэл аливаа асуудлыг сурвалжлахдаа өөр, өөр нөхцөл байдал, орчныг харгалзан үзэх хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг одоо ч гэсэн хөөрхийлөлтэй хохирогч, нийгэмд дараа бологч, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй байсан ч амжилтад хүрсэн баатар мэтээр дүрсэлдэг. Ийм хэв шинж, дүрслэл нь тухайн бие хүнийг бүрэн илэрхийлэхгүй, хөгжлийн бэрхшээлтэй байх талаар буруу ойлголтыг бусдад түгээх аюултай.

Сэтгүүл зүйн бүтээл хийхэд **дүрслэл** болон **төлөөлөл** нь салшгүй холбоотой бөгөөд юуг төлөөлж, бэлгэдэж, илэрхийлэх эсхүл мэдээ, бүтээлд дурдагдаж буй бодит хүмүүс, газар нутаг, үйл явдал, үзэл санаа, агуулгыг үзэгчид ямар байдлаар хүлээн авахыг шийддэг. Мөн бодит газар нутаг, хүмүүс, үйл явдал, үзэл санаа, агуулга хоорондын уялдаа хамаарал ямар байхыг ч тодорхойлно. Контент нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэм дэх олон дүр, мөн тэдний амьдрах, ажиллах нөхцөл байдалд нөлөөлдөг нийгэм соёлын янз бүрийн хүчин зүйлсийг тусгах ёстой.

Хэвлэл мэдээллийн хөтөлбөр дэх хөгжлийн бэрхшээлийн талаарх хэвшмэл ойлголтыг засаж сайжруулахын тулд нийгмийн олон талт байдлыг тусгаж, төрөл бүрийн

контентыг янз бүрийн хэрэглэгчдийн бүлгүүдэд нийлүүлэх ёстой. Хүмүүсийг ялгаварлан гадуурхаж, сөргөөр нөлөөлдөг, аль эсвэл бүр эсрэгээрээ тэдний чадавхжуулж буй тогтолцоо, янз бүрийн хэв дадлын давхцалыг **харилцан огтлолцол** гэх нэр томьёогоор төлөөлүүлэн ойлгож болно.[9] Хөгжлийн бэрхшээлийн талаар мэдээлэхдээ харилцан огтлолцлыг харгалзан үзэж, хувь хүний болон нийгмийн бүлгийн янз бүрийн амьдралын хэв маягийг тусгах ёстой. Жишээ нь хөгжлийн бэрхшээлтэйн дээр өөр ямар нэг шинж байдал огтлолцвол ялгаварлан гадуурхагдах байдал нэмэгдэх тул энэ онцлог байдлыг нь эерүүлэн ашиглаж бусад төрлийн хэвшмэл ойлголтуудыг хамтатган хөндөх боломжтой. Жишээ нь жендэрийн хэвшмэл ойлголт. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ч мөн адил жендэрийн хэвшмэл ойлголтод өртөж байгаа энэ огтлолцлыг үл тоовол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хэт энгийнээр дүрсэлсэн болохоос гадна тэднийг хүрээлэн буй бусад асуудлыг ч орхигдуулсан болно. Нэг ёсондоо хэвлэл мэдээллийн контент бодит байдлаас хол зөрж, хэрэглэгчдэдээ хамааралгүй, зохисгүй болно гэсэн үг.

Хүний эрхэд суурилсан хандлагыг хэрэгжүүлсэн бүтээлүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрсдөө шийдвэр гаргадаг, эрхээ эдлэх, оролцох, нийгмийн баялагт хувь нэмрээ оруулах эрх мэдэлтэй **идэвхтэй иргэд** гэж харуулдаг. Ийм хандлага нь **ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш эрх, иргэншлийн тухай ойлголт**уудыг өөртөө шингээсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн зорилтот хэрэглэгчдийн нэг хэсэг байх нь зүй бөгөөд тэд хэвлэл мэдээллийн бүтээл, үйлчилгээг **худалдан авах** чадамжтай хүмүүс мөн. Гэсэн хэдий ч ийм хандлага нь нийгмийн тэгш бус байдлыг бүрэн шийдэж чадахгүй, учир нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн худалдан авах чадвар, нөөц, зах зээлийн нөхцөл байдал зэргээс шалтгаалан эрэлт, нийлүүлэлтийн хууль үйлчилж, хэвлэл мэдээллийн контент болон үйлчилгээ хүртээмж багатай байгаатай холбоотой.

Харин хэвлэл мэдээлэлд дижитал технологи нэвтэрснээр тусгай, нэмэлт хэрэглүүрүүд болон **хиймэл оюун ухаанд суурилсан шийдлүүдийг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй** хүмүүс дижитал форматтай бүтээл, үйлчилгээ хүлээн авах, түгээх, боломж нэмэгдсэн. (Будүүвч зураг 3-ыг үзнэ үү)

### Будүүвч зураг 3. Хөгжлийн бэрхшээлийг хөтөлбөрт хэвшүүлэх

Нийгэм дэх олон талт байдлыг тусгаж, энгийн болон тусгай үзэгчдийг багтаасан олон төрлийн хөтөлбөрүүдийг санал болгосноор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийтлэг ойлголтыг дараах байдлаар хэвшүүлэн сайжруулж болно:

| | | |
|---|---|---|
| | **Төрөл, жанрын олон янз байдал** | Хөгжлийн бэрхшээлийн асуудлыг мэдээ, мэдээлэл, боловсрол, соёл урлаг, спорт, цэнгээнт нэвтрүүлэг, баримтат кино, кино, ток шоу зэрэг төрлүүдэд, мөн сэтгүүл зүйн эрэн сурвалжлах, шинжлэх ухааны, спортын болон бусад төрлүүдээр гаргаж болно. |
| | **Үзэгчдийн олон янз байдал** | Нийгмийн янз бүрийн бүлгийн гишүүд, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нас, хүйс, бичиг үсэг, ажил мэргэжил, байршил эсвэл бусад ангиллын (жишээлбэл, эцэг эх, залуучууд, эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэх мэт) өөр өөр хэрэгцээ, асуудлыг таньж мэдэх. |
| | **Сэдвийн олон янз байдал** | Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ашиг сонирхол болон тэдэнд тулгамдаад буй асуудлыг цогцоор нь тусган олон нийтийн хэлэлцүүлэгт хамруулах (жишээлбэл, улс төр ба сонгууль, бизнес, чөлөөт цаг, хүртээмжтэй аялал жуулчлалын өсөлт, нийгмийн шинэчлэл ба хотуудын хүртээмж, уур амьсгалын өөрчлөлт, ногоон эдийн засаг гэх мэт). |

### Бүдүүвч зураг 4. Үнэлэх хүчин зүйлүүд

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг **дүрслэх, төлөөлөх** нь **шударга, тэнцвэртэй, үнэн зөв** байгаа эсэхийг үнэлэхийн тулд дараах таван хүчин зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй бөгөөд ногоон дэвсгэр дээр юуг эрхэмлэх ёстойг, саарал дэвсгэр дээр юунаас зайлсхийхийг зааж өгсөн болно.

| | |
|---|---|
| **Мэдрэмжтэй мэдээлэх, төлөөлүүлэх** | Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүн ч бусадтай тэгш эрхтэй, мэдээлэлд суурилж шийдвэр гаргадаг идэвхтэй иргэн, олон нийтийн хэлэлцүүлгийн нэг оролцогч тал, нийгэмд баялаг бүтээгч мөн гэдгийг хүлээн зөвшөөрч буй хэлбэр. Хэвлэл мэдээлэл хөгжлийн бэрхшээлийн талаар мэдрэмжтэй мэдээлж, дэлгэцээр гаргахдаа ч эн тэнцүү хандах нь зөв. |
| **Доромжилсон, үзэн ядах үг хэллэг** | Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийтлэг бөгөөд бие даасан шинж байдлын эсрэг заналхийлсэн, ялгаварлан гадуурхсан, хүчирхийлэлд турхирсан харилцан яриа, үг хэллэг. |
| **Сөрөг дүрслэл** | Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүл, харьяа байгууллага зэргийн талаар сөрөг эсхүл хор хохиролтой тайлбар хийснээр нийгмийн харах өнцөг, зан үйл, хандлагыг тэнцвэргүй болгох, цаашлаад нийгэм дэх сөрөг хэвшлийг гааруулж, ялгаварлан гадуурхалтыг дэлгэрүүлэх. |
| **Хязгаарлагдмал эсвэл дутуу төлөөлөл** | Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдэнд тулгамдсан асуудлуудыг хэвлэл мэдээллээр гаргахдаа төлөөллийг дутуу, хангалтгүй хамруулснаар үүдэх нөхцөл. Токенизм харуулах буюу тухайн түүхийг эрх тэгш, олон ургалч мэтээр харагдуулахын тулд зүгээр л хэлбэр төдий хичээл зүтгэл гаргах. |
| **Огт хамруулахгүй байх** | Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдэнд тулгамдсан асуудлуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргахгүй байх. |

Мэдрэмжтэй, оролцоог хангасан редакцын бодлого, дадал гэдэг нь хэвлэл мэдээллээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн зөв төлөөллийг хангаж, зохих түвшний **төлөвлөлт, хяналт шинжилгээ, тайлагнах** механизмуудаар бүтцийн хүрээнд үр дүнгээ хэмжихийг хэлнэ. Хяналт шинжилгээний энэхүү механизм нь эерэг, сөрөг аль ч санал сэтгэгдэл, холбоотой гомдол, маргааныг бүртгэж, шийдвэрлэдэг байх хэрэгтэй. Мөн редакц олон талт төлөөллийг хангаснаар, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй ажилтны төлөөллийг хангаснаар тэд хөгжлийн бэрхшээлийг сөргөөр дүрсэлж, оновчгүй дүрээр илэрхийлсэн тохиолдолд түүнийг даруй таньж, үл анзаарагдам алдаа, дутагдлыг залруулахад хувь нэмрээ оруулах боломжтой юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг мэдрэмжтэй дүрсэлж, оновчтой дүрээр төлөөлүүлэхийн тулд хийж болох бас нэгэн чухал алхам бол **иргэний нийгмийн байгууллагууд**, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө ажилладаг байгууллагуудтай **зөвлөлдөх** юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч буй хандлагын саад тотгорыг өөрчлөхөд нөлөөлж болох, хүний эрх, эрх чөлөөг сурталчилсан олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулах мэдээллийн кампанит ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ тэдгээр байгууллагуудын байр суурийг сонсох нь зүйтэй.

**Хүснэгт 4-ийг үзнэ үү.** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дүрслэх нь

## Олон Улсын Стандарт, Удирдамж

- **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын** 8 дугаар зүйлийн 2 (с) хэсэгт "бүх төрлийн хэвлэл мэдээллийн байгууллага энэхүү конвенцын зорилгод нийцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дүрслэн харуулах” гэж заасан байдаг. Энэ зүйл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхэд голлон анхаарсан байна. Мөн хүртээмжтэй байдлын тухай 9 дүгээр зүйл, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай 21 дүгээр зүйл, улс төр, нийгмийн амьдралд оролцох тухай 29 дүгээр зүйл зэрэг бусад зүйлтэй холбоотой. Норматив баримт бичиг нь түүнийг соёрхон баталсан оролцогч улс орнуудад ойлголтыг нэмэгдүүлэх, хэвшмэл ойлголт, өрөөсгөл ойлголттой тэмцэхийн тулд "нэн даруй, үр дүнтэй, зохих арга хэмжээ" авах ёстойг ч заасан байдаг.

- 2019 онд ЮНЕСКО Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран Хятадын хэвлэл мэдээллийн ажилтнуудыг чадавхжуулах баримт бичгийг боловсруулж байв. **Тус баримт бичгийн гол зорилго нь хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарын мэргэжилтнүүдийн хөгжлийн бэрхшээл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн** олон талт байдал, тэдний нөхцөл байдлын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн. Уг шинэчилсэн хувилбарт 1) мэдээлэл, харилцаа холбоонд саадгүй хандах, мөн холбогдох зарим асуудлууд, 2) COVID-19 цар тахлаас болж хамгийн тулгамдсан асуудлууд, нийтийг хамарсан онцгой байдал болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдлын талаар хэрхэн сурвалжлах тухай гэсэн хоёр нэмэлт бүлгийг багтаалаа.[10]

- **Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хэвлэл мэдээллээр дүрслэх** удирдамж нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эерэг, хүртээмжтэй дүр төрхийг хэрхэн сурталчлах, эдийн засаг, нийгмийн бүх түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахгүй, тэгш боломжийг олгох уур амьсгалыг хэрхэн дэмжих талаар хэвлэл мэдээллийнхэнд зориулсан практик зөвлөгөөг багтаасан.[11]

- Британийн Өргөн нэвтрүүлгийн Корпорац (BBC) нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, эмзэг бүлгийг хамгаалах, тэдний харагдах байдал, төлөөллийг нэмэгдүүлэх, мөн тэдэнд өндөр чанартай үйлчилгээ үзүүлэхийн чухлыг ухамсарлаж, холбогдох **Редакцын стандарт, удирдамжийг** боловсруулжээ. Үүгээрээ BBC бүх үзэгчдийн оролцоог хангасан, хүртээмжтэй байж, бүх бүтээлээ "хамгийн боломжийн нөхцөл"-өөр түгээх хүчин чармайлт гаргаж буйгаа харуулжээ.[12]

- Al Jazeera Media Network нь мэдээ, цаг үеийн үйл явдал, нэвтрүүлгүүдэд хамгийн өндөр стандартыг хадгалахын тулд **редакцадаа хэд хэдэн удирдамж** нэвтрүүлсэн. Баримт бичгийн 9.2-т хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэгш хамруулан сурвалжлах, зохих нэр томьёо ашиглах, норматив арга хэрэгслүүдийг хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ярилцлага хийх практик мэдээллийг агуулжээ.

- Viacom/CBS-ийн дэлхийн 15 орны 13-49 насны 15,000 гаруй хүнээс цуглуулсан мэдээлэлд үндэслэн **"Дэлхийн үзэгчид дэлгэцэн дээр илүү оновчтой төлөөлөлтэй байхыг хүсэж байна"** гэсэн судалгаа хийхэд кино урлаг болон өргөн нэвтрүүлэгт бүх бүлэг, онцлог хүмүүсийн төлөөллийг хангасан байх нь зөв гэх дүгнэлт гарсан байна. Уг судалгаа нь арьс өнгө, үндэс угсаа, хүйсийн баримжаа илэрхийлэл, бэлгийн чиг хандлага, хөгжлийн бэрхшээл гэх мэт олон талт байдлыг хамруулан судалжээ. нь арьс өнгө, үндэс угсаа, хүйсийн баримжаа илэрхийлэл, бэлгийн чиг хандлага, хөгжлийн бэрхшээл гэх мэт олон талт байдлыг хамруулан судалжээ.[13]

### *Хэвлэл мэдээлэл дэх жендерийн болон хөгжлийн бэрхшээлийн тэгш байдал*

*Хөгжлийн бэрхшээл гэдэг хүний туулсан туршлагыг илтгэж болох нэг хэмжигдэхүүн хэдий ч хүнийг бүхлээр нь тодорхойлоход хангалтгүй. Жендер бол нийгмийн зарим гишүүдэд байдаг, заримд нь байдаггүй эрх мэдэл, давуу эрх, боломжийг тодорхойлох гол түлхүүр юм.*

Хамтын нийгэмд бий болсон ойлголт, биологийн үндсэн өгөгдөл болохын хувьд жендэр нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн биеэ авч явах байдал, тэднийг бусад хүмүүс хэрхэн хүлээн авч үнэлэх, тэдний гүйцэтгэх үүрэг, илүүд үздэг боломж зэрэг нь юу байх вэ гэдэгт нөлөө үзүүлнэ. Арьс өнгө, үндэс угсаа, соёл, хэл зэрэг нийгэм соёлын бусад хүчин зүйлсээс шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс боловсрол эзэмших, ажил мэргэжилтэй байх, хаана аж төрөх зэрэг янз бүрийн нөхцөлд олон саад бэрхшээлтэй тулгардаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийтлэг олон сорилттой тулгардаг ч хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд нийгэм соёлын оноосон үүрэг, жендэрийн хандлагын улмаас эрэгтэй хүмүүстэй харьцуулахад ялгаварлан гадуурхалт, үл хайхрагдах, хүчирхийлэл, зүй бус харьцах, үл хүндлэх зэрэг гутаан доромжлолын олон хэлбэрт өртөх магадлал өндөр байдаг.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр эмэгтэйчүүдийн **оролцоо, хүртээмж, төлөөллийн** түвшин бага нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг зүй бусаар дүрслэн харуулж, хэвшмэл ойлголтыг дэвэргэх, золиос болгох, бэлгийн объект болгох, эсхүл боловсрол, мэргэжлийн талбарт өрсөлдөх чадвартай, хөдөлмөрийн тэгш боломж, нөхцөлөөр хангагдсан гэж үзэлгүйгээр зүгээр л урам зориг төрүүлэх зорилготой дүр оноох эрсдэл өндөр. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хөгжлийн бэрхшээлийн талаар сурвалжлахдаа хөгжлийн бэрхшээлтэй залуус, хөвгүүдийн нийгэмд гүйцэтгэж буй үүрэг, биеэ авч явах байдал, хүлээлт зэргийг дүрслэхдээ "эршүүд" зан чанар, шинж байдлыг хэр хэмжээнд харуулах вэ гэдэг дээр мэдрэмжтэй байх нь зөв. Эс бөгөөс мөн л хэвшмэл ойлголтыг нийгэмд түгээх эрсдэлтэй. Үнэн зөв, тэнцвэртэй, мэдрэмжтэй, оролцоог хангасан сурвалжилгууд, төлөөллийг оновчтой хангасан өгүүлэмж бэлтгэх тохиолдолд янз бүрийн үндэс угсаатай хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд, хөвгүүд, залуусын туршлага, хэрэгцээг харгалзан тунгаах хэрэгтэй. Нийтлэг эсхүл онцлог шинж байдал, нийгэм соёлын янз бүрийн хүчин зүйлийн нөлөөтэйгөөр ялгаварлан гадуурхал, бүлгийн гадна үлдэх зэрэг янз бүрийн сөрөг үзэгдлийг туулж буйг нь ч бодолцож үзээрэй.

**Жендэрийн нийтлэг хандлаг**а нь өмнө дурдсан хүний эрхэд суурилсан хандлагын нэг хэсэг. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр жендэрийн гол үзэл баримтлалыг сурталчилж, жендэрийн тэгш байдлыг хангахдаа хоёр арга замыг ашиглаж болно:

- хэвлэл мэдээллийн байгууллагын мэргэжилтнүүдэд **жендэрийн мэдрэмжтэй мэдээлэхийн** ач холбогдлыг таниулах,
- зөвхөн ажлын байранд төдийгүй үндэсний хэмжээнд **жендэрийн хэвшмэл ойлголтыг халах** үйл ажиллагааг хөхиүлэн дэмжсэн бодлого, дадлыг нэвтрүүлэх.

Жендэрийн мэдрэмжтэй мэдээлэх болон жендэрийн хэвшмэл ойлголтыг халах аль ч төрлийн оролдлого байснаас үл хамааран жендэрийн тэгш байдлыг редакцын бодлогод тусгах шаардлагатайгаас гадна бүтээл, түүхүүдээ бусад хүчин зүйлстэй **огтлолцуулан** (жендер, арьс өнгө, гарал угсаа, нас, бэлгийн чиг баримжаа, анги давхарга, ур чадвар, соёл, шашин шүтлэг, статус) нарийн мэдрэмжтэй бэлтгэх нь чухал.

Гарын авлагын 1 дүгээр хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар сурвалжлахдаа  жендэрийн мэдрэмжтэй мэдээлэх тухай хөндсөн бол, жендэрийн хэвшмэл ойлголтыг халах тухай агуулгыг 3 дугаар бүлэгт дурдлаа.

**Жендэрийн мэдрэмжтэй мэдээлнэ** гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг шударгаар, тэгш дүрсэлж, контент үйлдвэрлэлдээ жендэрийн мэдрэмжтэй хандах тухай ойлголт. Жендэрийн мэдрэмжтэй мэдээлэх гэдэг нь сэтгүүл зүйн үнэн бодит, тэнцвэртэй, шударга байх зарчмуудын л адил гол зарчим юм.[14]

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай илүү цогц дүр зургийг дараах хэлбэрүүдээр гаргаж болно:

- Мэдээ, цаг үеийн мэдээгээр (өдөр тутмын мэдээ).

- Сурвалжилгын төрлүүд (газар дээрээс нь сурвалжлах, тоймлох, анализ хийх, ярилцлага хийх, баримтат сурвалжилга).
- Тусгай дугааруудаар (хадаас материал эсхүл тухайлсан сэдвийн нэвтрүүлэг, сурвалжилга).
- Охид, эмэгтэйчүүдийн үзэл бодлыг дамжуулах, ингэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ч оролцуулах.

Орчин цагт жендэрийн мэдрэмжтэй мэдээлэх байдлыг хангуулах олон төрлийн хэрэглүүр, үнэлгээний аргачлал, дадлууд бий болжээ. Тэдгээрийн дунд хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн талаар сурвалжлахдаа ашиглаж болох нийтлэг зарчмууд байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг гарын авлагын 4 дүгээр бүлэг дэх аргачлалын хүснэгтүүдээс аваарай.

Хэдийгээр хөгжлийн бэрхшээлд ээлтэй үг хэллэгүүдийн тухай дор дэлгэрүүлэх боловч дүр, дүрслэл дэх жендэрийн тэгш байдлын дийлэнх нь **үг хэллэгийн сонголт**оос хамааралтайг онцолъё. Олон хэлэнд хүйсийн ялгаатай төлөөний үгийг ашигладаг ч хөгжлийн бэрхшээлийн талаарх илэрхийлэл, өгүүлбэрт анхаарал хандуулаад зогсохгүй жендэрийн мэдрэмжтэй үг хэлийг ашиглах нь тухайн бүлгийг гадуурхагдахаас сэргийлэх ач холбогдолтой.

**Хүснэгт 5-ыг үзнэ үү.** Хөгжлийн бэрхшээлийг сурвалжлахдаа жендэрийн оролцоог хангах нь

## Жендэрийн тэгш байдалд зориулсан гарын авлага ба хэрэгслүүд

- НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагын **“Давхардсан ялгаварлан гадуурхалтын эсрэг удирдамж, хэрэгслүүд”** нь нийгмийн тогтолцооны хүрээнд асуудалтай цогцоор нь тэмцэж чадахгүй байгаа байдал болон хүний эрх хамгаалалд саад хийж, үгүйсгэж болзошгүй өвөрмөц асуудлуудын талаар дурдсан байдаг. Уг эх сурвалжид хөгжлийн бэрхшээлд суурилсан ялгаварлан гадуурхалт болон бусад бүх төрлийн нийлмэл болон давхардсан ялгаварлан гадуурхах асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх хөтөлбөр, бодлого боловсруулах хэрэгцээ бий гэдгийг сануулжээ.[15]
- ЮНЕСКО-гийн **"Эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийн талаар мэдээлэх нь. Сэтгүүлчдэд зориулсан гарын авлага"** нь охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй, тэднийг урт хугацаандаа эмгэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй болоход хүргэж буй хүчирхийллийн янз бүрийн хэлбэрийг мэдээлэхэд нь хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Энэхүү баримт бичиг нь[16] мэдээ, сурвалжилгын чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж, жишиг үзүүлэлт, эх сурвалжуудыг агуулсан бөгөөд НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тунхаглалыг (1993) хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг.
- ЮНЕСКО-гийн **"Хэвлэл мэдээллийн жендэрийн мэдрэмжийн үзүүлэлтүүд"** (GSIM) нь хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа, контент дахь жендэрийн мэдрэмжийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг цогцоор нь тодорхойлжээ. Мөн хэвлэл мэдээлэл дэх нийгмийн олон талт байдлын үзүүлэлтүүдээс тэгш байдал, жендэрийн хэмжигдэхүүнүүдэд түлхүү төвлөрч, эмэгтэйчүүдийн чадавх болон хэвлэл мэдээллийн хөгжил хоорондоо хаана огтлолцож буйг гаргасан байна.[17]
- ЮНЕСКО болон НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагын **“Чухал сэдэв. Хэвлэл мэдээлэл дэх болон түүгээр дамжуулан үйлдэгдэж буй эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг шийдвэрлэх гарын авлага”** нь хэвлэл мэдээлэл дэх жендэрийн дүрслэлийг харуулахаас гадна хэвлэл мэдээллийн байгууллагуудыг таатай орчинг бэхжүүлэх, институцийн эерэг хандлагыг сурталчлах, нийгмийн хэм хэмжээг өөрчлөхөд хэвлэл мэдээллийнхэнтэй хамтран ажиллахыг уриалах зорилготой.[18]

- 2019 онд Нигерийн Үндэсний сонгуулийн бие даасан хорооноос гадуурхагдсан хүн ам, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн санал бодлыг тусгах замаар ардчилсан үйл явцыг сурталчлах **Ёс зүйн дүрмийг** сэтгүүлчдэд зориулан гаргасан. Тус дүрэмд мөн хэвлэл мэдээллээр "хөгжлийн бэрхшээл, арьс өнгө, үндэс угсаа, ургийн овог, хүйс, итгэл үнэмшлээр нь хувь хүн эсвэл бүлгийг гутаан доромжилсон редакцын байр суурь, үзэл бодлыг нийтлэх, цацахаас зайлсхийхийг" тунхагласан байна.
- Жендэрийн тэгш байдлыг нэвтрүүлж, нийтлэг мөрдөж буй газрууд олон байна. Жендэрийн тэгш байдлын удирдамжуудад, жишээ нь **НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Жендэрийн хариуцлагатай мэдээллийн арван зарчимд** хүн бүрийг жендэрийн мэдрэмжтэй харилцах чадварт суралцаж, өдөр тутамдаа ашиглахыг уриалсан байдаг.[19]
- Онлайн мэдээний холбооны (ONA) **Мэдээллийн эрх тэгш байдлын өгөгдлийн баазад** (2023)[20] сэтгүүл зүйд аль эртнээс л төлөөлөл нь хангагдаагүй, эсвэл ташаа дүрээр төлөөлүүлсээр ирсэн хүмүүст хэрхэн хүрч ажиллах, харилцах зэрэг агуулгыг хэвлэл мэдээллийн салбарын мэргэжилтнүүдэд зориулан бэлтгэжээ. Энэхүү өгөгдлийн баазаар дамжуулан сэтгүүлч, редакторууд мэдээллийн хүртээмжийн цоорхойг олж илрүүлэх, олон нийтийн итгэлийг олж авах, хэрэглэгчидтэйгээ эргэх холбоотой байж асуудлыг тодорхойлон редакцын удирдлагууддаа мэдэгдэх зэрэг редакцын эрэн сурвалжлах үйл ажиллагаанд ач холбогдолтой агуулгыг тусгасан байна.

## *Хөгжлийн бэрхшээлд ээлтэй үг хэллэг*

*Хөгжлийн бэрхшээлийн талаар бичнэ гэдэг ярвигтай. Учир нь ямар үг хэллэг зохимжтой гэдэг дээр одоог хүртэл нийтээрээ бүрэн зөвшилцөлд хүрээгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөр хоорондоо ч ямар нэр томьёо, өгүүлбэрийг ашиглах дээр хурцаар маргах нь бий.*

**Хөгжлийн бэрхшээлийн тухай үг хэллэгүүд бусад үг хэллэгийн адил хувьсан өөрчлөгдсөөр байна.** Хэдхэн жилийн өмнө нийтээрээ хүлээн зөвшөөрдөг байсан зарим үг, нэр томьёог одоо нийтээрээ доромжилсон гэж үзэх ч болсон. Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц зэрэг олон улсын хэм хэмжээний баримт бичигтэй уялдуулан тухайн нөхцөл байдалд тохирсон нэр томьёо ашиглах нь нэн чухал юм. Сэтгүүлчдийн хувьд олон нийт, хүлээн авагчдадаа ойлгомжтой үг хэллэг ашиглах нь бас нэгэн тулгамдсан асуудал болоод байна.

Мэдээнд хөгжлийн бэрхшээлийн талаар ээлтэй үг хэллэг ашиглахдаа зөвхөн хөгжлийн бэрхшээлийн талаарх нэр томьёонуудаас гадна бусад төрлийн ялгаварлан гадуурхалд өртөж буй хүмүүсийн тухай мэдээлэхэд ашигладаг үг хэллэгийг ч харгалзан хослуулан хэрэглэх ёстой. Аливаа үг хэллэг нь ямар нэг онцгой нөхцөл байдалд буй, ялгаатай хүмүүсийн эсрэг **түүхийн турш оршсоор ирсэн хэвшмэл ойлголт, өрөөсгөл хандлагыг** түгээх хэрэгсэл болж, цаашилбал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар сөрөг ойлголтыг нийгэмд түгээж болзошгүй. Үүний нэгэн адил хэвлэл мэдээллээр дурдаж буй нэр томьёонууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар хортой, хөнөөлтэй төсөөллийг олон нийтэд урьдчилан түгээх аюултай.

Хоцрогдсон, бараг нийтээрээ доромжилсон гэж үздэг зарим нэр томьёоноос зайлсхийх хэрэгтэй. Хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд холбогдох байгууллагаас гаргасан **хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай үг хэллэгийн гарын авлагыг** ашиглавал зохино. Ярилцлага өгч буй хүмүүст ч санамсаргүй байдлаар өөрийгөө ялгаварлан гадуурхалд өртөхөд хүргэж болзошгүй сөрөг нэр томьёо бий гэдгийг урьдчилан сануулаарай. Редакцуудын хувьд хүлээн авагч, олон нийт нь хэл ярианы олон янзын аялга, хэв маягтай байдгийг харгалзаж нарийн, төвөгтэй сэдвүүдийн хүрээнд ашиглахХөгжлийн бэрхшээлд ээлтэй үг хэллэг боловсруулж болно.

Сэтгүүлчид бэлтгэж байгаа мэдээнийхээ гол зочин, эх сурвалжаас өөрсдийг нь болон хөгжлийн бэрхшээлийг нь юу гэж тодорхойлбол зохистой талаар лавлан нягталж, зөв хувилбар санал болгохыг асууж болно. Жишээлбэл, зарим хүн дүлий гэж хэлүүлэх нь зүгээр гэж үздэг бол зарим нь сонсголгүй эсвэл сонсголын бэрхшээлтэй

хүн гэж хэлүүлэхийг илүүд үздэг. Орчуулгын контентод дохионы хэл ашиглахдаа таны контент олон улсын үзэгчдэд зориулагдаагүй л бол үзэгчдийнхээ  унаган хэлийг (үндэсний хэлийг) нэн тэргүүнд тавих нь зүйтэй.

Зарим хэлээрх хөгжлийн бэрхшээлийн тухай үг хэллэгийн тайлбар толь маш дэлгэрэнгүй байдаг бол тэдгээрийг орчуулгын төхөөрөмж, хэрэгсэл (Жишээ нь: хиймэл оюунд суурилсан орчуулгын программ) ашиглан хөрвүүлэхэд хүндрэл учирч болзошгүй. Иймд аливаа **үг хэллэг, мэдээний түүхийг ховор ашиглагддаг хэлнүүд рүү орчуулах** тохиолдолд онцгой анхааралтай байх ёстой. Жишээ нь ховордож буй хэлээр ярьдаг хүмүүс аливаа нэр томьёог өөрсдийн нийгэм соёл болон хэл зүйд нийцүүлэн тохируулж, эсхүл хэл шинжлэлийн мэргэжилтнүүд, тэдний хүрээллээр баталгаажуулж ашиглах тохиолдол байдаг. Нийтлэг байдлаар ашигладаг хөгжлийн бэрхшээл, согог зэрэг үгнүүд нь зарим ховор хэл, соёлд тэс ондоо утга, агуулгыг илэрхийлж, тэдний хандлага, ертөнцийг үзэх үзэл, уламжлалт итгэл үнэмшил, зан үйлд ч харшлах магадлалтай.

Гарын авлагын 4-р хэсгийн 6, 7-р хүснэгтэд мэдээний үг хэллэгийг сонгохдоо анхаарах зүйлсийн талаар, зайлсхийх ёстой болон санал болгож буй хувилбарууд, ашиглах ёстой үг, нэр томьёо, хэллэгийн жагсаалтыг багтаасан болно. Хамгийн гол нь тухайн нөхцөл байдал, зорилгод хамгийн тохиромжтой хэлийг сонгох нь чухал. Гарын авлагын төгсгөлд өгсөн тайлбар толь бичгийг лавлагаа болгон ашиглах боломжтой.

Хөгжлийн бэрхшээлийн талаарх нэр томьёо өөрчлөгдсөөр байгаа тул үг ярианы сонголт нь үндэсний онцлог, хувь хүн, байгууллагын байр сууриас хамаарна. Жишээлбэл, эрүүл мэндийн асуудлаар мэдээлэх нь анагаах ухааны нэр томьёог ашиглахыг шаарддаг, эсвэл зарим нэр томьёо нь соёлын хувьд хүлээн зөвшөөрөгдөхгүй буюу ялангуяа нийгэм, хүний эрхийн асуудалтай холбоотой мэдээллийн хүрээнд төөрөгдөл үүсгэж болзошгүй.

**Хүснэгт 6 үзнэ үү.** Үг хэллэгийг сонгохдоо анхаарах гол зүйлс

**Хүснэгт 7 үзнэ үү.** Нэр томьёо, үг хэллэгүүдийн жагсаалт

## Хөгжлийн бэрхшээлд ээлтэй үг хэллэгийн удирдамж

- **НҮБ-ын Тэгш хамруулсан мэдээлэл харилцааны удирдамж: ”Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй эсвэл түүний тухай ярихдаа баримтлах зөвлөмж”**-өөр НҮБ-ын ажилтнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй хэрхэн харилцах тухай практик зөвлөмжийг тусгасан.[21] 2019 онд батлсан НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах стратегийн зарим асуудлуудын нэг хэсэг болсон, уншихад хялбар энэхүү баримт бичиг нь гол нэр томьёог тайлбарлаж, зөрэг түүхийг толилуулж, онлайн орчинд буй хүртээмжтэй мэдээллүүдийн сайн жишгүүдийг дурджээ.
- НҮБ-ын Женев дэх төлөөлөгчийн газар нь **хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэгш хамруулсан нэр томьёо**нуудыг ангилж, ашиглавал зохих, ашиглахаас зайлсхийх үг хэллэгийг тодруулсан энэхүү удирдамждаа суурилан, хэээд сөхөж үзэх боломжтой цахим зааварчилгаа бүтээсэн байдаг.[22]
- Аризона мужийн Их сургуулийн Хөгжлийн бэрхшээл ба Сэтгүүл зүйн үндэсний төвөөс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар сурвалжилж, бичиж буй сэтгүүлч, мэргэжилтнүүдэд зориулан англи, испани хэлээр **хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай үг хэллэгийн гарын авлагын** шинэчилсэн хувилбарыг гаргажээ. Энэхүү гарын авлага нь "хөдөлмөрийн чадвартай"-аас "тэргэнцэртэй" хүртэлх түгээмэл хэрэглэгддэг 100 орчим үг, нэр томьёоны талаар мэдээлэл, зөвлөгөө багтаасан.[23]

## Хөгжлийн бэрхшээлд ээлтэй үг хэллэгийг орчуулах нь

- Шинэ Зеландын Сэтгэцийн эрүүл мэндийн судалгаа, мэдээлэл, ажиллах хүчний хөгжлийн Үндэсний төвөөс Маоригийн соёлд чухал үүрэг гүйцэтгэдэг 200 гаруй whakataukī гэх зүйр цэцэн үг, бусад маори үг, нэр томьёог багтаасан **“Тэ Рео Хапай – Баяжуулсан хэл”** номыг хэвлүүлсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг Те Рео Маори хэл рүү орчуулсан бөгөөд энэ хүчин чармайлт нь хөгжлийн бэрхшээл, хөгжлийн бэрхшээлийн талаарх уугуул иргэдийн ертөнцийг үзэх үзэлтэй нийцэж, улс төрийн оролцоо нь утга учиртай байх боломжтойг харуулжээ.[24]
- Сонсголын бэрхшээлтэй хүмүүс дотор өөрийгөө дүлий, сонсголоо алдсан, сонсголгүй, сонсгол муутай, хожуу дүлийрсэн зэрэг янз бүрийн байдлаар тодорхойлох хүн бий. Хүн харилцан адилгүй шалтгааны улмаас сонсголын бэрхшээлтэй болж болох бөгөөд сонсголын түвшин, сонсголоо алдсан нас, боловсролын зэрэг, харилцаа холбооны арга, түүнийгээ илэрхийлэх соёлын хэв шинжийн хувьд ч адилгүй байна. Хүмүүс өөрсдийгөө юу гэж тодорхойлох нь хувь хүний өөрийн мэдэх хэрэг бөгөөд сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн нийтлэг шинж, сонсголын түвшин, сонсголоо алдсан нас зэргээс хамааран янз бүр. АНУ-ын Сонсголгүй хүмүүсийн нэгдсэн холбоо нь нийтлэг тулгардаг харилцаа холбоо болон соёлын чанартай асуултуудад хариулт өгсөн байх ба ингэхдээ ямар үг хэллэг, нэр томьёо ашиглах тухай ч зөвлөсөн байна. Тухайн хүнийг юу гэж дуудахаа мэдэхгүй байвал зүгээр л өөрөөс нь асууж заншаарай.[25]

### *Сөрөг контентын зохицуулалт*

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 8 дугаар зүйлд оролцогч бүх улс орнууд бүх төрлийн **хэвлэл мэдээллийн хэрэгслээр конвенцын зорилгод нийцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дүрслэн харуулахыг шаарддаг.** Ялгаварлан гадуурхалтыг хориглох нь хүний эрхийг хамгаалах үндэс суурь бөгөөд хүний эрхийн талаарх олон улсын бүх баримт бичигт дурдсан байдаг.

Хэвлэл мэдээлэл бол нээлттэй, чөлөөт яриа хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнүүлэх үндсэн талбар юм. Ингэснээр **олон талт үзэл, хандлагын дуу хоолой** болохын зэрэгцээ хүмүүсийн оршихуй, өөрсдийгөө илэрхийлэхүй төдийгүй дэлхий ертөнц, соёл хоорондын олон янз байдал, тэдгээрийг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэхийн үнэ цэнийг түгээн дэлгэрүүлдэг. Гэсэн хэдий ч хэвлэл мэдээлэл, тэр дундаа нийгмийн мэдээллийн сүлжээ нь хэт туйлширсан үзэл, хүлцэшгүй үзэл суртал, үзэн ядах үг хэллэг зэргийг цахим болон цахим бус хэлбэрээр түгээх гол цэг болох эрсдэл ч байна.

**Хэвлэл мэдээллийн удирдлага**, зохицуулалт, шийдвэр гаргах түвшний алба нь Засгийн газар болон бизнесээс хараат бус, бие даасан байснаар өргөн нэвтрүүлэг болон дижитал сувгаар түгээж буй контент нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүндэтгэлтэй хандаж, тэдний эрх ашигт үйлчилж чадна. Түүнчлэн шүүх, эрх зүйн систем нь хэвлэл мэдээлэл, зар сурталчилгааны нийтлэг стандартад халдахгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ашиг, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалж, үзэн ядах үг хэллэгийг таслан зогсоох хууль, дүрэм журмуудыг хэрэгжүүлдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг хэт туйлширсан хэллэгийг хязгаарлах нийтлэг үндэслэлүүдийн нэг бол хөгжлийн бэрхшээлтэй хүнд учирч болох **сэтгэл зүйн болон бие махбодын гэмтэл** бөгөөд үүнийг үзэн ядах гэмт хэрэг гэж нэрлэдэг. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ялгаварлан гадуурхлаас ангид үг хэллэг хэрэглэж, **үл тэвчсэн болон хүчирхийллийг өдөөж** болзошгүй контентыг түгээхээс зайлсхийх хэрэгтэй. **Хүйс, арьс өнгө, бэлгийн чиг баримжаа, үндэс угсаа, нас болон бусад шинж чанараар нь ялгаварлан гадуурхах**, үл хүлцэх, ялгаварлан гадуурхахад хүргэж болзошгүй хөгжлийн бэрхшээлтэй давхардсан бусад асуудлыг мөн авч үзэх хэрэгтэй.

Хэт туйлширсан, үзэн ядах үг хэллэгтэй тэмцэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс улс төр, соёл, нийгэм, эдийн засгийн амьдралд оролцох боломж хязгаарлагдмал, саад бэрхшээлтэй байж болохыг харгалзан үзэж хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь **яриа, хэлэлцүүлгийн нээлттэй орон зай** бий

болгож, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзэл бодол, байр сууриа илэрхийлэх индэр нь болох хэрэгтэй. Хэвлэл мэдээлэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нэр төр, хувийн нууц, ёс суртахууны болон нийгэм соёлын бусад асуудлыг харгалзан нийгэмд **шударга мэдээ мэдээлэл, санаа түгээх** үүрэгтэй. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм, улс төр, соёлын амьдралд оролцох тэгш нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хэвлэл мэдээллийн үйлчилгээ, контент нь **түгээмэл хүртээмжтэй** байдлыг хангах ёстой. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс **оновчгүй төлөөлөл, хуурамч мэдээллийн бай болсон тохиолдолд хариу арга хэмжээ авах боломж** бүрдэнэ. Энэ нь ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс **хэвлэл мэдээллээр үзэгдэх төлөөлөл хангагдаагүй, эсвэл бүр хэвлэл мэдээллийн хөтөлбөрийн агуулгад дурдагддаггүй**, түүнчлэн **контент үйлчилгээг хүртээмжтэй, бүх нийтийн, зорилтот бүлгүүдэд** нээлттэй болгох техникийн стандартыг бүрэн хангаагүй эсвэл дагаж мөрдөөгүй зэргээс шалтгаалан хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тэгш хандах боломжгүй байдаг тул энэ нь онцгой ач холбогдолтой юм.

Хэт туйлширсан болон **үзэн ядах үг хэллэгийг хэмжих, хянах хэд хэдэн арга хэрэгсэл, техник** байдаг бөгөөд эдгээр нь тухайн нөхцөл байдал, оролцогчид болон платформоос хамаарч өөр өөр байж болох ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхах үзлийг энгийн болон цахим орчинд эсэргүүцэхэд тустай.

Мөн улс орнууд өргөн нэвтрүүлгийн хуулиараа өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний цар хүрээ, зохицуулалтыг тодорхойлж, телевизийн хөтөлбөр болон зар сурталчилгаанд тодорхой шаардлагуудыг тусгасан байдаг. Эдгээр дүрэм нь олон улсын хууль эрх зүйн баримт бичиг, зарчимд тулгуурласан байдаг бөгөөд **хэвлэл мэдээллийн байгууллагуудад өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын заалтуудыг зөрчсөн гэх гомдол ирсэн тохиолдолд зөрчлийг яаралтай залруулахад чиглэжээ.** Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд гарсан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг хэт даврагч болон үзэн ядах үг хэллэгийг анхааралтай хянаж, зохицуулалт, удирдамжийг шаардлагатай үед шинэчилж байх ёстой бөгөөд аналог, хиймэл дагуул эсвэл дижитал хэлбэрээр дамжуулж буй өргөн нэвтрүүлгийн аль ч хүрээнд үзэгчдийн санал, шүүмжлэлийг авч үзэх нь чухал юм.

**Хүснэгт 8 үзнэ үү.** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг хэт туйлширсан болон үзэн ядах үг хэллэгийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зарим аргачлалууд

**Хүснэгт 9 үзнэ үү.** Гомдлын төрлүүд ба тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг хэт туйлширсан хэллэгийг хязгаарлах нийтлэг үндэслэлүүдийн нэг бол хөгжлийн бэрхшээлтэй хүнд учирч болох **сэтгэл зүйн болон бие махбодын гэмтэл** бөгөөд үүнийг үзэн ядах гэмт хэрэг гэж нэрлэдэг.

## Үзэн Ядах Үг Хэллэгийг Зохицуулсан Стандартууд

- **2021 онд ЮНЕСКО-гоос гаргасан "Олон нийтийн сүлжээн дэх үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх нь: Орчин цагийн асуудлууд"** нэртэй өгүүлэлд үзэн ядах үг хэллэгийг онлайн орчинд маш бага зардлаар бүтээж, түгээж байгааг онцолжээ. Бусад бичвэрийн төрлүүд шиг хянан тохиолдуулах шаардлагагүй, тухайн нийтлэл хэр их анхаарал татахуйц гэдгээс хамаарч янз бүрийн түвшинд хандалт цуглуулдаг: Мөн тухайн платформын сервэр эсхүл удирдлагын байр нь тухайн нийтлэлч болон зорилтот үзэгчидтэй нь нэг улс, байршилд байх шаардлагагүй тул үзэн ядах үг хэллэгийг үндэстэн дамнуулан түгээх ч боломжтой болсон. Иймд тус баримт бичигт үзэн ядах үг хэллэгийг илрүүлэх зарим хэрэгсэл, онлайн орчинд түүнээс урьдчилан сэргийлэх зөвлөмжүүдийг танилцуулсан байна.[26]

- **Фэйсбүүкийн Олон нийтийн стандарт** нь онлайн орчинд үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх практикт хамаардаг. Фэйсбүүкийг ашиглах нөхцөл, журамд хор хөнөөлтэй, заналхийлсэн эсвэл үзэн ядалтыг өдөөж, хүчирхийлэлд хүргэж болзошгүй контентыг хориглодог. Тус платформын Олон нийтийн стандартад, Фэйсбүүк нь үзэн ядах үг хэллэгийг арилгахыг зорьдог бөгөөд үүнд арьс өнгө, угсаа гарал, үндэсний гарал үүсэл, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, хүйс, хүйсийн тодорхойлолт, хөгжлийн бэрхшээл эсвэл өвчин эмгэгт нь суурилан шууд дайрсан контент багтдаг гэж тодорхой дурдсан байдаг.[27]

- Европын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Форум (EDF) **нь "Үзэн ядах үг хэллэг болон үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргийн эсрэг EDF-ийн байр суурь болон зөвлөмж"** баримт бичгийг  боловсруулсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үзэн ядах үг хэллэг болон үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргийн хохирогч болох магадлал өндөртэйг дурджээ. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд, мөн оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд илүү хамаатай бөгөөд тэд хүчирхийлэл, гэмт хэрэг, дижитал орчинд нэмэгдсээр буй хүний эрхийн зөрчлийн бай болж өртөх өндөр эрсдэлтэй байдаг.[28]

## *Хөгжлийн бэрхшээлд хамаарах асуудлуудыг эрэн сурвалжлах нь*

*Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь хөгжлийн бэрхшээлийг нийтийн эрх ашигт хамааралтай, эрэн сурвалжлах ёстой сэдэв гэж үзэх хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлийн талаар эрэн сурвалжилснаар хэвлэл мэдээллийн байгууллага нь нийгмийн шударга байдал, эгэх хариуцлагад хувь нэмрээ оруулна.*

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой асуудлууд дээр эрэн сурвалжилга хийхдээ хариуцлагатай албаны үйл ажиллагааг олон улсын, бүс нутгийн, улсын болон орон нутгийн гээд янз бүрийн түвшинд авч үзэж болох ба олон талаас нь (жишээлбэл, гэр бүлийн асуудал ба дэмжлэг, боловсролын байгууллагуудын тэгш хамруулах боловсролын шаардлагад нийцэж буй байдал, хотын захиргаа ба хүртээмжтэй хотын хөгжил эсвэл төсвийн зарцуулалт, бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжтэй дизайн гэх мэт) хөндөж болно.

Юун түрүүнд, хөгжлийн бэрхшээлийн асуудалд **хандахдаа Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенц нь олон улсын хүний эрхийн гэрээ, баримт бичгийн адил олон улс, бүс нутаг, болон үндэсний хяналт тавих бүрэлдэхүүн хэсэг, журам механизмтай** гэдгийг анхаарах нь зүйтэй.

Конвенц нь гишүүн орнуудыг хэрэгжилттэй холбоотой асуудлуудаар засгийн газрын дотор нэг буюу хэд хэдэн **эрхэлсэн нэгжтэй** байхыг шаардлага болгожээ. Түүнчлэн салбар, түвшний үйл ажиллагааг хөнгөвчлөх, засаж залруулах арга хэмжээ авах орон зайг хангах зохицуулалтын механизмыг бий болгоход зохих анхаарал хандуулдаг.

Олон улсын түвшинд **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хороо** болон **Гишүүн орнуудын бага хурал** хяналтын үйл явцад оролцдог. Хороо нь Конвенцын хэрэгжилтийг хянадаг бие даасан мэргэжилтнүүдийн байгууллага бөгөөд гишүүн орнууд Конвенцыг хүлээн авснаас хойш хоёр жилийн дотор, түүнээс хойш дөрвөн жил тутамд авсан арга хэмжээ болон гаргасан ахиц дэвшлийн талаар **хугацаат тайланг** Хорооноос гаргасан удирдамжийн дагуу өгөх үүрэгтэй.

Хэвлэл мэдээлэл нь олон нийтийн дэмжлэгийг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг олон нийтийн хэлэлцүүлэгт хамруулах замаар Конвенцын **хэрэгжилтэд хувь нэмэр оруулдаг.** Тэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрхийн эзэд гэж ойлгуулах, ялгаварлан гадуурхлаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Мөн хяналтын байгууллагын үүргийнхээ хүрээнд Конвенцын хэрэгжилтэд **авсан арга хэмжээ болон гаргасан ахицыг судалж, тайлагнадаг**.

Гарын авлагын 4-р хэсэг дэх 10-р хүснэгт нь илүү системтэй, гүнзгий судалгаа шаардсан сэтгүүл зүйн эрэн сурвалжилга хийхэд хэрэгцээтэй практик зөвлөмжүүдийг багтаасан. Үүнд илүү их нотлох баримт цуглуулах, нэмэлт баримт шалгах, тухайн асуудлыг үзэгчдэд илүү сонирхолтой болгохын тулд холбогдох өгөгдлийн шинжилгээний хэрэгслийг ашиглах зэрэг орно.

**Хүснэгт 10 үзнэ үү.** Хөгжлийн бэрхшээлтэй холбоотой асуудлуудаар эрэн сурвалжлах нь

## Хууль эрх зүйн баримт бичгүүд болон хяналтын механизм

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенц нь гишүүн орнуудыг засгийн газраас хараат бус **үндэсний хяналтын механизм** байгуулахыг шаарддаг. Энэ нь ихэвчлэн Конвенцын хэрэгжилтийг дэмжих, хамгаалах, хянах үүрэг бүхий бие даасан хүний эрхийн байгууллагын хэлбэрээр байдаг (33-р зүйл).

## Нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх

Конвенцын **8-р зүйлд** зааснаар, мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх хүрээнд гишүүн орнууд дараах зүйлсийн талаар тайлагнах ёстой:

- Нийтийн мэдээллийн кампанит ажил: Бүх нийтийг хамарсан олон нийтэд хандсан мэдээллийн кампанит ажил, боловсролын тогтолцооны хүрээнд болон уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслээр (сонин, телевиз, радио, сурталчилгааны самбар, нийтийн талбай гэх мэт) зохион байгуулагдсан үйл ажиллагаа
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон нийгмийн бусад бүлгүүдэд Конвенц болон түүний агуулсан эрхийн талаар мэдлэг, ойлголт өгөх, мэдээлэл түгээх зорилгоор хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

## Хүртээмжтэй байдал

Конвенцын **21-р зүйл нь** үзэл бодолтой байх болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл авах эрхтэй холбоотой бөгөөд гишүүн орнууд дараах зүйлсийн талаар тайлагнах үүрэгтэй:

- Хөгжлийн бэрхшээлийн төрөл бүрд тохирсон хүртээмжтэй формат болон технологийг цаг алдалгүй, нэмэлт зардалгүйгээр хангах.
- Албан ёсны харилцаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгосон дохионы хэл, брайл үсэг, нэмэлт болон орлуулах харилцаа, бусад бүх хүртээмжтэй арга, горим, форматыг ашиглах.
- Хувийн хэвшлийн байгууллагууд, ялангуяа интернэтээр дамжуулан нийтэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хүртээмжтэй, хэрэглэх боломжтой мэдээлэл, үйлчилгээний форматыг хангах.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл өгөх үйлчилгээ үзүүлдэг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд, түүний дотор интернэтээр мэдээлэл түгээдэг байгууллагуудын үйлчилгээний хүртээмжтэй байдлыг хангах.
- Дохионы хэлний хэрэглээг хүлээн зөвшөөрөх, түгээн дэлгэрүүлэх.

## Улс төр, олон нийтийн амьдралд оролцох нь

Конвенцын **9-р зүйлд** хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээлэл авах эрхийг хангах, **29-р зүйлд** улс төр болон олон нийтийн амьдралд оролцох тухай хэд хэдэн заалтуудыг тусгасан.

## Хөгжлийн бэрхшээлийг өгөгдөлд тэгш хамруулах нь

- НҮБ-ын Хүүхдийн сангийн **"Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамарсан өгөгдөл боловсруулах: Яагаад чухал вэ, хэрхэн хэрэгжүүлэх вэ?"** гарын авлага нь статистикийн үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг яагаад албан ёсны статистик мэдээлэлд хамрагдахгүй байгааг тайлбарладаг. Ялгаварлан гадуурхахтай тэмцэх, тэгш хамрагдалтыг дэмжих нь бүх салбарт анхаарах асуудал бөгөөд чанартай өгөгдөл, нотолгоонд суурилсан зөвлөмж, бодлогоор дамжуулан хэрэгжүүлж болно. Тэгш хамруулсан өгөгдөл боловсруулна гэвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өгөгдөл цуглуулах үйл явц, үр дүнд оролцуулах шаардлагатай. Ингэснээр тэдний туршлага, хэрэгцээ шаардлага нь өгөгдөл боловсруулалтаар илрэх үр дүнд зохих ёсоор тусгагдах боломжтой болно.[29]

- OHCHR: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцыг баталсан бүх гишүүн орнууд хоёр жилийн дотор, түүнээс хойш дөрвөн жил тутамд **Хороонд хугацаат тайлан илгээх** үүрэгтэй. Тайлан нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар мэдээлэл агуулсан байна. Үүний зэрэгцээ, гомдол, асуулга гаргах тусгай журам байх ба хараат бус хяналтын механизмын үйл ажиллагааг архивлаж хадгалдаг.[30]

- **Хөгжлийн бэрхшээлийн статистикийн** Вашингтон групп нь хүн амын тооллого болон үндэсний судалгаанд ашиглах боломжтой хөгжлийн бэрхшээлийн хэмжүүрүүдийг хавсаргасан эрүүл мэндийн статистикийг бэлтгэж түгээдэг. Үүний зорилго нь дэлхийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээллийг харьцуулж болохуйц байдлаар хангах явдал юм.

- Канадын Статистикийн газар нь Хөдөлмөр эрхлэлт ба Нийгмийн хөгжлийн төв (ESDC)-тэй хамтран тэгш хүртээмж болон хөгжлийн бэрхшээл, хүйс, олон талт байдал, **тэгш хамрагдалттай холбоотой статистик мэдээлэл, дүн шинжилгээг хийж засгийн газарт** өгдөг.[31]

- “Dart” төвийн **Сэтгэл Зүйд суурилсан Сэтгүүл Зүй** гарын авлага нь яаралтай, найдвартай эх сурвалж хэрэгтэй байгаа сурвалжлагч, редакторууд болон продюсеруудад зориулан боловсруулсан эмхэтгэл юм. Энэ нь хувь хүн, гэр бүл, олон нийтийн сэтгэл зүйд учирсан сэтгэл зүйн гэмтлийг мэдээлэхдээ мэдээний сонголт, хэрэглэх үг хэллэг, ёс зүйн талаар богино хугацаанд нотолгоонд суурилсан зөвлөмжүүдийг багтаасан. Мөн арьс өнгөөр ялгаварлан гадуурхал болон бэлгийн хүчирхийлэл зэрэг ноцтой, хүнд сэдвүүдийн талаар мэдээлэх үед сэтгэл зүйн болон шинжлэх ухааны холбогдох нэр томьёог зохистой ашиглах зөвлөмжүүдийг багтаасан.[32]

- Дэлхийн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сүлжээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нөлөө үзүүлж буй асуудлуудыг, тэдгээр саад тотгорыг арилгахын тулд хийж буй боловч хязгаарлагдмал үйл ажиллагаануудыг хэрхэн **сурвалжлах тухай удирдамж** бэлтгэсэн. Хамгийн гол нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг олон төрлийн ялгаварлан гадуурхалт давхацдаг нийгмийн цөөнх гэдгийг онцолж, үүний эсрэг тэмцэх талаар дурджээ.[33]

- **Европын сонсголын бэрхшээлтнүүдийн сэтгүүл зүйн сүлжээ** (DJE) нь сонсголын бэрхшээлтэй хүмүүсээр удирдуулсан хэвлэл мэдээллийн байгууллагуудын дунд хамтын ажиллагааны сүлжээ бэхжүүлэх замаар сонсголын бэрхшээлтэй чанартай, тэнцвэртэй бэрхшээлтэй иргэдийн төлөөх сэтгүүл зүйг бэхжүүлэх зорилготой. Инновац, хамтын ажиллагаа, олон талт байдал, чанартай, тэнцвэртэй байдлыг эрхэмлэсэн тус төсөл нь Европын холбооны санхүүжилттэй үйл ажиллагаа явуулж сонсголын бэрхшээлийг сурвалжлахад орхигддог асуудлуудыг тодорхойлж, мөн сонсголын бэрхшээлтэй хүмүүсээр удирдуулсан хэвлэл мэдээллийн байгууллагын санхүүгийн тогтвортой байдлыг хангахуйц бизнес загваруудыг эрэн хайж, судалдаг. Уг байгууллага нь сонсголын бэрхшээлтэй сэтгүүлчдийн мэдээ, контент бэлтгэх чадавхыг бэхжүүлж, Европ даяарх зорилтот бүлгүүдэд өөрсдийнх нь үндэсний дохионы хэлд суурилсан байдлаар түгээхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.[34]

- Үл үзэгдэгчийг ил болгох нь багийн “The Kit” нь хамтын ажиллагааг хангасан, өөрөө суралцахуйд суурилсан **эрэн сурвалжлах арга, хэрэглүүрүүдийн** цогц багц юм. Эрэн сурвалжлага хийх хүсэлтэй хүмүүс болон хамт олон туршлагатай эрэн сурвалжлагчдын мэдээлэл цуглуулах, баталгаажуулах, баримт бүрдүүлэх, ёс зүй болон аюулгүй байдлын зарчмуудаас гажилгүйгээр ажиллах тухай мэдээллийг нээлттэй байршуулсан байна.[35]

## Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс ярилцлага авч, тэдэнтэй харилцах нь

*Аливаа мэдээ, сурвалжилгыг үнэн зөв, оновчтой, бүх хэрэглэгчдэд хамааралтай байлгахын тулд хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллах, харилцах, ярилцах чадавхаа дээшлүүлэх хэрэгтэй.*

Сэтгүүлчид хүнээс хэрхэн хөгжлийн бэрхшээлийнх нь талаар асууж, тэдэнд тухтай мэдрэмж бүрдүүлж, ямар орчинд ярилцах шаардлагатайг нь тодруулахаа мэдэхгүй байж болно. Мэргэжилтнүүд ч тухайн асуудалд нийцсэн асуулт асууж чадах эсэхдээ эргэлзэж, магадгүй өөрсдөө ичгэвтэр байдалд орох, эсвэл нөгөө хүндээ таагүй мэдрэмж төрүүлэх магадлалтай. Ийм эргэлзээ байна гэдэг нь бид хөгжлийн бэрхшээлийн талаар мэдээ, сурвалжилга хангалтгүй бэлтгэж байна л гэсэн үг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ярилцахдаа хэвлэл мэдээллийн салбарт хөгжлийн бэрхшээлийн тухай мэдлэг ойлголт хангалтгүй, мөн тэдний төлөөлөл бага хангагдсан гэдгийг санах нь тустай. Ярилцлагаа эхлүүлэхийн өмнө тухайн хүн **хөгжлийн бэрхшээлийн тухай ярилцахад тухтай байгаа эсэхийг** асуух нь чухал. Хэрэв үгүй бол хүндэтгэлтэй хандаж, ярилцлагын үеэр тухайн асуудлаар илүү лавшруулж ухаад хэрэггүй. Зураглаачид хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралыг дүрсэн дээр буулгахдаа ярилцагчтай эн тэнцүү, энгийн харьцахдаа хүрээлэн буй орчны болон мэдрэхүйн анзааргатай хандах хэрэгтэй. Нэмэлт төхөөрөмж ашигладаг ярилцагч байлаа гэхэд хүнийг “хүн биш мэт” харагдуулахаас зайлсхийгээрэй. Дүрсний планд хүнийг нь оролцуулалгүйгээр тэргэнцэр дээр нь, эсвэл сонсголын төхөөрөмж дээр нь фокусалж, дүрс татах шаардлагагүй. Мөн эсрэгээрээ, хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдгийг нь илтгэх төхөөрөмжүүдийг нь хассанаа зүгээр л хүний дүрс дангаар нь ашиглах ч буруу. Хамгийн чухал нь хамт ажилладаг хөгжлийн бэрхшээлтэй мэргэжилтэн эсвэл ажилтан бий бол, эсвэл шууд ярилцагчаас лавлаж зөвлөгөө авах хэрэгтэй.

Сонсголын бэрхшээлтэй хүнтэй ярилцахдаа өөрийнх нь орны хэлээр **дохионы хэлээр** харилцах хэлмэрчтэй эсэхийг нь урьдчилж тодруулсан байх ёстой. Жишээ нь, сонсголын бэрхшээлтэй цагаач иргэн байлаа гэхэд өөрийн төрөлх хэлээрх дохионы хэлийг биш олон улсын дохионы хэлийг илүү ойлгодог байх магадлалтай.

Хэрэв та **зар сурталчилгаа** эсвэл **олон нийтийн кампанит ажил** хийдэг бол хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн төлөөллийг ялгаварлалгүй дүрслэх хэрэгтэй. Зар сурталчилгаанд (дуу бичлэг болон зураг, дуу оруулга, хүлцэнгүй гэхээс илүүтэй идэвхтэй дүр дүрслэл ашиглах, мэргэжлийн байр суурь илэрхийлэх, бие даан амьдардгийг харуулах, эсвэл эцэг, эх болж хариуцлага үүрсэн г.м) болон иргэний идэвхийн (жишээ нь сонгуульд оролцох) хүрээнд аль ч төрлийн бүтээлд хүйсийн ялгаварлалгүй төлөөллийг хангахыг үргэлж санах. Зар сурталчилгааны тухайд “хөгжлийн бэрхшээл”-ийн талаарх уламжлалт дүрслэлийг ашиглахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эрэгтэй, эмэгтэй хэн бүрийг оролцуулаарай.

Дашрамд дурдахад, өргөн нэвтрүүлгийг зохицуулах зарим байгууллагууд телевизийг аливаа зар сурталчилгааг **дэлгэцээр нэвтрүүлэхээс өмнө заавал урьдчилан хянаж, баталсан** байхыг шаарддаг. Ингэхдээ зарим тохиолдолд хөгжлийн бэрхшээлийн агуулга тусгасан түүх, бүтээл, загвар зэрэгт заавал хөгжлийн бэрхшээлтэй хүнийг идэвхтэй оролцуулж, баримтжуулсан байхыг заасан байна.

Хэвлэлийн мэдээллийн салбарын мэргэжилтнүүд ярилцаж эсвэл зураг, дүрсийг авч буй хүнээсээ энгийн, хөнгөн асуултууд асууж ярилцлагаа эхлүүлж болно.

12 дугаар хүснэгтэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ярилцахад ашиглаж болох нийтлэг асуултуудын богино жагсаалтыг оруулаа.

**Хүснэгт 11 үзнэ үү.** Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ярилцах нь

**Хүснэгт 12 үзнэ үү.** Энгийн асуултууд

Хэрэв та **зар сурталчилгаа** эсвэл **олон нийтийн кампанит** ажил хийдэг бол хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн төлөөллийг ялгаварлалгүй дүрслэх хэрэгтэй.

## Хямрал, нүүлгэн шилжүүлэлт, байгалийн гамшиг, хүрээлэн буй орчны нөхцөл байдлыг сурвалжлах нь

*Хямралын үед, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өдөр тутамдаа туулдаг саад бэрхшээлүүд улам нэмэгдэж, тэдний мэдээлэл олж авах, үзэл бодлоо илэрхийлэх боломж хязгаарлагддаг.*

Хэвлэл мэдээллээр түгшүүр, терроризм, албадан нүүлгэн шилжүүлэлт, байгалийн гамшиг, хүрээлэн буй орчны нөхцөл байдал болон нийтийн эрх ашигт хамааралтай үйл явдал, цаг үе зэрэг сэдэвчилсэн олон асуудлыг хөнддөг.

Нийтлэг тохиолдолд эдгээр **нөхцөл байдлын үед** хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг тэр бүр **чухалчилж авч үздэггүй. Ихэнхдээ л нийт хүн амд чиглэсэн яаралтай тусламжийн бүтээлүүдийг түгээдэг.** Мөн хэвлэл мэдээллийн салбар тухайн нөхцөл байдлаас шалтгаалан дөнгөж бие махбодын болон нийгэм сэтгэл зүйн хөгжлийн бэрхшээлтэй болоод буй хүмүүстэй яаж ажиллах ёстой тал дээр бэлтгэлгүй байх нь бий. Түүнчлэн хямралын үед охид, эмэгтэйчүүдийн, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй тохиолдолд хүчирхийлэлд өртөх магадлал өсдөг тул сурвалжлах нөхцөл улам дордож болно.

**Найдвартай мэдээлэл олж авах улам бэрхшээлтэй болох** ба үүний гол шалтгаан нь гамшгийн үеэр ажиллаж буй алба хаагчид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээ, шаардлагыг мэддэггүйтэй холбоотой. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө, хүртээмжтэй хоргодох байр, хүмүүнлэгийн тусламж эсхүл хүнс, эм зэрэг яаралтай тусламжийн бараа түгээх төрийн тусламжийн үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжгүй байх эрсдэлтэй. Харилцаа холбооны сүлжээ барьцаалагдах, мэдээллийн сувгууд хуурамч, ташаа мэдээлэл түгээх хэрэгсэл болж хувирах, найдвартай мэдээллийн эх сурвалж хязгаарлалтад өртөж, редакцын шийдвэр эрх мэдэлтнүүдээс хамааралтай болж ч болзошгүй.

Ийм цаг үед **олон нийт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд л найдаж суудаг.** Иймд хэвлэл мэдээллийн байгууллагууд баттай мэдээ, сурвалжилгыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон олон нийтэд нийтлэг хүртээмжтэй байдлаар түгээх бэлтгэл базаах ёстой. Үүний тулд **хэвлэл мэдээллийн байгууллага хямралын үед бие даасан, шударга, цэгцтэй ажиллах дадлыг урьдаар хэвшүүлсэн байвал зохино.**

Хямралын үед яаралтай хариу үзүүлэхдээ мэдээний шинэ хөтөлбөр боловсруулах, эмзэг сэдвээр ярилцлага өрнүүлэх, сэтгэл зүйн гэмтэл авсан хүмүүстэй харилцаж, ёс зүй, ур чадварын нарийн шаардлагуудыг ягштал мөрдүүлж, хүртээмжтэй мэдээлэл бэлтгэж түгээх, хүмүүсийн үйлдэх болон эс үйлдэхүйн талаар шинэ хэрэгсэл, технологи ашиглаж мэдээлэх зэргээр ажиллах шаардлагатай. **Хямрал, нийтийг хамарсан бусад үйл явдлын үеэр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг агуулгын гадна үлдээх нь тэдний хувьд үхэл, амьдралын зааг дээр л ирж байна гэсэн үг.** Хөгжлийн бэрхшээлийн талаар мэдрэмжтэй сурвалжилна гэдэг эрсдэлийг бууруулж, нийгэмд хат бэхжүүлэх ач холбогдолтой.

Гамшиг болон олон нийтийг хамарсан бусад үйл явдал, тохиолдлуудад хэвлэл мэдээлэл хүн амын эмзэг хэсгийн хэрэгцээ шаардлага, тэдэнд тулгарч буй асуудал, бэрхшээлийг онцгой анхаарах хэрэгтэй. Мөн тэднийг төлөөлүүлэхдээ хүндэтгэлтэй хандах хэрэгтэй. Аливаа контентыг техникийн стандартад нийцүүлэн бүтээж, түгээх хэрэгтэй. 2 дугаар хэсэг болон Хүснэгт 13-т энэ тухай зарим зөвлөмжийг тусгалаа.

**Хүснэгт 13.** Хямралын үеийн нөхцөл байдалд тэгш хамруулан сурвалжлах нь

Хямралын үед **хэвлэл мэдээлэл нь** нийгэмд тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст найдвартай мэдээ сурвалжилгыг хүргэхэд **бэлтгэгдсэн** бөгөөд бэлэн байх хэрэгтэй.

## Хүмүүнлэгийн яаралтай тусламж

- НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 2019 оны **Зэвсэгт мөргөлдөөний** нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах тухай 2475 тоот тогтоол нь зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлж буй үндсэн үйлчилгээ, тэр дундаа мэдээлэл, харилцаа холбоог тэгш хүртэх эрхийг хангасан.
- 2020 онд НҮБ-аас **"Бодлогын товч: COVID-19-ын эсрэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулсан хариу арга хэмжээ"**-г боловсруулсан бөгөөд цар тахал дэлхийн 1 тэрбум хөгжлийн бэрхшээлтэй хүнд хэрхэн нөлөөлснийг онцлон тэмдэглэж, хүн бүрд хөгжлийн бэрхшээлийг хамарсан хариу арга хэмжээ авч, нөхөн сэргээхийг зөвлөж байна. Товчхондоо “Хэрэв нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, бидний цогцлоосон орчин байгууламж, харилцаа холбоо, технологи, бараа үйлчилгээ хүртээмжгүй бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шаардлагатай шийдвэр гаргах, бие даан амьдрах, тусгаарлах, хорио цээрийн дэглэм тогтоох, эрүүл мэнд, төрийн үйлчилгээг цаг тухайд нь авах боломжгүй болно".[36]
- Улс орнууд, НҮБ-ын харьяа байгууллагууд, иргэний нийгэм, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын 70 гаруй оролцогч талууд гарын үсэг зурсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг **хүмүүнлэгийн үйл ажиллагаанд** хамруулах тухай дүрэм"-д хүмүүнлэгийн үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох үндсэн зарчмуудыг тохиролцсон.[37]
- Америкийн Нэгдсэн Улсын Невада мужийн Уул уурхай, геологийн товчооноос **“Газар хөдлөлтийн дараах** олон нийтийн аюулгүй байдлын талаарх мэдээллийн бичвэр”-ийг боловсруулжээ. Энэхүү эх сурвалжийг бусад онцгой нөхцөл байдлын үед ч хамруулан хэрэглэж болно.[38]
- Al Jazeera Journalism Review сэтгүүл газар хөдлөлтийн үед мэдээлэл цуглуулах сайн туршлагыг нэгтгэжээ. Редакторууд сэтгүүлчдээс сүүлийн арван жилд Арабын орнуудад болсон газар хөдлөлтийн талаар датад суурилсан мэдээ бэлтгэхийг даалгажээ. Энэхүү баримт бичигт **газар хөдлөлтийг** байнга хянаж, бүртгэдэг олон улсын мэдээллийн сангийн мэдээллийг багтаасан бөгөөд энэ нь баримтыг шалгах, аргачлалыг тохируулах найдвартай эх сурвалж болно.[39]
- Хүртээмжтэй хүрээлэн буй орчин, технологийн глобал холбоо (GAATES) нь хүний гараар бүтсэн хүрээлэн буй орчны хүртээмжтэй байдал, түгээмэл загварт чиглэсэн үйлчилгээ эрхэлдэг. Тэд мэдээлэл солилцох, хөгжүүлэх, түгээх, удирдах зориулалт бүхий мэдээлэл, харилцаа холбооны технологиудыг хүн бүрд хүртээмжтэй байлгах зорилгоор хэд, хэдэн баримт бичгийг боловсруулжээ. Жишээлбэл, **“Хүртээмжтэй байдлаар гамшгийг бууруулах удирдамж: Гамшиг ба хөгжлийн бэрхшээл”** нь гамшгийн бэлэн байдал, хүртээмжтэй урьдчилсан сэрэмжлүүлэг, хүртээмжтэй тээвэрлэлт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амь насны аюулгүй байдал, нүүлгэн шилжүүлэлт зэрэгт зориулсан мэдээлэл болон бодлого, дадлагын дутагдлыг арилгахад чиглэсэн болно. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, олон нийтийг хамарсан хүртээмжтэй урьдчилан сэргийлэх системийг зохион бүтээх, гамшгийн бэлэн байдал, хүртээмжтэй хоргодох байр, орон сууц, тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолт зэргийг тусгасан гамшгийн эрсдэлийг бууруулах хүртээмжтэй стратегиудад төвлөрдөг.[40]
- Дэд бүтэц эвдэрч, сүйтгэгдсэн үед радио нь хамгийн үр ашигтай бөгөөд хүртээмжтэй хэрэгсэл болдог. Түүнчлэн радио хүлээн авагч нь хямд өртөгтэй, худалдан авсан байхад нэмэлт зардал шаарддаггүйгээр давуу талтай. Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага (ITU)-ын Онцгой байдлын радио холбооны цахим хуудас нь **олон нийтэд анхааруулга өгөх, гамшгийн урьдчилан сэргийлэлт, тусламж**ийн талаар мэдээлэл байршуулсан байдаг.[41]
- Хямралын үед болон бусад олон нийтийн чухал үйл явдлын үед, **хэвлэл мэдээлэл эмзэг бүлгийн хүн амд тулгарч буй бэрхшээл болон тэдний хэрэгцээг харгалзан үзэх хэрэгтэй.** Мөн эдгээр хүн амыг хүндэтгэлтэй байдлаар төлөөлөн гаргахыг хичээх хэрэгтэй. Контентыг техникийн стандартын дагуу бэлтгэж, түгээх нь зүй. Зарим зөвлөмжийг 2-р бүлгийн 13-р хуснэгэд түзүүлэв.



# Бүлэг II

Сэласи Сиканкү

Радиогийн сэтгүүлч, Гана Улсын өргөн нэвтрүүлгийн нэгдэл

© UNESCO

# Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа болон контентыг хүртээмжтэй болгох нь

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан, мөн тэдний тухай хэт нэг талыг баримтлаагүй, ялгаварлан гадуурхалгүй чанартай бүтээл туурвих нь **хэвлэл мэдээллийн салбарын контент тэдэнд хүртээмжтэй байх**ын зөвхөн нэг хэсэг юм.

## Контентыг хүртээмжтэй хийх эрх зүйн шаардлага

Ардчилсан, олонхын нийгэмд иргэд тэдэнд нөлөөлөхүйц шийдвэр гаргалтад эн тэнцүү оролцох, хувь нэмэр оруулах боломжтой байх ёстой. Хэвлэл мэдээллээр дамжин хүрч буй контент болон үйлчилгээ нь нийгмийн үр нөлөөтэй байдаг. **Тиймээс хэвлэл мэдээллийг ашиглах түгээмэл боломж нь нийгмийн аль нэг бүлгийг орхигдуулж хэрхэвч болохгүй** (жишээ нь, бие махбодын, мэдээллийн, хандлагын, эдийн засгийн (бодлоцоо) болон институтийн аливаа саад байх ёсгүй.)

Хэвлэл мэдээллийн хувьсал нь контент болон үйлчилгээг хүлээн авах өргөн хүрээний хэрэгслүүд бий болох явцад мэдээллийг илүү хүртээмжтэй болгосон. Гэсэн хэдий ч улс төрийн хүчин зүйл, нийгэм соёл, газар зүйн байрлал, худалдан авах чадвараас шалтгаалан хэрэглэгчид контент, үйлчилгээг эн тэнцүү хүлээн авах боломжгүй байдаг.

Энэ нөхцөл байдал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлд улам хүнд тусдаг. Ялангуяа захиалгын системтэй арилжааны зорилготой хэвлэл мэдээллийн үйлчилгээг авах боломж нэн бэрхшээлтэй. Хөгжлийн бэрхшээлтэй үзэгчид ийм төрлийн үйлчилгээ болон контентыг үзэхийн тулд харьцангуй үнэтэй тусламжийн технологиудыг худалдан авах ёстой болдог. Цаашилбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хангалттай төлөөлөлгүй тул олонхын сонирхол хэл, соёлын онцлогт тохирсон нэгэн төрлийн контентыг хэрэглэх шаардлагатай болж, нийгэмд гадуурхагдахад хүрдэг.

Дэлхийн олон улс, ялангуяа Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн Конвенцод нэгдсэн улсууд хэвлэл мэдээллийн контент болон үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгохын тулд эрх зүйн арга хэмжээ авч эхлээд байна. Контент

боловсруулалт, түгээлт хариуцсан хэвлэл мэдээллийн байгууллагын мэргэжилтнүүд бүх үзэгчдэд хүртээмжтэй бүтээл, үйлчилгээг нийлүүлэхийн тулд боловсруулалт, түгээлтийн ажлын явцыг эргэн харах, шинэ ур чадварыг хөгжүүлэх хэрэгцээтэй болохоор байна. Ингэснээр **хэвлэл мэдээллийн байгууллагууд дижитал орчинд үзэгчдээс олох шинэ орлогын үүсвэр бий болгож, дижитал эринд шилжих үйл явцаа дэмжиж, мөн нийгмийн хариуцлагаа илэрхийлэх юм.**

### *Ашиглах боломж болон хүртээмжтэй байдал*

**Ашиглах боломж** гэдэг нь контент, үйлчилгээг хэрэглэх, нэвтрэх, хандах боломж, эрх эсвэл чадвараар тодорхойлогддог бол **хүртээмжтэй байдал** нь дохионы хэл, дуут тайлбар, тайлбар зэрэг ашиглалтын үйлчилгээ эсвэл дэмжих технологиор дамжуулан аль болох олон хүнд, нэн ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэвлэл мэдээллийн үйлчилгээ, контентыг нээлттэй байгаа хэр хэмжээ, түвшнийг үнэлэх хэмжээс (нийгэмд оролцох болон хандах урьдач нөхцөл эсвэл харьцуулах үзүүлэлт) юм.

Өөр нэгэн ойр хамааралтай нэр томьёо бол бүх үйлчилгээ, программ, бүтээгдэхүүн, хүрээлэн буй орчныг боломжит хамгийн өргөн хүрээнд бүх хүн хэрэглэж болохуйц загвартай байхыг уриалдаг “бүгдэд зориулсан загвар” гэгддэг **“түгээмэл загварчлал”** юм. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан бүтээгдэхүүн, үйлчилгээг өөрчлөх эсвэл онцгойлон хийх хэрэгцээг арилгадаг. Хэвлэл мэдээллийн байгууллагууд, технологийн компаниуд болон дижитал мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчид өөрсдийн контент боловсруулалт, түгээлтэд түгээмэл загварчлалыг ашигладаг.

### *Дагаж мөрдөх болон хэрэглээний стандарт*

Олон улсын түвшинд хэвлэл мэдээллийн зохицуулалтын бат бөх суурийг хангадаг хэд хэдэн баримт бичиг, стандарт байдаг. Эдгээрийн дагуу хэвлэл мэдээллийн контент, үйлчилгээ нь **түгээмэл загварчлалтай** байхыг шаарддаг. Энэ нь контент, үйлчилгээ тэр дундаа өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ үзүүлэгчдийн контентыг хүн бүрд хүртээмжтэй байхаар үйлдвэрлэгдэж, загварчилсан байхыг шаарддаг (энэ нь мөн түгээмэл загварчлалын үзэл баримтлалтай холбоотой).

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн конвенц нь интернэт болон олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгохыг үүрэг болгодог. Хэвлэл мэдээллийн контентыг хүртээмжтэй болгоход анхаарах ёстой хэд хэдэн чухал чанарууд байдаг бөгөөд үүнд олон нийтийн дизайн, харилцааны өөр аргууд, техникийн стандартууд, дэвшилт технологи, хэрэгслүүд, хандах боломжийг нэмэгдүүлэх, чиглүүлэг, туршилт, интерактив байдлыг сайжруулахад ашигладаг лицензийн горим, нөөцүүд багтдаг.

Зарим улс орон, бүс мужийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байхыг хуульдаа тусгасан байдаг. Жишээ нь, АНУ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль болон Европын Хүртээмжтэй байдлын тухай хууль (2019/882 дугаар удирдамж) нь хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст зориулж контент **хүргэх тусгай аргуудыг** хангахыг шаарддаг. Мөн Европын холбооны хэвлэл мэдээллийн байгууллагуудын хувьд хүлээн авагчдадаа хүртээмжтэй хэлбэрээр дуу-дүрсний контент хүргэх үүрэг хүлээсэн байдаг.

World Wide Web Консорциум-ын нийтэлсэн Сүлжээний контентын хүртээмжтэй байдлын Гарын авлага (The Web Content Accessibility Guidelines (WCAG)) нь хэвлэл мэдээллийн байгууллагуудыг сүлжээний контентын хүртээмжтэй байдлаа бүрэн хангахын тулд ашиглаж болох **техникийн стандартаар** хангадаг. Эдгээр нь гипер холбоос, текстийн загвар, бичлэг, дуу, алтернатив текст (alt text), хадмал текст, тайлбар текстийн хэрэглээнд чиглэдэг. Дэлхий даяарх хэвлэл мэдээллийн байгууллагууд бүтээлээ илүү хүртээмжтэй болгож, хүртээмжтэй байдлыг үйл ажиллагааныхаа турш хадгалахыг баталгаажуулж байна. Европын холбоо нь төрийн үйлчилгээний байгууллагуудын вэб сайт болон гар утасны программын хүртээмжтэй байдлын талаар Сүлжээнд хандалтын удирдамжийг (WAD) (EX 2016/2102) нэвтрүүлж, тус холбооны бүх төрийн албанд өөрсдийн онлайн вэбсайт болон гар утасны аппликейшныг хүртээмжтэй болгохыг үүрэг болгосон.[42]

Эдгээр норматив баримт бичгүүдийн дагуу, сонин, сэтгүүл, радио, телевиз болон дижитал хэвлэл мэдээлэл болон бусад хэвлэмэл хэвлэл мэдээллийн бүтээж, түгээсэн хэвлэмэл, дуут, бичлэгэн болон дижитал хэлбэртэй мэдээллийг бусад иргэдтэй эн тэнцүү байдлаар хүлээн авах эрхтэй байдаг.

### *Технологийн шийдлүүд дэх хүртээмж*

Дэлхийн олон оронд орлого, контент түгээлтийн загвараас үл хамааран хэвлэл мэдээллийн байгууллагуудад хууль эрх зүйн шаардлага тавьж, контент үйлдвэрлэх, хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгохыг шаарддаг. Энэхүү зохицуулалт нь ихэвчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хадмал, тэмдэглэгээ, дуут тайлбар, хялбар ойлгомжтой цэсийн удирдлага зэргийг багтаадаг боловч үүгээр хязгаарлагдахгүй.

Сүүлийн жилүүдэд зарим норматив баримт бичгүүдээр дамжуулан хэвлэл мэдээллийг контент, үйлчилгээгээ тодорхой хугацаанд шат дараатайгаар хүртээмжтэй байдалд нийцүүлэх хэлбэрийг зөвлөх болсон. Энэ төрлийн арга барил нь бусад продюсерууд болон үйлчилгээ, бүтээл, бүтээгдэхүүн нийлүүлэгчдийг хүртээмжтэй байдлыг загварчлалын үйл явцдаа шингээхийг шаарддаг. Үр дүнд нь хэвлэл мэдээллийн контентын үйлдвэрлэл болон түгээлтэд ашиглагддаг хэд хэдэн технологийн шийдлүүд **анхнаасаа төлөвлөгдсөн, суурилсан байдлаар хийгдэж,** хүртээмжтэй болсоор байна.

Дотроо суурилсан хүртээмжтэй байдлын шинжтэй шийдлүүдийн нэг нь хиймэл оюуны технологид суурилсан шийдлүүд байна. Хиймэл оюун нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өдөр тутмын амьдралд тусалж, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, мөн амьдралын чанарыг нэмэгдүүлэх боломжтой, тэдний амьдралыг өөрчлөх чадалтай гэж яригддаг. Хэрэв хиймэл оюун нь хүн төв хандлагатай, тэгш оролцоог хангасан загвартай бол мэдээлэл болон хэвлэл мэдээллийн контентын хүлээн авалтыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх шинэ боломж нээдэг. Сүүлийн үеийн жишээнүүдийн нэг нь Apple-ийн ярианд шууд хөрвүүлэгч, хүртээмжтэй байдалд зориулсан Magnifier[43] дахь Дуу хоолой болон Заагаад ярь зэрэг юм. Microsoft-ийн хиймэл оюуныг ашиглан харааны бэрхшээлтэй[44] хүмүүст зориулж оновчтой дуут тайлбар боловсруулдаг утасны ярьдаг камерын аппликейшныг агуулсан Seeing AI Talking Camera for Blind одоогоор 70 гаруй оронд хэрэглээнд нэвтрээд байна. Өөр нэг хэрэгтэй хэрэгсэл бол WCAG стандартад нийцсэн Google Lookout бөгөөд энэ нь камерын дүрслэлийг тайлбарлах, объектыг тодорхойлох, олон хуудас текст унших, и-мэйл удирдах гэх мэт өдөр тутмын үйл ажиллагаанд туслах зорилгоор хиймэл оюун ухааны аргыг ашигладаг.[45] Мөн Samsung сонсгол хатуу хүмүүст зориулсан Galaxy Buds2 чихэвчээ танилцуулсан.[46]

Хэвлэл мэдээлэлтэй холбоотой хиймэл оюун ухааны хэрэгслүүд нь мэдээ, сурвалжилгын агуулгыг дэлгэрүүлэх, ташаа мэдээлэл (баримт шалгах, урвуу зураг хайлт, эх сурвалж хайх гэх мэт) илрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй үзэгчдэд зориулсан түгээлтийг сайжруулах, тэдэнтэй үүсгэх эргэх холбоог сайжруулах, арын албаны үйл ажиллагааг хөнгөвчлөх зэрэгт тусалж чадна.

Цаашлаад хиймэл оюун ухааны инновац нь хөгжлийн бэрхшээлтэй хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдийг ажилд авах боломжийг нэмэгдүүлж байгууллагын бүтэц болон ажлын байрыг хувирган өөрчилж байна.

Тиймээс хэвлэл мэдээллийн байгууллагууд ёс суртахууны хувьд ашигладаг хиймэл оюун ухааны хэрэгсэл, алгоритмын системийн үндсэн параметрүүдийг мэдэхээс гадна хиймэл оюун ухааныг хэрхэн ашигладаг тухайгаа үзэгчдэд мэдээлэх хэрэгтэй.

Зохицуулалт нь ихэвчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан **хадмал, тэмдэглэгээ, дуут тайлбар, хялбар ойлгомжтой цэсийн удирдлага** зэргийг багтаадаг боловч үүгээр хязгаарлагдахгүй.

### *Нээлттэй лицензийн схем*

Нээлттэй лицензийн схемүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэвлэл мэдээллийн бүтээл, үйлчилгээг хүлээн авах боломжийг хөнгөвчилдөг. Ихэнхдээ контентын лицензийн схемүүд нь **лицензийн нээлттэй нөхцөлөөр** хүртээмжтэй контентыг гаргах үзэл баримтлалтай холбоотой стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлдэг.

Нээлттэй лиценз нь хэрэглэгчдийг хэвлэл мэдээллийн нөөцийг түгээх, хувиргах, зориулалтыг шинэчлэх, дахин ашиглах, хандах эрхээр хангадаг. Энэ хүрээнд хэвлэл мэдээлэл, ялангуяа олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагууд (нийтийн

ашиг сонирхолд үйлчилдэг төрийн санхүүжилтээс ашиг хүртэгчдийн хувьд) нээлттэй контентын бодлого, хууль эрх зүйн орчныг боловсруулах, хэрэгжүүлэх, ашиглах талаар анхаарч үзэхийг зөвлөдөг. Ийм норматив баримт бичгүүдийн дунд 2013 оны Хараагүй, сонсголын бэрхшээлтэй эсвэл Бусад хэвлэмэл материал хүртэх боломжгүй хүмүүсийг дэмжих Марракешийн гэрээ багтана. Дэлхийн оюуны өмчийн байгууллага (ДОӨБ)-аас хэрэгжүүлдэг энэхүү гэрээ нь хараагүй болон харааны бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зохицсон ном **үйлдвэрлэх болон олон улсад түгээхэд** хялбар болгохын тулд жүжигчдийг урьж оролцуулдаг.

ЮНЕСКО-гийн 2019 оны **Нээлттэй боловсролын нөөцийн** талаарх зөвлөмжид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээлэл, боловсрол, танин мэдэхүйн зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр бэлтгэгдэж болох боловсролын контентыг бий болгох, хандах, дахин ашиглах, хувиргах, дахин хуваарилах бодлого, контентыг тусгасан байдаг. Төсвийн хөрөнгөөр бүтээгдсэн ийм контентыг нээлттэй лицензжүүлж эсвэл нийтийн эзэмшилд байршуулж, нээлттэй хандалтын бодлогыг хэрэгжүүлэх, үнэлэхэд санхүүгийн болон хүний нөөцийг хуваарилах ёстой. Энэ хүрээнд нээлттэй лиценз гэдэг нь зохиогчийн эрх эзэмшигчийн оюуны өмчийн эрхийг хүндэтгэж, олон нийтэд боловсролын материалд хандах, дахин ашиглах, зориулалтыг өөрчлөх, хувиргах, дахин түгээх эрхийг олгох зөвшөөрлийг хэлнэ.

## Хүртээмжтэй байдлын стандарт

- Канадын Хүртээмжтэй байдлын стандарт нь тус улсад бүртгэлтэй байгууллага, этгээдэд зориулсан хүртээмжтэй байдлын стандартыг боловсруулдаг. Канад улс 2040 он гэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан саадгүй ашиглах нөхцөлийг бүрдүүлэхийг зорьж байна. Бүх үйл ажиллагаа нь Канадын хүртээмжтэй байдлын тухай хуулийн тэргүүлэх чиглэлүүдтэй нийцдэг бөгөөд стандартуудыг сайн туршлага, судалгаанд үндэслэн загварчилдаг. Холбогдох яамнаас баталсны дараа стандартууд нь заавал дагаж мөрдөх журам болж, дараа нь холбооны зохицуулалттай байгууллага, Засгийн газрын хэлтэс, агентлагуудад хэрэгждэг.[47]
- Washington Post дижитал платформ дээрх контентын хүртээмжийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан нэмэгдүүлэхийн тулд Сүлжээний контентын хүртээмжтэй байдлын гарын авлага болон үзэгчдийн санал хүсэлтийг ашигласан байдаг. Гол онцлогуудын зарим нь (i) контентыг хулганагүйгээр удирдах боломжтой, (ii) зургийг тайлбарлахын тулд алтернатив текст ашигладаг, (iii) дуу, бичлэг нь хадмал болон сценари хавсаргасан, (iv) өнгөний харалган байдалд зориулан өндөр ялгаралтай өнгө ашигладаг, (v) уншигдахуйц байдлыг дээд хэмжээнд хүргэхийн тулд текстийн хэмжээ, фонтыг өөрчлөх сонголт, (vi) бичиглэл нь ойлгомжтой бөгөөд хүртээмжтэй, (vii) вэб хуудасны хүртээмжтэй байдлыг баталгаажуулахын тулд автоматжуулсан туршилтын хэрэгслийг ашигладаг.

## Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх аргууд

*Хүртээмжтэй байдлын шаардлагууд хууль, эрх зүйн түвшинд зохицуулагдах болсон тул хэвлэл мэдээллийн байгууллагууд бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжтэй байдлын талаар редакцын бодлого боловсруулах талаар авч үзэх хэрэгтэй. Энэ бодлого нь аль нэг баримт бичгийн нэг хэсэг, эсвэл бие даасан тусдаа бодлогын баримт бичиг байхыг ч үгүйсгэхгүй. Гол нь* ***хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны хүртээмжтэй байдал нь боломжийг тэгш олгоход суурилсан, асуудалд идэвхтэй байр сууринаас хандаж, ялгаварлан гадуурхахгүй байх тунхаг юм.***

> Хэвлэл мэдээлэл дэх хөгжлийн бэрхшээлтэй үзэгчдэд тулгарч буй саад бэрхшээлийг арилгах явдал нь голчлон **зохион байгуулалтын асуудал** юм.

Хөгжлийн бэрхшээлийн олон төрөл, түвшин байдаг тул хэвлэл мэдээллийн үйлчилгээ, контентыг хүртээмжтэй болгохын тулд сайтар **төлөвлөлт, тууштай байдал, техникийн ур чадвар** шаардагддаг. Үүнд менежер, редактор, сурвалжлагч, сэтгүүлч, техникч, дизайнер, продюсер зэрэг бүх түвшний ажилтнуудын болон эцсийн хэрэглэгч болох хөгжлийн бэрхшээлтэй

хүмүүсийн оролцоо шаардлагатай. Өөрөөр хэлбэл хэвлэл мэдээллийн өмнө байгаа саад тотгорыг арилгах нь юун түрүүнд зохион байгуулалтын, техникийн, эдийн засгийн, ур чадварт суурилсан, удирдлагын ойлголт/хандлагын асуудал юм.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд хүртээмжтэй байдлын шийдлүүдийг цогц байдлаар нэгтгэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өмнө тулгарч буй олон саад бэрхшээл, бартааг арилгаж, капиталыг олныг хамарсан буюу хүртээмжтэй болгож, нийгмийн оролцоонд хувь нэмэр оруулах юм. Дуу, дүрсний контентын хүртээмж сайжирснаар шинэ хэрэглэгчдийг татаж, нэмэлт орлогын урсгалыг бий болгож, хэвлэл мэдээллийн байгууллагуудад зах зээлийн шинэ сегментүүдийг нээх болно гэдгийг дурдах нь илүүц биз ээ.

**Хүснэгт 14-ийг үзнэ үү.** Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд хүртээмжтэй байдлыг нэгтгэх талаар ойлголт

## Хүртээмжтэй бүтээгдэхүүн болон үйлчилгээ

- 2019 оны **Европын Хүртээмжтэй байдлын тухай хууль (European Accessibility Act (EAA))** нь Европын холбооны гишүүн орнуудад харилцан адилгүй зохицуулалтын дагуу үүссэн саад тотгорыг арилгах замаар хүртээмжтэй бүтээгдэхүүн, үйлчилгээний дотоод зах зээлийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэгдсэн юм. Бизнес эрхлэгчид Европын холбооны хүртээмжтэй байдалтай холбоотой нийтлэг дүрмээс ашиг хүртэж,  зардал буурах болно.

- **EAA** нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамгийн чухал гэгдэх бүтээгдэхүүн, үйлчилгээг хамрахын зэрэгцээ холбооны улсуудын хүртээмжтэй байдлын хамгийн олон талт шаардлагуудыг агуулдаг. Эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээнд компьютер, үйлдлийн систем, ATM, тасалбар болон бүртгэлийн машин, ухаалаг гар утас, дижитал телевизийн үйлчилгээтэй холбоотой телевизийн тоног төхөөрөмж, телефон утасны үйлчилгээ болон холбоотой төхөөрөмж, телевизийн өргөн нэвтрүүлэг гэх мэт дуу дүрсний хэвлэл мэдээллийн үйлчилгээ болон холбоотой төхөөрөмж, агаарын, автобус, төмөр зам, усан замын зорчигч тээвэр, банкны үйлчилгээ, цахим ном, цахим худалдаа зэрэгтэй холбоотой үйлчилгээнүүд багтана.[48]

- Мөн **EAA** нь бизнес эрхлэгчдийг илүү ихээр тэгш хамруулахыг уриалсан үлгэр жишээ болдог. Энэ нь бизнес эрхлэгчдэд сүлжээний хүртээмжтэй байдлаас эхлээд бүтээгдэхүүний загвар хүртэл шинэ үүрэг хариуцлага хүлээлгэдэг бөгөөд дагаж мөрдөхгүй байх сонголт үгүй билээ. Энэ нь Европын холбооны 135 сая хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нөхцөл байдлыг тэгшитгэх зорилготой шинэлэг зааварчилгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцод үндэслэсэн **EAA** нь Европын холбооны бүх гишүүн орнуудын хүртээмжтэй байдлын хуулиудыг уялдуулах зорилготой. **EAA** нь 2019 оны 4-р сард хүчин төгөлдөр болсон бөгөөд гишүүн улсууд 2022 оны 6-р сарын 28-ны дотор өөрийн оронд шаардлагатай хуулиудыг гарган батлах байв. Ингэснээр гишүүн улсуудын хуулиуд 2025 оны 6-р сар гэхэд хэрэгжихэд бэлэн болох учиртай.[49]

- **Канадын Өргөн нэвтрүүлгийн корпорац (The Canadian Broadcasting Corporation (CBC))**/Радио-Канада нь хүртээмжтэй олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагын алсын харааг түгээх Саад бэрхшээлийг арилгах нь нэртэй 2023–2025 он хүртэлх иж бүрэн Хүртээмжтэй байдлын төлөвлөгөө гаргажээ. Энэхүү төлөвлөгөөнд корпорацын бүтээл, ажилтан сонгон шалгаруулалт, албан тушаал ахиулах болон ажлын байранд удаан ажиллуулах хүчин чармайлт болон технологи, дэд бүтэц зэрэг бүхий л талд хүрсэн стратегийн долоон зорилтыг тусгасан болно. Энэ бол хэвлэл мэдээллийн байгууллагад өөрчлөлт хийх цогц төлөвлөгөө юм.

- **Японы Өргөн нэвтрүүлгийн корпорац (NHK)** нь өндөр чанартай тайлбар бүхий дуут транскрипцийг автоматжуулах зорилгоор үйлдвэрлэл, түгээлтийн системд хиймэл оюун ухааны технологи ашиглах талаар судалж байна. Нэг туршилт нь спортын үйл явдлуудаас шууд статистикийг автоматаар гаргаж, дуут тайлбарт оруулах явдал юм. NHK нь тайлбарт текст үүсгэх автомат системийг ашигладаг.

- **Норвегийн Өргөн нэвтрүүлгийн корпорац (NRK)** нь хийж буй бүх ажилдаа хүртээмжтэй загвар ашигладаг бөгөөд хүн бүр нэвтрүүлгийн каталогийг үзэх боломж олгодог шууд дамжуулалтын үйлчилгээ хөгжүүлсэн. NRK нь ихэнх төхөөрөмж, платформ дээр хүртээмжтэй байдлыг өндөр түвшинд нэмэгдүүлж, хэрэглэхэд маш хялбар байдлаар шийдэл

санал болгосон. Мөн зохион байгуулалт, байгууллагын хөгжлийн төлөвлөлтдөө хүртээмжтэй загварын асуудлыг тусгайлан авч үздэг бөгөөд сонсголын бэрхшээлтэй дохионы хэлний редакцын захирал, хараанц бэрхшээлтэй дижитал хүртээмжтэй байдлын мэргэжилтэн зэрэг хүртээмжтэй байдлын менежер болон төрөл бүрийн мэргэжилтнүүдийг ажилд авсан байна.[50]

- Канадын Торонто хотын Хамбер коллежийн Хэвлэл мэдээлэл, бүтээлч урлагийн факультетын Өргөн нэвтрүүлгийн хүртээмжтэй байдлын сангийн дэмжлэгтэйгээр боловсруулсан **Хүртээмжтэй хэвлэл мэдээллийг бүтээх** нь цахим сургалтын хөтөлбөрөөр хүртээмжтэй байдлыг бий болгохдоо бүхнийг дууссаны дараа эргэн харах биш төлөвлөлтийн эхний шатнаас эхлээд бодох ёстой зүйл гэдгийг ойлгуулахыг зорьжээ.[51]

## Хэвлэл, телевиз, радио, дижитал хэвлэл мэдээллийн хэрэгсэлд авч болох арга хэмжээнүүд

### *Тогтмол хэвлэл*

Сонин, товхимол, сурталчилгааны хуудас, сэтгүүл, ном зэрэг хэвлэмэл хэвлэл мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст илүү хүртээмжтэй болгох хэд хэдэн энгийн арга байдаг. Текстийн хэмжээ, үсгийн фонтын сонголт, өнгөний сонголт, хоорондын зай, тодосгогч, нарийн төвөгтэй мэдээллийг харуулах арга зэрэг нь маш их өөрчлөлтийг бий болгодог.

### Харж хүлээн авах

- Хэвлэмэл хэвлэл мэдээлэл илүү хүртээмжтэй болсоор байна. Тэр дундаа харж хүлээн авдаг хэрэглийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй уншигчдад тулгардаг бэрхшээлийг арилгаснаар бодит өөрчлөлт болж байгаа юм. Энэ өөрчлөлт нь байгууллагын түвшинд арга хэмжээ авч эхэлснээр бүхэл тогтолцоонд нөлөөлөхүйц жин дарах болсон. Жишээ нь, Нью-Йорк Таймс сонины хувьд зураг дүрслэлийг илүү их ашиглах боломжийг нэмэгдүүлснээр хүртээмжийг нэмэгдүүлэх шат дараатай арга хэмжээнүүдийг авч байна.[52]

**Хүснэг 15-ийг үзнэ үү.** Хүртээмжтэй хэвлэмэл бүтээл

### *Телевизийн өргөн нэвтрүүлэг*

Телевиз бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн харилцааны чухал суваг юм. Хөдөлгөөнт дүрс нь агуулгыг илэрхийлэхэд илүү сайн байдаг бөгөөд зарим хүмүүс биеийн хэлэмж, илэрхийлэл болон бусад хараанц дохиогоор дамжуулан мэдээллийг илүү сайн ойлгож чаддаг. Мөн телевиз нь хямрал, нүүлгэн шилжүүлэлт, байгалийн гамшгийн үед орхигдох эрсдэлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэрэгцээт мэдээллээ авах боломж олгодог. Хадмал болон дуут тайлбар, дохионы хэл нь ийм контентын хүртээмжтэй байдлыг хангахад тусална.

Өргөн нэвтрүүлэг түгээгч ихэнх сувгууд дижитал платформ дээр давхар байршсанаар хүссэн үедээ шууд үзэх боломжтой контент нийлүүлж, мультимедиа сурвалжилгын шинэ хэлбэрүүдийг танилцуулж, интерактив хөтөлбөр, хөтөч зэргийг санал болгох болсон. Дижитал контентыг хүртээмжтэй болгох зөвлөмжийг энэ хэсгийн "Дижитал медиа" хэсгээс олж болно.

### Олон нийтийн мэдээллийн хүртээмжтэй байдал

- Бразилын Гүйцэтгэх танхимаас гаргасан албан ёсны мэдэгдэл, мэдээлэл, ярилцлага нь Засгийн газрын нээлттэй сувгууд (TV Brasil 2) болон TV Brasil сувгаар сонсголгүй хүмүүст хүртээмжтэй нөхцөлөөр шууд дамжуулагддаг. Мөн дуу дүрсний контент (кино) болон Repórter Brasil into Libras (Бразилын дохионы хэл)-ийн орчуулга байдаг. Бразилын Ерөнхийлөгчтэй хийсэн бүх ярилцлагыг ТВ Brasil 2, Brasil Agora мэдээллийн товхимол, TV Brasil 1 телевизээр дамжуулан Libras хэлний орчуулгатай хүргэдэг.[53]

- 2022 онд Францын Засгийн газар Төрийн харилцаа холбооны шинэ Хүртээмжтэй байдлын дүрмийг танилцуулсан. Дүрэмд төрийн үйлчилгээнээс гаргаж, түгээж буй контентыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэрхэн хүртээмжтэй болгох талаар тусгасан. Засгийн газрын гишүүд үг хэлэх, хэвлэлийн бага хурал хийх, ярилцлага өгөхдөө хүртээмжтэй байдлыг хангах, сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулан франц дохионы хэлний тайлбартай байлгах ёстой. [54]

**Хүснэгт 16-г үзнэ үү.** Хүртээмжтэй видео контент

### *Радио өргөн нэвтрүүлэг*

Радио бол хүлээж авахад харьцангуй хялбар бөгөөд хямд хэрэгсэл. Тэр дундаа харааны бэрхшээлтэй хүмүүст хамгийн хэрэгтэй байдаг. Урьдчилан бэлтгэсэн зохиол болон хадмал, түүнчлэн хэмнэл, ярианы тодорхой байдалд анхаарал хандуулах нь радио контентыг илүү хүртээмжтэй болгож байдаг. Ярианаас текст үүсгэх чадварыг сайжруулах, радио хүлээн авагчдад зориулсан транскрипци бүхий үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор хиймэл оюун ухаанд суурилсан шинэ технологийг боловсруулж байгаа нь онцгой байдлын үед нэн ач холбогдолтой. Бусад шийдлүүд нь мэдээллийн эх сурвалжуудыг “шүүрдэж”, холбогдох сэдвүүдийг татаж авснаар хиймэл оюун ухаанаар тухайн мэдээллийг шууд уншуулан хүлээн авах боломжтой. Түүнчлэн вэбэд суурилсан радио улам нэмэгдэх болсон тул дижитал хүртээмжийн тухай зөвлөмжид энэ асуудлыг ч тусгах нөхцөлийг бий болгож байгаа юм.

**Хүснэгт 17-г үзнэ үү.** Хүртээмжтэй дуут бүтээл

## Хүртээмжтэй бүтээл

- **Аргентины Өргөн Нэвтрүүлгийн Корпорац (**RTA) Олон нийтийн телевизийн Ёс Зүйн Дүрэмдээ (9-р зүйл) хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнд зориулан нэвтрүүлгийг эн тэнцүү ойлгох, оролцох боломж олгохын тулд дуу дүрсний болон дижитал хүртээмжийн механизмыг тусгахыг заадаг. Хөгжлийн бэрхшээлтэй үзэгчдийг хууль ёсны этгээд гэж хүлээн зөвшөөрөх нь туйлын үүрэг гэж үзэгддэг бөгөөд энэхүү дүрэмд тусгасан гарын авлагыг харгалзан үзэж, үүнд хүрэхийн тулд шаардлагатай бүх арга хэмжээг авдаг.[55]
- **Австралийн Өргөн Нэвтрүүлгийн Корпорац** (ABC) хөгжлийн бэрхшээлтэй сэтгүүлчийн радио, телевизэд ажиллаж байсан туршлагыг нь хуваалцах сонирхолтой нэвтрүүлгийг бэлдэж байв. Түүнчлэн байгууллага нь ажлын орчиндоо ямар шинэчлэл, өөрчлөлт нэвтрүүлсэн тухай хуваалцжээ. Тэрээр радио сурвалжлагч, мэдээний хөтлөгчөөр ажиллаж байхдаа дэлгэцэн дээрх текстийг сканердаж, чихэвчээр тоглуулдаг дэлгэц унших программ хангамж ашиглан шууд нэвтрүүлэг хүргэж байжээ.[56]
- **CBC/Radio-Canada** нь дуут контентыг илүү хүртээмжтэй болгож, англи хэлээрх гурван нэвтрүүлэг, франц хэлээрх хоёр нэвтрүүлэгт зохиолын текст хуулбарыг бүрэн хавсаргаж өгдөг. Мөн CBC Тусламжийн Төв нь сонсголгүй болон сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулсан радио нэвтрүүлэг, подкастуудын зохиолыг хэрхэн авах талаар мэдээллээр хангадаг.[57]
- 2024 оны хоёрдугаар сарын 13-ны өдөр, ЮНЕСКО, **Европын өргөн нэвтрүүлгийн холбоо**, болон Европ даяарх радио станцууд статик шалтгаанаас үүдэн AM радио тоглуулагчийг (засагдах боломжтой) шинэ цахилгаан машинаасаа авах гэж байгаад анхаарал хандуулж байгаагаа илэрхийлэв. Ингэснээр газрын радио дамжуулалт, CD, хуурцаг, 8-зам зэрэгтэй адилаар хоцрогдлын ирмэг дээр байна гэсэн маргаантай үндэслэлээр удахгүй бүх төрлийн шинэ автомашинуудаас AM ба FM төхөөрөмжүүдийг хасах магадлалтай болж байгаа юм. Энэ нь дэлхий даяар байгаа WiFi-д хандах боломжгүй хэдэн сая хүмүүст, мөн зөвхөн AM станцаар дамжуулан эргэн тойрныхоо мэдээллийг авдаг, шашны сургаал хүлээн авдаг болон ер нь өдөр тутмын бүхий л мэдээллээ авдаг хүмүүст маш хүнд тусах юм. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээ, контент хүлээн авах хүртээмжийг бууруулах болно.[58]
- **Францын Радио** нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан контент бэлтгэхийн тулд хэд хэдэн алхам хийсэн бөгөөд хараагүй болон харааны бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй шийдлүүдийг санал болгодог иргэний нийгмийн байгууллага, компаниудтай хамтын ажиллагаа тогтоосон. Үүнд вэбсайтуудад аудио санал болгох, дохионы хэл рүү хөрвүүлсэн концерт зэрэг соёлын арга хэмжээнүүд орно.[59]
- **Talking News Federation** (TNF) нь Их Британи даяар 300 гаруй Ярьдаг Сониныхоо тусламжтайгаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст дуут болон хэвлэмэл байдлаар мэдээлэл хүргэдэг.[60]

## *Дижитал хэвлэл мэдээлэл*

Уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ихэнх контентоо интернэтээр түгээж байгаа нь дэлхий даяарх хүмүүс мэдээллийнхээ ихэнх хэсгийг компьютер, таблет, гар утсаараа хүлээн авч байгааг харуулж байна.

Тиймээс улс орнуудын зүгээс хэвлэл мэдээллийн байгууллагуудыг өөрсдийн вэб контентоо хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох шаардлагыг тавих боллоо. Хэдийгээр хуулийн хатуу заалт байхгүй ч гэлээ хэвлэл мэдээлэл нь нийгмийн өмнө бүхий л бүлгүүд, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ч тэгш үйлчлэх хариуцлагатай үүрэгтэй. Онлайн хүртээмжтэй байдал нь уншихад тохиромжтой фонт, шошгоны товчлуур болон дүрсийг сонгох зэрэг хялбар зүйлсээс эхэлнэ. Харин дуу, бичлэг гэх мэт мультимедиа бүтээлийг хүн бүрийн хэрэглээнд тохиромжтой болгох нь илүү төвөгтэй байж болох юм.

World Wide Web консорциумаас боловсруулсан Вэб контентын хүртээмжийн Гарын Авлага зэрэг вэбийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар маш их мэдээлэлтэй эх сурвалж бий. Нэмж дурдахад хэвлэл мэдээллийн байгууллагууд ажилтнуудаа вэбийн хүртээмжтэй байдлын гэрчилгээ авахыг уриалж болно. Энэ гэрчилгээг Олон улсын хүртээмжтэй байдлын мэргэжилтнүүдийн холбоо олгодог.

**Хүснэгт 18-г үзнэ үү.** Хүртээмжтэй дижитал контент үйлдвэрлэлт

### Хүртээмжтэй дижитал бүтээл

- НҮБ-ын Хүмүүнлэгийн асуудлыг зохицуулах газрын дэмжлэгтэйгээр Олон улсын Улаан Загалмайн хороо, Олон улсын Улаан Загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгийн нийтэлсэн “Хямралд нэрвэгдсэн хүмүүсийн оролцоог сайжруулахын тулд **нийгмийн сүлжээг** хэрхэн ашиглах вэ. Хүмүүнлэгийн байгууллагуудад олон нийтийн сүлжээг ашиглаж буй хүмүүст зориулсан товч гарын авлага” номд гамшигт өртсөн хүмүүстэй харилцахдаа олон нийтийн сүлжээг үр дүнтэй ашиглах, хариуцлагатай хандах талаар практик зөвлөмж өгдөг. Энэ нь голчлон байгууллагынхаа албан ёсны олон нийтийн мэдээллийн сувгийг хариуцдаг ажилтнуудад чиглэж, өөр өөр контент форматыг ашиглахыг санал болгодог.[61]
- ЮНЕСКО-гийн "Хүртээмжтэй **дижитал баримтат өв**: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй хэлбэрээр баримтат өвийг бэлтгэх заавар" нь бас нэгэн чухал баримт бичиг юм. Өвийн баримт бичгийг дижитал хэлбэрт шилжүүлэхэд оролцож буй талууд, тухайлбал, хэвлэл мэдээлэл, мэдээллийн болон архивын байгууллагууд буюу номын санч, архивын ажилтнууд, музейн ажилтнууд, кураторууд, консерваторууд болон бусад хамаарах талуудад чиглэсэн энэхүү удирдамж нь тэдэнд хүртээмжтэй байдлын үүднээс дижитал платформ, агуулгыг сайтар төлөвлөхөд тусалдаг. Хүртээмжтэй байх тодорхой стандартуудыг дагаж, туслах программ хангамж, техник хангамжийн хэрэгслийг хөгжүүлэлтийн үе шатанд оруулснаар дижитал баримтат өвийн сангууд нь хараа, сонсгол, хөдөлгөөний болон танин мэдэхүйн бэрхшээлтэй хүмүүст соёл урлагт нэвтрэх, оролцох боломж олгоно.[62]
- CBC нь бага оврын англи хэлээрх мэдээний вэбсайтыг санал болгодог. **HTML код** нь бага зурвасын холболтод зориулагдсан байдаг. Энэ нь вэб хуудас хэт их дизайн, медиа хэрэгсэл, хуудасгүй бөгөөд ингэснээр тухайн хуудсыг уншихад ачаалал бага зарцуулж, хурдан, хялбар байдлаар мэдээлэл авах боломж бий болгодог. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл хүргэх байдлыг энгийн, хялбар болгох давуу талтай.[63]



# Бүлэг III

**Софи Морган**

Сэтгүүлч, нэвтрүүлэгч мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалагч (Их Британи)

© Beyond Borders Media

# Тэгш оролцоот удирдлагын арга барил

Хэвлэл мэдээллийн байгууллага нь бусад ажилтнуудын нэгэн адил хөгжлийн бэрхшээлтэй ажилтнаа хөдөлмөрийн зохистой нөхцөлөөр хангах, ялгаварлан гадуурхалгүй арга барил хэрэглэх хууль ёсны үүрэгтэй.

## Хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх олон талт байдал, тэгш байдал, оролцоо

Менежер, редактор, сурвалжлагч, сэтгүүлч, техникийн ажилтан, дизайнер, продюсер зэрэг хэвлэл мэдээллийн салбарын ажилтнууд өөр өөр үүрэг, хариуцлагатай байдаг. Мөн өргөдөл гаргагч, оффис ажилтан, хүний нөөцийн менежер, удирдлага, эрүүл мэндийн ажилтнууд, хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан төв зэрэг бүх талын төлөөлөл бий. Тэд бүгд **олон талт байдал, тэгш байдал, оролцоог хангах (Diversity, Equality and Inclusion (DEI))** эсвэл Манлайлал ба Тэгш хамруулах хөтөлбөр (Leadership and Inclusion)-т хамрагдаж болно.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд олон өөр бүлгийн хүмүүсийн (тэдний нас, арьс өнгө, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээл, хүйс, шашин шүтлэг, соёл, хэл, өөр өөр амьдралын нөхцөл, туршлага, чадвар зэргийг харгалзан үзэх) DEI-ийн зарчмуудыг хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлснээр ажлын байрны тогтвортой бодлого, хөтөлбөрөөр дамжуулан үр шимийг нь хүртэх боломжтой. Эцсийн дүндээ ийм арга хэмжээ нь шинэ авьяастныг татах, урамшуулах, зорилтот үзэгчдийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хэвлэл мэдээллийн салбарын бүтээлч байдал, инновацыг нэмэгдүүлэх болно.

Энэ мэт хүчин чармайлт нь DEI хөтөлбөрөөр дамжуулан ажлын орчны зан байдлын стандартыг бий болгож үүнд шаардлагатай ажилтнуудын урт хугацаанд дагаж мөрдөх, өргөн хүрээний үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга замыг зааж өгдөг. DEI хөтөлбөрүүд нь байгууллагын үндсэн үнэт зүйлсийг баталж, илэрхийлж чаддаг бөгөөд боломж, хөдөлмөр эрхлэлт, ажлын байранд нэгдмэл мэдрэмжийг тэгш хүртээмжтэй болгоход чиглэсэн бусад бодлого, журам, үйл ажиллагаатай ихэвчлэн давхцаж эсвэл огтлолцож байдаг.

DEI бодлого нь ихэвчлэн стратегийн төлөвлөлт, шийдвэр гаргалт, манлайллын дэмжлэг, сонгон шалгаруулалт, ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, хүний нөөцийн удирдлага, сургалт, чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрүүд, түүнчлэн оффисын талбайн хүртээмжтэй байдал, техникийн дэд бүтцийн холбоотой бусад асуудлыг хамардаг. Ерөнхийдөө эдгээр бодлого, үйл ажиллагаа нь ажлын байран дахь үл анзаарам буруу хандлага, ялгаварлан гадуурхал, гутаан доромжлолыг даван туулахад туслахаас гадна ажилтнууд, үзэгчид, олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллага болон бусад оролцогч талуудын хооронд итгэлцлийг бий болгоход туслах ёстой билээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухайд, DEI хүрээнд ажлын байран дахь бусад бодлого, журам, үйл ажиллагаатай уялдаа холбоотой байхыг онцлон харгалзах нь бас чухал юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн янз бүрийн бүлэгт багтдаг бөгөөд хүйс, арьс өнгө, үндэс угсаа болон бусад хүчин зүйлээс хамааран гадуурхагдаж болно. Тиймээс илүү цогц бодлого, ажлын байрны хүртээмжтэй арга барилыг шаарддаг.

Дараах хэсэгт хэвлэл мэдээллийн байгууллагууд хэрхэн зөвхөн мэдрэмжтэй, асуудлыг анхаардаг гэсэн хандлагаас өөрчлөлт хийх алхам хийсэн буюу олон талт, эрх тэгш, оролцоог хангасан байгууллага руу шилжсэн жишгүүдийг хүргэж байна.

## DEI-ийн хэрэгжилт ба хяналт

- CBC/Радио-Канадын хүртээмжтэй байдлын төлөвлөгөө 2023–2025 нь хүрэх үр дүн, түүнийг хэрхэн үнэлэх, шаардлагатай дата эх сурвалж зэргийг нарийн тодорхойлж **үр дүнд суурилсан** арга барилыг санал болгосон байдаг. Энэ төлөвлөгөөнд бие махбод, технологи, харилцаа, бараа, үйлчилгээний худалдан авалт зэрэг хөтөлбөр, үйлчилгээний төлөвлөлт, түгээлтэд зориулсан тулгуур орчныг бүрдүүлэх практик арга хэмжээг тусгасан.
- Францын Радио (Radio France) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг **мэргэжлийн түвшинд хамрах, хөдөлмөр эрхлэх**эд чиглэсэн гурван жилийн хугацаатай тав дахь гэрээгээ соёрхон батлав. Энэхүү гэрээ нь байгууллага доторх үйл ажиллагаандаа өдөр тутам авч хэрэгжүүлэх боломжтой болон шууд дамжуулалтаар олон улсын тэмдэглэлт, өдрүүд зэргийг тохиолдуулан үзэгчдийнхээ ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааны зааврыг багтаадаг.
- Бразилын Харилцаа холбооны компани (The Brazilian Communication Company (EBC)) **Ёс зүй, Шударга байдлын дүрэмдээ** (4.2 (III) ба (IV) зүйл) EBC нь ажилчдынхаа амьдралын чанарыг сайжруулах, сайн сайхан байдал, эрүүл мэнд, эрүүл ахуй, аюулгүй байдал, биет орчны арчилгаа, EBC-ийн барилга байгууламжид нээлттэй нэвтрэх боломж олгох ажлын төхөөрөмжийн хүрэлцээ, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан сайжруулсан ажлын байрыг хангахад тусалдаг гэж заасан байдаг.
Түүнчлэн нийгэм, соёлын олон талт байдал, хувь хүний ялгаатай байдлыг хүндэтгэж, үнэлж, нийгэм, соёл, угсаатны гарал үүсэл, хүйс, нас, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, бэлгийн чиг баримжаа , биеийн байдал, сэтгэцийн болон сэтгэц-нийгмийн байдал эсвэл бусад хэлбэр зэргээс нь хамааралгүйгээр бүх хүмүүст тэгш хандахыг уриалдаг.
- Австралийн Өргөн нэвтрүүлгийн корпорацын (ABC) Олон улсын хөгжил ба Номхон далайн хэвлэл мэдээллийн тусламжийн хөтөлбөрөөс (PACMAS) хэвлэл мэдээллийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах **нотолгоонд суурилсан арга барилд** шаардлагатай Номхон далайн хэвлэл мэдээлэл гэх судалгааг тайлагнажээ. [64]

## Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа, манлайлал, удирдлагын практикт DEI хөтөлбөрүүдийг нэвтрүүлэх нь

*Хэвлэл мэдээллийн байгууллагууд DEI-г байгууллага бүрд өөр нөхцөл тулгардаг. Зарим нь байгууллагын дээд удирдлагын түвшинд DEI-г хэрэгжүүлэх баттай төлөвлөгөө, стратеги гаргаж байгууллагын соёлыг өөрчлөх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлтаа нотлон харуулах хандлагатай байдаг. Харин зарим нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдлын гарын авлага, заавар, журамд тусгагдсан байдаг бодлогыг чиглүүлгээ болгон ашигладаг.*

DEI хөтөлбөрүүдийг янз бүрээр боловсруулдаг боловч бодлого, журам, санаачилга нь  тогтвортой, асуудалд нухацтай хандсан байхын тулд үргэлж **нэмэн дэлгэрүүлэх боломжтой байдлаар** хийсэн байдаг. Эцсийн дүндээ хэвлэл мэдээллийн салбарт хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудад ижил тэнцүү боломж бий болгох, ажлын байрны олон талт байдлыг түгээн сурталчлах ажил нь энэ салбарын бодлого тодорхойлогчид л байдаг. Зарим улс оронд редакцуудыг олон талт байдлыг хангах үүрэг хүлээж, энэ хүрээнд өөрсдийн гэсэн авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, жил бүр үйл явцаа тайлагнахыг эрх зүйн хүрээнд үүрэг болгосон нь ч бий.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдлыг хангах бодлогыг төлөвлөхөд

дараах нийтлэг хоёр DEI бодлогыг хэрэгжүүлэх аргыг анхаарч үзэх хэрэгтэй:

## Бүдүүвч зураг 5. DEI хүрээ

### Олон талт байдал, тэгш байдал ба тэгш хамруулах (DEI) хөтөлбөр

Иж бүрэн DEI хөтөлбөр нь стратегийн хандлага, зарчим, үнэт зүйл, стандарт, зорилгыг нэвтрүүлэх **цогц төлөвлөлт** бөгөөд **холбогдох бодлогуудад** эдгээрийг тусгадаг.

DEI-тэй хамааралтай бусад бодлогод жендэрийн тэгш байдал, ялгаварлан гадуурхал, хүчирхийллийн эсрэг болон карьер хөгжүүлэлт болон ажлын байрны бусад бодлого багтана.

Редакцын бодлоготой уялдуулан хэвлэл мэдээллийн контентын хүртээмж ба хэрэгжүүлэх арга зам, хэрэгслүүд гэж бий. Үүнд:

- Техникийн заавар, төлөвлөгөө, стандартууд
- Үйл ажиллагааны стандарт журам (жишээ нь хүртээмжтэй хүлээн авалт, ажилд авах үйл явц)
- Сургалт, сургалтын хэрэглэгдэхүүн

### Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдлын бодлого (DEP)

Стратегийн боломжуудыг нээж, эрх тэгш байдлыг дээшлүүлж, олон талт байдлыг нэмэгдүүлж, ашиг тусын талаарх ойлголтыг өсгөж, үр ашиг, бүтээлч байдлыг нэмэгдүүлж, илүү хүртээмжтэй байдалд хүргэдэг **бие даасан бодлого.**

Энэхүү бодлогын тодорхой элементүүдийг редакцын бусад бодлогуудад тусгах нь зүйтэй. Үүнд, хэвлэл мэдээлэлд эрх тэгш байдлыг хангах (1-р хэсэг), хэвлэл мэдээллийн контентын хүртээмжтэй байдлын бодлого (2-р хэсэг), хүртээмжтэй удирдлагын практик (3-р хэсэг) зэрэг болно.

Бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл явц, практик үйл ажиллагаанд арга барилын зааварчилгааг заавал харгалзах хэрэгтэй.

Ихэвчлэн нарийвчилсан болон арга барилын зааварчилгаа, гарын авлага, материал, стандарт үйл ажиллагааны журам зэрэг туслах баримт бичгүүдийг танилцуулдаг. Жишээлбэл, ажилд авах явцад наад захын болон илүү түвшний хүртээмжтэй вэбийн талаарх мэдээлэл өгөх шаардлагатай бөгөөд холбогдох сургалтыг бүх ажилтнууд болон шинээр орж байгаа хүмүүст явуулах ёстой.

Хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллаж байгаа хүн бүр DEI-ийг сурталчлах үүрэг хариуцлагаа хүлээх нь чухал ч тодорхой **DEI ажилтан, баг эсвэл төвийг томилохыг** зөвлөдөг. Энэ нь илүү ил тод, хариуцлагатай байдлыг хангахаас гадна хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудад шинээр тохиолдож буй хэрэгцээ, шаардлагад цаг алдалгүй хариу өгөхөд тусалдаг. Асуудлыг тусгайлан хариуцсан ажилтнууд нь хэлтэс хооронд төлөвлөлт, зохицуулалт, төсөвлөлтийн уялдаа холбоог хангахаас гадна тэднийг мэдлэг, мэдээллээр хангах үүрэгтэй. DEI нэгж нь нэг ажилтан, хэлтэс, хороо эсэхээс үл хамааран ахлах менежерийн зөвлөлийн удирдлагад ажиллаж, үр дүнг тайлагнадаг.

Үйл ажиллагааны үр дүн, хөрөнгө оруулалтын өгөөжийг хянахын тулд **гүйцэтгэлийн зураглал** бий болгох нь зүйтэй. Ахиц дэвшлийг хэмжих байгууллагын хэмжээний тогтвортой зорилт тодорхойлох нь ахлах

менежерүүд, ажилтнууд, гадны түншүүд болон оролцогч талуудад тустай. Ийм стратегийн баримт бичиг нь 1-р хэсэгт дурдсан Ухаалаг, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, ач холбогдолтой, цаг хугацаатай (SMART) зорилтууд дээр тулгуурлан, жишиг үзүүлэлтүүдийг тогтоож, баталгаажуулах арга хэрэгсэл, цаг хугацааг тодорхойлж, шаардлагатай хүний болон санхүүгийн нөөцөөр дэмжих үндсэн үйл ажиллагааг төлөвлөх болно. Энэ нь **ахиц дэвшлийг хэмжих өөрийн үнэлгээ, оношилгооны хэрэгслийг** хөгжүүлэхэд хүргэж болно.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудад ажлын байрыг хүртээмжтэй болгож хамруулахын тулд **тодорхой өөрчлөлт** хийх шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны хөдөлмөр эрхлэлтийг хөнгөвчлөхийн тулд ажлын байр, тэр дундаа машин, тоног төхөөрөмжийг өөрчлөх, ажилтай холбоотой материал, агуулгыг хүртээмжтэй болгох, ажлын уян хатан хуваарийг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын журамд өөрчлөлт оруулах, бусад зохицуулалт хийх бодит арга хэмжээ авах шаардлагатай байна. Үүнд налуу зам, хүртээмжтэй угаалгын өрөө, эргономик тоног төхөөрөмж, тавилга, бариул, гарын авлага, дохионы хэлний орчуулга хийх, шаардлагатай туслах хэрэгслийг худалдан авах зэрэг орно. Гэсэн хэдий ч тодорхой өөрчлөлт нь байгууллагад хэт их ачаалал өгөх ёсгүй. Тодорхой өөрчлөлтүүдийг санал хүсэлтэд тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд болон удирдагчдын хооронд нээлттэй яриа хэлэлцээ хийж шийдвэр гаргах хэрэгтэй.

Нэмж дурдахад ажилтнууд болон зорилтот хэрэглэгчдээс гомдол, санал хүсэлт, сэтгэгдлийг хүлээж авахдаа **нэрээ нууцлах боломж олгох, түүнийг чанд мөрдөх** нь хөгжлийн бэрхшээлтэй холбоотой ажлын байран дахь саад бэрхшээлийг тодорхойлох, шийдвэрлэх өөр нэг арга юм. Үүнтэй холбогдуулан хэвлэл мэдээллийн байгууллагуудад байгаа **өөрийн зохицуулалтын механизмыг** DEI хөтөлбөрүүдтэй уялдуулж болно.

Ерөнхийдөө эдгээр механизмууд нь ажилтнууд, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийг ёс зүйтэй, тэнцвэртэй, олон талт үүднээс хянах, дэмжих, сурталчлах зорилготой юм. DEI-тэй холбоотой хүчин чармайлтыг санал, гомдол зохицуулах **ажилтан, хэвлэл мэдээллийн байгууллагуудад** ажлаа сайжруулах боломж олгодог иргэдийн төлөөлөгч, ажилтны эвлэл эсвэл мэргэжлийн холбоодын ажилтай холбож болно.

Энэхүү гарын авлагын 19-р хүснэгтэд DEI хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зураглал буюу тулгардаг гол асуудлууд болон таван үе шатыг (бүдүүвч зураг 6 үзнэ үү) тайлбарласан байгаа.

**19-р хүснэгтийг үзнэ үү.** DEI хөтөлбөрийг эхлүүлэх нь

DEI хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь удирдлага болон хөгжлийн бэрхшээлтэй ажилтан хоорондын нээлттэй харилцааг дэмжих, зөвлөн туслах, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, ажилчдыг дэмжих бүлгүүдийг бий болгох, шаардлагатай өөрчлөлт, шинэ түншлэл бий болгох замаар хэвлэл мэдээллийн байгууллагуудад **хүртээмжтэй соёл бий болгоход** чиглэгдсэн үйл явц юм.

**Бүдүүвч зураг 6. DEI хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн үе шатууд**



## Гүйцэтгэлийн стратеги

- 2017 онд Катарын нийслэл Доха хотод болсон дээд хэмжээний уулзалтын үеэр Аль-Жазира албан ёсоор "Эсрэгцлээр Тодотгох нь" гэх **Сүлжээний Брэнд Стратегиа** танилцуулсан. Энэ хүрээнд бүх ажилтандаа олон талт байдал, гүн ойлголт, зүрх зориг, авхаалж самбаа гэсэн дөрвөн тулгуур ойлголтыг таниулах боловсролын кампанит ажил өрнүүлжээ.[65]
- Канадын Хүртээмжтэй байдлын тухай хуулийн (2019) дагуу тус улс дахь бүх өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид **хүртээмжтэй байдлын төлөвлөгөө**, түүнд үндэслэсэн **эргэх холбооны механизмтай** байхыг шаарддаг. Ингэснээр ажилтнууд төдийгүй олон нийтийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй холбоотой асуудлуудад анхаарал хандуулах саналаа илэрхийлэх орон зай бий болгож буй. Одоогоор өөрийн хяналтын механизмаар санал, сэтгэгдэл хүлээн авч хэвлэл мэдээлэл дэх хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг тасралтгүй авсаар байна. Олон нийтийн зүгээс нэрээ нууцлан саналаа хүргүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сайжруулах зүйлсийн талаар зөвлөлдөх уулзалт тогтмол хийх зэрэг хэлбэрүүд бий.[66]

## Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудад зориулсан тэгш хамруулсан ажлын байр бий болгох нь

*Хэвлэл мэдээллийн байгууллагуудын хувьд олон талт, тэгш хамруулах зарчмын үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд авах, хамтран ажиллах нь тийм ч хялбар биш.*

Хөгжлийн бэрхшээлтэй мэргэжилтнүүдийг багтаасан олон талт, тэгш хамруулсан ажиллах хүчийг бий болгох нь хэвлэл мэдээллийн байгууллагуудад бэрхшээлтэй байж болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажилд авах явцад ялгаварлан гадуурхалд өртөх вий, ажлын орчин нь хүндрэлтэй байх болов уу гэсэн санаа зовнилоос үүдэн хэдий өөрөө ур чадвартай боловч ажилд өргөдөл гаргахаас хойш сууж магадгүй юм. Энэ мэт **хойш суух хандлага ажилд авах, шинэ ажилд дасан зохицох, тогтвортой ажиллах, карьер ахих, удирдлагын түвшинд ажиллах** гэхчлэн олон үе шатанд тохиолдож болно.

Тиймээс эдгээр асуудлыг тэгш хамруулах, хүний эрхийг хамгаалах, шаардлагатай өөрчлөлт, ялгаварлан гадуурхлыг үл тэвчихийн төлөөх амлалт, хүчин чармайлтыг тусгасан хүний нөөцийн бодлого, арга барилаар шийдвэрлэх ёстой. Хэвлэл мэдээллийн байгууллагуудын тэгш хамруулах үйл ажиллагаа, удирдлагын арга барил нь олон төрлийн ажиллах хүчнийг сонгон шалгаруулах, элсүүлэх, орон байр, гүйцэтгэлийн үнэлгээ, менежмент дэх санаатай, санаандгүй ташаа ойлголт, хандлагыг арилгах ёстой. Эдгээр нь 1-р хэсэгт авч үзсэн редакцын болон хөтөлбөр төлөвлөлтөд анхаарах асуудлуудтай нягт холбоотой. Мөн хүртээмжтэй байдал нь 3-р хэсэгт хэлэлцсэн хэвлэл мэдээллийн бүтээл, үйлчилгээг үйлдвэрлэх, түгээх үйл явцад ч хамаарна.

Мэргэжил дээшлүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй холбоотой асуудлаар сургалт явуулах ёстой. Боломжтой бол ирээдүйн хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдийг бэлтгэдэг боловсролын байгууллагуудтай сургалтын үр дүнтэй түншлэл бий болгож, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш байдлыг сургалтын хөтөлбөрт тусгах хэрэгтэй.

Хүртээмжтэй контент бүтээхтэй холбоотойгоор байгууллагын дотоод аливаа баримт бичиг ч нээлттэй, хүртээмжтэй байснаар ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран байгууллагын үйл ажиллагаанд ижил тэнцүү оролцох боломжтой болно. Хэдийгээр энэ бүхнийг технологийн тусламжтай шийдэж болох ч, үйл ажиллагаа нь анхнаасаа бүрэн хүртээмжтэй байснаар хүн бүр ижил тэнцүү хүлээн зөвшөөрөгддөг гэдгийг илэрхийлнэ.

## НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тэгш хамруулах стратеги

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын 2-р зүйлд “Ажлын байрны өөрчлөлт” гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орох, оролцох, карьер ахиулах боломж олгохын зэрэгцээ ажил олгогчид хэт их дарамт учруулахгүй байх арга хэмжээ гэж тодорхойлсон байдаг. **Ажлын байрны өөрчлөлт** нь ажлын байрыг өөрчлөхөөс эхлээд хүртээмжтэй бичиг баримт бүрдүүлэх, дохионы хэлээр орчуулах, уян хатан ажлын хуваарь, алсаас ажиллах зэрэг бүх зүйлийг хамарна.
- Уг конвенцыг хэрэгжүүлснээр НҮБ-ын **Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тэгш хамруулах стратеги** нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамруулах чиглэлээр байнгын өөрчлөлт, ахиц дэвшил гаргах үндэс болдог. Мөн энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах ахиц дэвшлийг үнэлэх, өөрчлөлтийг хурдасгах жишиг үзүүлэлт бүхий бодлого, хариуцлагын тогтолцооны сайн жишээ юм.

### *Сонгон шалгаруулалт*

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй, хялбар байдлаар ажлын байрны самбар, вэб сайт дээр албан тушаалуудыг байршуулах нь өргөдөл гаргагчдын өргөн хүрээг хамруулах хүчин чармайлтын нэгээхэн хэсэг юм. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авах, тушаал дэвшүүлэх, тогтвортой ажлын байраар хангах үйл ажиллагаа нь шударга, алагчлалгүй байх болно гэдгийг **ажлын заруудад** онцгойлон тусгах нь зүйтэй. Гэсэн хэдий ч аливаа сонгон шалгаруулалтын өмнө **ажлын байрны тодорхойлолтыг** хянаж үзэх нь чухал бөгөөд зөвхөн тухайн ажилд зайлшгүй шаардлагатай бие махбодын болон/эсвэл оюун санааны шаардлагуудыг багтаасан байх ёстой.

Байгууллагууд **орон нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үйлчилгээ болон хөтөлбөрт хүрч энэ чиглэлээрх байгууллагуудтай** хамтран ажиллах тухай бодож үзэх нь хэрэгтэй. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй ажил горилогчдыг ажилд авахдаа менежерүүд тэгш хандах, **ажлын байрны өөрчлөлтийн нөхцөл байдлын талаар** ч бас мэдээлэлтэй байх шаардлагатай.

**20-р хүснэгтийг үзнэ үү.** Сонгон шалгаруулалтыг тэгш хамруулан хийх нь

Хэвлэл мэдээллийн байгууллагууд **орон нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үйлчилгээ болон хөтөлбөрт хүрч энэ чиглэлээрх байгууллагуудтай** хамтран ажиллах тухай бодож үзэх нь хэрэгтэй.

## Хөдөлмөр эрхлэлтийн санаачилга

- BBC зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулж тусгайлан төлөвлөсөн албан тушаал, гэрээний хугацаа, **нөхцөл бүхий ажлын байр** санал болгодог.
- CBC AbiliCrew **Placements for Excellence Program** (CAPE) нь CBC-д ажилд ороогүй ч, карьераа эхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй мэргэжилтнүүдэд зориулагдсан зургаан сарын хөтөлбөр юм. Хөтөлбөр нь хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй саад тотгорыг арилгахад тусалдаг бөгөөд тэр бүр олонд харагддаггүй ч тэдний дундах авьяас чадварыг нээн харуулж, хөгжлийн бэрхшээл, тэгш хамруулалт, хүртээмжтэй холбоотой илүү олон хэлэлцүүлэг, сургалтын контентуудыг гаргадаг.[67]
- АНУ-д төвтэй News Corp компани Dow Jones нь **хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байрны** зар сурталчилгаандаа онцолж, тусламж хэрэгтэй байгаа хүмүүст ажилд орох өргөдөл гаргахад нь тусалдаг.
- Нью Йорк Таймс сонин **хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сэтгүүл зүйн тэтгэлэгт хөтөлбөр** санал болгодог бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар мэдээлэл өгөхөд туслах зорилгоор карьерын эхэн болон дунд үеийн сэтгүүлчдийг нэг жилийн хугацаанд редакцдаа ажиллуулдаг.

### *Ажлын байранд хүлээн авах, орчин бүрдүүлэх нь*

*Хэвлэл мэдээллийн ажилтнууд хүнд, хэцүү золгүй явдал тохиолдсоны дараа зохих туслалцаа, нөхөн сэргээх үйлчилгээ авахгүй бол дам утгаараа олон нийтийн хувьд ч бодитой мэдээлэл авах эрхээ хязгаарлуулж байгаа хэрэг юм.*

Ажилд авах шийдвэр гарсны дараа тухайн байгууллагын DEI болон хүртээмжтэй байдлын бодлогыг сайтар тусгасан үйл явц явагдах учиртай. **Ахлахууддаа** ажлын байрны өөрчлөлтийн талаар мэдээлэл өгч, шинэ ажилтныг ажлынхаа чухал хэсгийг гүйцэтгэхэд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хөгжлийн бэрхшээлгүй хүмүүстэй адил тэгш оролцох боломжийг баталгаажуулах ёстой. Ажлын байрны өөрчлөлт гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд ороход шаардлагатай бүх дэмжлэг, байраар хангах цогц арга хэмжээг агуулна.

**21-р хүснэгтийг үзнэ үү.** Ажлын байранд хүлээн авах болон өөрчлөлт

## Хэвлэл мэдээллийн байгууллага дахь тэгш хамруулалт

- Нэгдсэн үндэстний байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газрын **Ажлын байрны өөрчлөлтийн удирдамж** нь тус газрын хэмжээнд шаардлагатай өөрчлөлтийг шударга, тууштай хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлдэг. [68]
- Испанийн Радио, телевизийн корпорац (RTVE) нь **ёс зүйн дүрэмдээ** (5.5.1.2-т) бүх ажилтныхаа мэргэжлийн болон хувь хүний хөгжлийг дэмжих тэгш боломжийг бодлогоор хангадаг. Нас, арьс өнгө, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарал үүсэл, хөгжлийн бэрхшээлээр нь ажлын байр, мэргэжлийн чиглэлээр аливаа төрлийн ялгаварлан гадуурхлыг хүлээн зөвшөөрдөггүй.[69]
- Европын зөвлөлөөс "Мөргөлдөөн, түрэмгийллийн нөхцөл дэх сэтгүүл зүй: Европын Зөвлөлийн холбогдох зарчмууд болон олон улсын бусад стандарттай уялдах зарчим" баримт бичгийг гаргасан бөгөөд энэ нь мөргөлдөөний бүсэд ажиллаж буй **сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалахад** хувь нэмэр оруулах хэд хэдэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгасан.[70]
- ЮНЕСКО-гийн "Сэтгүүлч, мэдээллийн ажилтан, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой аюулгүй байдлын ажиллагаа" тогтоол нь **хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны** явцад хууль сахиулахтай холбоотой арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх журмын олон улсын сайн туршлагыг багтаасан удирдамж болдог. Түүнчлэн цагдаа, хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагааны сайн туршлагыг таниулах зорилгоор бүс нутгийн хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагуудад сурталчилгааны хэрэгсэл болгон ашиглахыг санал болгож, бүс нутгийн сэтгүүлчдийн аюулгүй байдлыг сайжруулахад хувь нэмрээ оруулж, эмэгтэй сэтгүүлчдийг хамгаалахад онцгойлон анхаарч байна.[71]

### *Ажлын байрыг тогтвортой хадгалах, карьерын хөгжил болон сургалт*

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтныг удирдлагын түвшинд хүрэх болон ажлын өндөр гүйцэтгэлтэй болоход карьер хөгжлийн болон сургалтын хөтөлбөрүүд нь ажлын байранд дэмжлэг болж өгдөг.

**Хүснэгт 22-ийг үзнэ үү.** Карьерын хөгжил болон сургалтад тэгш хамруулах нь

## Хэвлэл мэдээллийн байгууллага дахь хөгжлийн бэрхшээлийн асуудалд анхаарах нь

- Олон улсын сэтгүүлчдийн сүлжээнээс **“Сэтгүүл зүй ба Сэтгэцийн эрүүл мэнд” гарын авлагыг** боловсруулжээ. Уг цахим материал нь стрессийн эмгэгээс дижитал эрүүл мэнд хүртэлх олон янзын асуудлаа анагаахад хэрэгцээтэй эх сурвалжийг багтаасан. Эх материал, подкаст ярилцлагаар дамжуулан уг хэрэгсэл нь хэвлэл мэдээллийн салбарын өндөр ачаалалтай ажлын онцлог дээр нэмээд сэтгүүлчдийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудлын үндсэн шалтгаан, түгээмэл бэрхшээл болон шийдлийг судлан танилцуулжээ.[72]
- НҮБ-ийн “**Сэтгүүлчдийн аюулгүй байдал** ба сэтгүүлчийн эсрэг гэмт үйлдлийн ял шийтгэлгүй байдлын талаарх үйл ажиллагааны төлөвлөгөө” дэх хөгжлийн бэрхшээлийн асуудалд мэдрэмжтэй мэдээлэх хандлага нь сэтгүүлчийн аюулгүй байдлын төлөөх цогц, харилцан уялдаатай, үйл ажиллагаанд суурилсан арга барил юм.[73]
- BBC-д BBC Ability болон BBC Enigma for disabled and neurodivergent colleagues гэх **ажилтнуудад зориулсан** хоёр эх сурвалж байдаг.[74] Ажилтнууд тархины ялгаатай хөгжилтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хамтран ажиллагсадтайгаа дуу хоолойгоо нэгтгэх, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх тогтмол арга хэмжээ явуулдаг.

Дэлхийн хөдөлмөрийн байгууллагаас гаргасан "Аж ахуйн нэгжийг **олон талт, тэгш хүртээмжтэй болгох нь"** баримт бичигт ковид-19 цар тахлын үеэр дэлхий даяар тэгш байдал, олон талт байдал, оролцоог хангахтай холбоотой хамгийн өргөн хүрээний судалгааны гол ололтуудыг тусгажээ.[75]

### *Олон талт ажлын хамт олныг удирдах нь*

Жишиг ажлын байрны хувьд зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан өөрчлөлт хийгээд зогсохгүй тэдний амжилтыг баталгаажуулж, бүхэл байгууллагын өсөлтөд хувь нэмрээ оруулахын тулд идэвхтэй ажилладаг. Урт хугацаандаа олон талт ажлын байр нь сэтгүүл зүйн бүтээлийн чанарыг сайжруулж, шинэ санаа, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, шинээр гарч ирж буй бэрхшээлүүдийг даван туулах арга хэрэгслийг бий болгодог.

**Хүснэгт 23-ийг үзнэ үү.** Олон талт ажлын хамт олныг удирдах нь



# Бүлэг IV

© chainarong06/Shutterstock.com*

# Аргачлалын хүснэгтүүд

## Хүснэгт 1. Хүний эрхэд суурилсан хандлагыг сэтгүүл зүйд хэвшүүлэх нь

| Ажлын жагсаалт | Хүний эрхэд суурилсан хандлагыг хэвшүүлэх нь |
|---|---|
| **Ажил** | **Тайлбар** |
| **Таван зарчмыг эргэн тунгаах** | • Хүний эрхэд суурилсан хандлагын таван удирдамж зарчим болох оролцоо, хариуцлага, ялгаварлан гадуурхахгүй байх, чадавхжуулах, хууль ёсны байдал зэрэг зарчмуудыг мэдээ, мэдээллийн агуулга, бодлого, үйл ажиллагаандаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар, тэр дундаа хүний эрхийн үүднээс авч үзээрэй. |
| **Ялгаварлан гадуурхах хандлага, саад бэрхшээлийг ил болгох** | • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэмд бүрэн оролцоход тээг болж буй бодлого, хууль эрх зүйн болон ялгаварлан гадуурхах аливаа хандлагыг судалж, тогтоо. Эдгээр саад тотгор нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн амьдралд нөлөөлөхүйц шийдвэрт идэвхтэй, хүртээмжтэй, утга учиртайгаар оролцох боломжийг хязгаарладаг.<br>• Эрх нь хөндөгдөж буй талууд буюу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс тухайн мэдээ, сурвалжилга нь тэдний амьдрал, ажил ахуйг үнэнээр тусгаж байна уу, сурвалжилгын явц нь тэдний оролцоог бодитоор хангаж чадаж байна уу гэдгийг асуу. |
| **Ташаа ойлголт, сөрөг хандлагыг арилгах** | • Хөгжлийн бэрхшээл бол засах эсвэл даван туулах ёстой зүйл эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдаас "доогуур" гэсэн ойлголтыг үл зөвшөөр<br>• Хөгжлийн бэрхшээлийг бусад хүчин зүйлтэй (жишээ нь ядуурал, газар зүй, соёл) уялдуулан хараарай. |
| **Бусдын нэр төрийг эрхэмлэн хүндэтгэж, чадавхыг нь зөв үнэлэх** | • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нэр төрийг хүндэтгэж, тэднийг зүгээр л мэдээгээр гарч байгаа хүн гэхээс илүүтэй цаг үеийн мэдээллийн эх сурвалж, хэвлэл мэдээллийн мэдээлэл олж авах, боловсруулах үйл явцад хувь нэмрээ оруулах боломжтой гэдгийг харуул.<br>• Тэднийг эрх нь хөндөгдөж буй, тэр нь анхаарах ёстой асуудал бөгөөд мэдээгээр дамжуулан эрхээ хамгаалж болохыг харуулах, дэмжих механизм байдгийг ойлгуулах (жишээ нь, олон улсын болон үндэсний хэмжээний хууль эрх зүйн актууд, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд болон дагаж мөрдөгддөг бодлого, үйл ажиллагааны журам зэргийг таниулж болно). |
| **Нээлттэй хэлэлцүүлгийг дэмжих** | • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг нийгэмд хамгаалах, дэмжих бодлогын болон тогтолцооны өөрчлөлтөд чиглэсэн бүх талыг тэгш хамруулсан нээлттэй яриа хэлэлцүүлэг, оролцоог дэмжиж байгаарай. |
| **Хяналт болон судалгаа хийх** | • Аливаа бодлого, арга хэмжээ, нөхөн сэргээх үйл ажиллагаа нь буруу эсвэл үр дүнгүй болсон тохиолдолд тэдгээр нь бусдын эрхэд хэрхэн нөлөөлсөн талаар судалгаа, хяналт хэрэгжүүлэх.<br>• Хүний эрхийг хангах үүрэг хүлээсэн хариуцагчдыг (жишээ нь төрийн байгууллагууд, иргэний нийгэм, эцэг эх, багш нар) тодорхойлох.<br>• Үр ашигтай үйл ажиллагаа, үр дүнтэй хариуцлагын тогтолцоо бүхий механизмыг тодорхойлох. |

## Хүснэгт 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэгш хамруулсан редакцын бодлого

| Ажлын жагсаалт | Оролцоог хангасан редакцын бодлого |
|---|---|
| **Ажил** | **Тайлбар** |
| **Хүртээмжтэй редакцын бодлого боловсруулах** | • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх тусгай заалтууд болон гол зарчмуудыг багтаасан шинэ редакцын бодлого боловсруулах эсвэл одоогийн бодлого, удирдамж, стандартуудыг шинэчлэх.<br>• Тодорхой, тууштай байгаарай. Ингэхийн тулд ёс зүйн код, редакцын стандарт, ёс зүйн дүрэм болон бусад баримт бичгүүдийг дахин хянах шаардлагатай байж магадгүй.<br>• Гол үнэт зүйлс, удирдамж зарчмуудыг тодорхойлж, редакцын бодлого тань чанартай сэтгүүл зүйд хэрхэн хувь нэмэр оруулах талаар бодож үзээрэй.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдлыг мэдээ, сурвалжилга, хөтөлбөрт хангахын тулд тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, ач холбогдолтой, цаг хугацаанд суурилсан (SMART) зорилтуудыг тодорхойл. |
| **Хүлээн авагчдаа судлах** | • Зорилтот хэрэглэгчдийг тодорхойлохдоо хүйс, нас, байршил, орлого, мэргэжил, хэл, статус, амьдралын хэв маяг зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзээрэй.<br>• Зорилтот хэрэглэгчидтэй холбоотой бусад мэдээлэл болох хүн ам зүйн мэдээлэл, сонирхож буй сэдэв, намтар мэдээлэл, үүрэг хариуцлага, сорилт бэрхшээл, мэдээллийн эх сурвалжуудыг нь тодорхойл. |
| **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамарсан нэр томьёоны удирдамж батлах** | • Редакцын болон төлөвлөлтийн үйл ажиллагаанд зориулсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй нэр, томьёоны удирдамж боловсруулж, хэрэгжүүл.<br>• Хөгжлийн бэрхшээлийг зонхилох мэдээлэл болгох удирдамжийг ашиглаж, дотоод үйл ажиллагаа болон гадагш чиглэсэн харилцаандаа ч ашиглах.<br>• Үг, хэл цаг хугацааны явцад өөрчлөгддөгийг санаарай. Олон жилийн өмнө түгээмэл хэрэглэгддэг байсан нэр томьёонууд одоо хүлээн зөвшөөрөгдөхгүй байж магадгүй.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй найдвартай эх сурвалжуудыг тодорхойлж, баталгаажуул. |
| **Редакцын багийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж, чадавхжуулах** | • Хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт, хандлагыг нэмэгдүүлж, бүх редакцын багт олон талт байдал, тэгш байдал, оролцоог хангах талаар тусгайлсан сургалт явуул.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар буруу ойлголт, ялгаварлан гадуурхал, хортой хэллэг, сөрөг контент зэрэг буруу, ялгаварлан гадуурхсан агуулгад суурилсан хандлагаас зайлсхий.<br>• Хэрэв шаардлагатай бол мэдээ бэлтгэх арга, хэлбэрээ өөрчил. |
| **Хөгжлийн бэрхшээлийн талаар түгээмэл мэдээлэх** | • Редакцын хүн бүрийг контент бэлтгэл, үйлдвэрлэлдээ хөгжлийн бэрхшээлтэй холбоотой асуудлыг багтаахыг дэмжиж, олон сувгаар нэвтрүүлэх.<br>• Мэдээллийн эх сурвалж, контентын үргэлжлэх хугацааны шаардлага, зураг сонгох, давталт явуулах бодлого болон эх сурвалжуудыг багтаасан өгөгдөл хамгаалах зэрэг холбогдох бодлого, үйл явцуудыг мөрдүүлэх. |

| Ажлын жагсаалт | Оролцоог хангасан редакцын бодлого |
|---|---|
| **Ажил** | **Тайлбар** |
| **Зорилтот үзэгчдийг оролцуулах** | • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын төлөөлөл, мэргэжилтнүүд, хамт олныг шинэ мэдээ, мэдээлэл бэлтгэхэд оролцуулж, тэднийг мэдээллийн гол эх сурвалжаар харуулж, тэдний түүхийг бодитоор тусгаарай. |
| **Санал хүсэлт авах хяналтын механизм тогтоох** | • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх хэвлэл мэдээллийн дүрслэлийг тогтмол хянах механизм бий болго.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй үзэгчдэд мэдээ, мэдээлэлд хариу санал өгөх боломж олго.<br>• Мэдээлэлд гарч буй эерэг, сөрөг дүрслэлийг тогтмол хянан дүгнэ.<br>• Үзэгчдээс санал хүсэлт авч, сайжруулж болох агуулгуудыг тодорхойлж, хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгчид рүүгээ (жишээ нь, тогтмол мэдээлэл цуглуулах, хэрэглэгчдийн судалгаа, фокус бүлэг, санал асуулга зэрэг) тогтмол хандаарай.<br>• Санал хүсэлт нь тавьсан зорилтын дагуу гаргасан ахиц дэвшлийг үнэлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд ашиглагдах ёстой. |

## Хүснэгт 3. Хэвлэл мэдээллийн хөтөлбөрийг эрх тэгш төлөвлөх нь

| Ажлын жагсаалт | Хэвлэл мэдээллийн эрх тэгш төлөвлөлт |
|---|---|
| **Ажил** | **Тайлбар** |
| **Хөтөлбөр төлөвлөх (Өргөн хүрээний үзэл хандлагыг тусгах нь)** | • Зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухайд биш, харин олон нийтэд өндөр ач холбогдолтой (жишээ нь, улс төрийн мэтгэлцээн, мэдээ эсвэл соёлын хөтөлбөрүүд, сонгуулийн үе, үндэсний, бүс нутгийн эсвэл дэлхийн ач холбогдол бүхий онцгой үйл явдлууд, дууны тэмцээнүүд, теле марафон, спортын арга хэмжээ, цаг агаарын мэдээ гэх мэт) хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үзэл бодлыг ч мөн оруулаарай.<br>• Хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр нэг буюу хэд хэдэн ажилтанд, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хөтлөгч эсвэл нэвтрүүлэгч эсвэл бүхэл бүтэн багт анхаарлаа төвлөрүүлж, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой мэдээллийг хүргэх үүрэг өгөх.<br>• Хөгжлийн бэрхшээлийг янз бүрийн хөтөлбөрүүдэд нэмж тусга. Мэдээний агуулгад оруулах, ТВ хөтөлбөрүүдэд дүр нэмэх, дохионы хэлний хэлмэрч нэмэх, кино үзвэрт зориулсан хадмал орчуулга зэрэг туслах технологиор нэвтрүүлэх боломж бий. |
| **Холбоотой сэдвүүдийг уяж өгөх (өөр сегментийн хөтөлбөрүүдийг холбох)** | • Холбох аргачлал буюу хөгжлийн бэрхшээлтэй холбоотой нэвтрүүлэг байлаа гэж бодоход хоёр алдартай хөтөлбөрийн хооронд (нэг хөтөлбөр дуусаж, нөгөө нь эхлэх үед) байрлуулан “холбох” аргачлалыг ашиглаарай.<br>• Өндөр ач холбогдол бүхий спортын арга хэмжээний үеэр үзэгчдийг суваг солихоос урьтан хөгжлийн бэрхшээлтэй тамирчдыг онцолсон богино баримтат кино үзүүлж болно. |
| **Цаг төлөвлөлт (Нэмэлтээр)** | • Зорилтот хэрэглэгчдийн хамгийн их татагддаг, тэднийг хамарч чаддаг төрөлжсөн хөтөлбөр, түүний хэв маягийг тодорхойлох (жишээ нь, хүүхэд, залуучууд, өндөр настнууд). Улмаар тэдгээр төрөлжсөн хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлийн асуудлыг давхар тусгах (Жишээ нь, залуу манлайлагч, шинжлэх ухааны түүчээ эмэгтэйчүүдийн тухай, эсвэл гэр бүлийн хүчирхийллийг даван туулагч эмэгтэйн тухай өгүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дүр болгож болно). |
| **Дэмжин төлөвлөх (нийтлэг байдлаар)** | • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх өгүүлэмжийг баримтат цуврал, савангийн дуурь, мэдээ, спортын арга хэмжээ, соёлын болон амралт чөлөөт цагийн хөтөлбөр зэрэг төрөл бүрийн хөтөлбөр, жанруудад багтаах. |
| **Дэмжин төлөвлөх (тусгайлсан байдлаар)** | • Тухайлсан өдөр эсвэл үйл явдлыг угтаж тусгай хөтөлбөр бэлтгэх. Жишээ нь, богино хугацааны, эсвэл ямар нэг сэдэв тойрсон тогтмол биш хөтөлбөр байж болно (жишээ нь, гамшгийн нөхцөл байдал үүссэн үед нүүлгэн шилжүүлэх хүмүүстэй холбоотой).<br>• Хөтөлбөрүүдийг олон улсын тэмдэглэлт өдрүүдтэй уялдуулан төлөвлө (жишээ нь, 2-р сарын 13 – Дэлхийн Радиогийн өдөр, 5-р сарын 3 – Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр, 9-р сарын 28 – Мэдээллийн хүртээмжийн олон улсын өдөр, 11-р сарын 2 – Сэтгүүлчдийн эсрэг гэмт хэрэг ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох олон улсын өдөр, 2-р сарын 21 – Эх хэлний өдөр, 12-р сарын 3 – Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон улсын өдөр, 10-р сарын 5 – Дэлхийн багш нарын өдөр). |

## Хүснэгт 4. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дүрслэх нь

| Ажлын жагсаалт | Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дүрслэх нь |
|---|---|
| **Ажил** | **Тайлбар** |
| **Удирдамж ёс зүйн дүрмийг боловсруулах** | • Редакцууд хүртээмжтэй үг хэллэг, нэр томьёо ашиглах, хэвшмэл ойлголт төрүүлэх дүр дүрслэлээс зайлсхийхэд чиглэсэн өөрийн дагаж мөрдөх дүрэм, журмыг боловсруулах нь зүйтэй. Ингэж чадвал өргөн нэвтрүүлгийн зохицуулагчдаас тавьдаг хөтөлбөрийн шаардлагад нийцэх төдийгүй хэрэглэгч, хүлээн авагчдаа ч хүндэтгэж буй хэрэг.<br>• Эдгээр дүрэм журмууд нь хамтын болон өөрийн зохицуулалтын үндсэн дээр хэрэгжиж болно. Мөн нарийн тусгасан эсвэл ерөнхий түвшний гэхчлэн ямар ч байж болохоос гадна хөтөлбөрийн төрлүүдийг хамруулж болно (жишээ нь, шууд телевизийн нэвтрүүлэг, инээдмийн шоу, драм, савангийн дуурь, цаг үеийн асуудлууд). |
| **Хөгжлийн бэрхшээлийг өргөн хүрээнд харуулах** | • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн тэгш эрхт гишүүд гэж харуулах бөгөөд хөгжлийн бэрхшээл нь тэдний онцлог байдлын нэг хэсэг төдий юм.<br>• Олон талын төлөөлөл бүхий ажлын хэсэг байгуулж, цогц мэдээ бэлтгэх. |
| **Олон талт байдлын давхцалыг судлах** | • Олон талт байдлыг баримтлахдаа нас, арьс өнгө, хүйс, угсаатны байдал, соёл, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, боловсрол, мэргэжил, нийгэм-эдийн засгийн болон улс төрийн хүчин зүйлүүдээр болон боловсрол, эрүүл мэнд, орон сууц, тээвэр, уур амьсгал, соёл зэрэг салбаруудаар огтлолцуулж үзээрэй. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөлөл бодит байдалтай нийцэж, бодит орчин, хүмүүс, үйл явдал, санаа бодолтой хэрхэн ижилсэж байгааг харуулна. |
| **Амжилтыг онцлох** | • Зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй байдлаар нь дурдах, эсвэл бүр хөгжлийн бэрхшээлтэй гэдгийг нь заавал дурдах шаардлагатай юу зэргийг нь бодож үзээрэй.<br>• Хөгжлийн бэрхшээлээр хязгаарлагдахгүй хүн гэдгээр нь дүрсэлж, хөгжлийн бэрхшээлээс гадна мэргэжлийн, академик, урлагийн болон бусад ололт, амжилтад нь анхаарал хандуулаарай. |
| **Бодитой байж, шударга, төвийг сахисан байдлыг хангах** | • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн эрх тэгш гишүүд гэж хүлээн зөвшөөрч, тэднийг амжилт гаргах чадамжтай хүмүүс гэдгийг ойлгоорой.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр өөрийгөө бусдаас сул дорой гэж үздэггүй гэдгийг санаарай. |
| **Хувийн нууцыг хүндэтгэх** | • Хүний эрүүл мэндийн байдал эсвэл оношийг дурдах нь мэдээнд хэр зэрэг хамаатай эсэхийг сайтар тунгаан үзээрэй.<br>• Хэрэв зайлшгүй хамаатай бол хөгжлийн бэрхшээлийг өргөн хүрээнд тайлбарлаж, зөвхөн оношинд нь төвлөрөх биш тухайн хүнд тэр нь ямар байдлаар нөлөөлдгийг дурдана уу. (Жишээ нь, өдөр тутмын амьдралд нь нөлөөлдөг нийгмийн болон хандлагын саад бэрхшээлүүд). |
| **Дүрслэлийг ухаалгаар сонгох** | • Боломжтой бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн идэвхтэй, олон талт гишүүд гэж харуулсан дүрслэл эсвэл видео сонгоорой. |

| | |
|---|---|
| **Зохист өөрчлөлтийг нэвтрүүлэх** | • Хэрэв мэдээнд хамаатай бол хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэглэдэг туслах хэрэгсэл, хүртээмжтэй байдлын талаар мэдээллийг хуваалцаарай (жишээ нь, брайл үсгийн дэлгэц, дэлгэц уншигч программ, аудио тоглуулагч).<br>• Хүн бүрд хүртээмжтэй мэдээлэл өгөх, үүнд хиймэл оюун ухаанд суурилсан шийдлүүдийг (жишээ нь, интернэт туслах, дүрс болон нүүр царай таних технологи, хадмал орчуулга, амны хайрцаг унших технологи) багтаана уу. |
| **Ахиц дэвшлийг хянах** | • Норматив баримт бичгүүд болон техникийн стандартуудын талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлж, тэдгээрийг дагаж мөрдөхийн ач холбогдлыг онцлон тэмдэглээрэй (жишээ нь, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц). |
| **Үүрэг, хариуцлагыг эргэн хянах** | • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэвлэл мэдээллээр шууд болон шууд бус тусгал, дүр дүрслэлийг тогтмол хянаж, санал хүсэлтийн механизм бий болгох.<br>• Норматив баримт бичгүүд болон стандартуудад гарсан ахиц дэвшил, ялангуяа хууль эрх зүйн шаардлага бүхий баримт бичгүүдийг болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан шинэлэг шийдлүүдийн хөгжүүлэлт, хэрэгжих байдлыг хянах. |

## Хүснэгт 5. Хөгжлийн бэрхшээлийг жендэрийн тэгш байдлыг ханган мэдээлэх нь

| Ажлын жагсаалт | Хөгжлийн бэрхшээлийг жендэрийн тэгш байдлыг ханган мэдээлэх нь |
|---|---|
| **Ажил** | **Тайлбар** |
| **Хөтөлбөрт жендэрийн тэнцвэртэй байдлыг хангах** | • Хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэнцвэртэй оролцоог хангаж, тэднийг дутуу төлөөлөх эсвэл орхигдуулахаас зайлсхийх.<br>• Зорилтот мэдээ, цаг үеийн сурвалжилга төдийгүй бүх төрлийн хөтөлбөр (жишээ нь, сурвалжилга, сэтгэгдэл/шинжилгээ, онцлох өгүүллүүд, баримтат кино) болон сэдэвт (жишээ нь, спорт, бизнес, эрүүл мэндийн тусгай хуудас эсвэл хөтөлбөрүүд) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эрэгтэй, эмэгтэй болон бусад хүйсийн төлөөллийн дуу хоолойг нэн тэргүүнд тавих.<br>• Зар сурталчилгаанд хөгжлийн бэрхшээлийг ч мөн дүрслэх.<br>• Жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг онцгой анхаарах. |
| **Хэвлэл мэдээллээр дүрслэх зохист хэлбэр, эх сурвалжийг сонгох** | • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэнцвэртэй оролцоог мэдээлэхдээ нийгэмд эзлэх байр суурь, амьдралын туршлага, үзэл бодол, тулгамддаг асуудал зэргийг нь ч мөн тусгах.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн, мөн бусад хүйсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүл, байгууллага, нийгэмд оруулж буй хувь нэмрийг дутуу үнэлэх, хохирогч болгох, эсвэл тэднийг орхигдуулахаас зайлсхийх.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн дүрслэлд хүний эрхэд суурилсан хэвлэл мэдээллийн хандлагыг (эмнэлгийн, буяны эсвэл нийгмийн хандлагаас илүүтэй) нэн тэргүүнд тавих. Мөн зохист дүрслэлийг илэрхийлээгүйн улмаас тэдний талаарх хэвшмэл буруу ойлголтыг улам түгээх эрсдэлтэй. (жишээ нь, "эмэгтэйлэг" эсвэл "эрэгтэйлэг" гэгдэх хэт уламжлалт шинж чанаруудын дүрслэл).<br>• Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг нийгмийн өргөн хүрээний асуудлуудын (жишээ нь, улс төр, эдийн засаг, мөргөлдөөн, шинжлэх ухаан, спорт, соёл) хүрээнд үнэн зөв, найдвартай, мэдээлэл хүргэх эх сурвалж гэж үзэж, холбогдох. Салбарт мэргэжилтэн болсон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн дуу хоолойг нэн тэргүүнд тавих. |
| **Олон талт төлөөлөл, дүрслэлийг хангах** | • Жендэр, арьс өнгө, угсаатны байдал, нас, бэлгийн чиг баримжаа болон бусад ялгаатай хүчин зүйлс, мөн гэр бүлийн болон цахим орчин дахь хүчирхийлэл, хөгжлийн бэрхшээлийн төрлүүд зэрэг өөр өөр нөхцөл байдлаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон янз байдлыг төлөөлөх.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, бусад хүйсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, мөн тэдний асран хамгаалагчид болон гэр бүлийн гишүүдийг олон талт байдлаар төлөөлүүлж, тэдний хүч чадал, амжилтыг хүлээн зөвшөөрч, бие даасан амьдрал, ажил эрхлэлт, мэргэжлийн ур чадвар, шийдвэр гаргалт болон нийгэмд оролцож буй байдлыг дүрслэх.<br>• Нийгмийн бүрэлдэхүүн, хүүхэд, өсвөр насны охид, хөвгүүд, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, бусад хүйсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдрал туршлага, үйлдэл, үзэл бодол, тулгамддаг асуудлыг тусгах. |

| | |
|---|---|
| **Хүйсээр ангилсан өгөгдлийг ашиглах** | • Хүйсээр ангилан судалсан өгөгдлийг цуглуулах.<br>• Хүйсээр ангилан судалсан өгөгдөлд шинжилгээ хийх.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үүрэг, чадамжтай холбоотой баримтуудыг гаргаж авах, тэдгээрийг хэвшмэл ойлголтоор дүгнэн тайлбарлахгүй байх. |
| **Жендэрийн мэдрэмжтэй хэллэг ашиглах** | • Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудалд хохирогчийг буруутгах хандлагатай үг хэллэг ашиглахгүй байх. |
| **Жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг авч үзэх** | • Жендэрт суурилсан хүчирхийллийн нотолгоо цуглуулах (жишээ нь, статистик, шууд эх сурвалжууд, эмэгтэйчүүдийг дэмжих байгууллагууд зэрэг орон нутгийн эх сурвалжууд).<br>• Хүний эрхийн талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн норматив баримт бичгүүдийн зарчмуудыг хэрэгжүүлэх (жишээ нь, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг халах тунхаг).<br>• Хүчирхийлэл нь хүрээлэн буй орчинд төдийгүй цахим орчинд ч тохиолддог төдийгүй түүнийг авч үзэх хэл, соёл, нийгмийн хэм хэмжээ, ажлын байрны ялгаатай байдлыг харгалзах. |
| **Хууль эрх зүйн баримт бичгүүд болон стандартыг хүлээн зөвшөөрөх** | • Олон улсын норматив стандартууд болон хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд, хөвгүүд, эрэгтэйчүүд, бусад хүйсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, тэдний хүний эрхийн баталгааг нийтэд хүлээн зөвшөөрүүлэх.<br>• Хүний эрхийн баримт бичгүүдэд тусгагдсан удирдамж зарчмуудыг хэрэгжүүлэх (жишээ нь, НҮБ-ын Орон нутгийн ард түмний эрхийн тунхагт багтсан уугуул хүмүүст мэдээлэл өгч, зөвшөөрөл авах). |
| **Ахиц дэвшлийг хянаж, хяналт тавих үүргийг хэрэгжүүлэх** | • Жендэр, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой норматив баримт бичгүүд, бодлого, практик, хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийг хянах.<br>• Хэвлэл мэдээллийн байгууллагуудад жендэрийн тэнцвэртэй төлөөллийг хангах, жендэрийн тэгш байдлыг дэмжих арга хэмжээний үнэлгээнд зориулсан одоо байгаа хэмжээсүүдийг ашиглах.<br>• Жендэрт тулгуурласан мэдээ, цаг үеийн асуудлын контентыг хянах, шинжилгээ хийх.<br>• Редакцын өөр өөр контентын төрөл, сэдэв, ангилал, сегментүүдийн жендэрийн мэдрэмжийн түвшинг үнэлэх. |

## Хүснэгт 6. Үг хэллэгийн сонголтод анхаарах зүйлс

| Ажлын жагсаалт | Нэр томьёо сонгохдоо анхаарах гол зүйлс |
|---|---|
| **Ажил** | **Тайлбар** |
| **Нэгдүгээр биеийн төлөөний үг ашигла** | • Тухайн хүнийг дан ганц хөгжлийн бэрхшээлээр нь л тодорхойлж болохгүй. Төлөөний үгэндээ аль болох би, бид зэрэг нэгдүгээр биеийн төлөөний үг ашиглана.<br>• Ярилцлагад оролцогчид өөр өөр нэр томьёог ашиглахыг хүсдэг тохиолдол байдаг гэдгийг анхаарах хэрэгтэй. |
| **Хувь хүн өөрийгөө юу гэж тодорхойлж байгаа эн тэргүүнд тавих** | • Хөгжлийн бэрхшээлийг нь хэрхэн нэрлэхийг тухайн хүнээс нь тодруулж, тэдний сонголтыг дагах. Жишээлбэл, сонсголгүй болон аутизмтай зарим хүмүүс өөрийгөө хөгжлийн бэрхшээлээрээ тодорхойлсон хэллэгийг илүүд үздэг (жишээ нь, хэл ярианы хувьд цөөнхөд багтах буюу дүлий хүн гэх нэр томьёоны оронд сонсголгүй хүн гэж тодорхойлох нь илүү зохистой). |
| **Энгийн хэл найруулга ашиглах** | • Ойлгомжтой, үнэн зөв энгийн хэллэг ашиглаарай. |
| **Эмзэг нэр томьёонуудыг эргэцүүлэх** | • “Эмгэг”, “гажиг”, “онцгой” гэх мэт үгсийг хөгжлийн бэрхшээлийн мөн чанарыг тодорхойлоход ашиглахдаа мэдрэмжтэй хандах хэрэгтэй.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан үг хэлний удирдамжийг найдвартай эх сурвалжаас олж уншаарай.<br>• Жендэрийн тэгш байдлын талаарх удирдамж зэрэг холбогдох бусад хэлний гарын авлага ашиглаарай. |
| **Нэр томьёоны хамгийн сүүлийн үеийн өөрчлөлтийг тогтмол харгалзах** | • Ашиглагдахаа больсон эсвэл зайлсхийх ёстой нэр томьёонууд хэрхэн өөрчлөгдөж байгааг нягталж, шинэ нэр томьёонуудыг нэвтрүүлэхэд анхаараарай. |
| **Тухайн хэл соёлын контекстийг ойлгох** | • Бүх хэлэнд шаардлагатай нэр томьёонууд байхгүй байж болох тул орчуулга хийх үед орчуулагчид, хэлний нийгэмлэгийн гишүүд болон бусад эх сурвалжуудаас баталгаажуулах шаардлагатай байж болно. |
| **Байгууллагад хөгжлийн бэрхшээлийн асуудлыг тэгш хамруулсан удирдамж ашиглах** | • Байгууллагын хамт олныг хөгжлийн бэрхшээлийн асуудлыг тэгш хамруулсан хэл найруулга ашиглахыг уриалах, тогтмол ашиглах.<br>• Жендэрийн тэгш байдал гэх мэт хөгжлийн бэрхшээлээс бусад нөхцөл байдалд ч хүртээмжтэй хэлний удирдамжийг баримтлах. |

## Хүснэгт 7. Үг, нэр томьёо, хэллэгийн жагсаалт

| Ажлын жагсаалт | |
|---|---|
| **Орлуулах үг хэллэг** | **Зайлсхийх үг хэллэг** |
| • Хөгжлийн бэрхшээлгүй хүн | • Бүрэн бүтэн бие махбодтой<br>• Энгийн<br>• Хөгжлийн бэрхшээлгүй |
| • Хөгжлийн бэрхшээлтэй хүн<br>• Хөгжлийн бэрхшээлтэй амьдардаг хүн | • Зовж шаналсан<br>• Зовж буй<br>• Хохирсон<br>• Хохирогч |
| • Хөгжлийн бэрхшээлтэй хүн | • Бусдаас өөр чадавхтай<br>• Тусгай хэрэгцээтэй |
| • Бие махбодын нөхцөл байдал эсвэл хөгжлийн бэрхшээл<br>• Саатал | • Эмгэг<br>• Гажиг |
| • Ухаангүй, хөдөлгөөнгүй | • Ургамал болсон хүн |
| • Төрөлхийн хөгжлийн бэрхшээл | • Төрөлхийн гажиг |
| • Хөгжлийн бэрхшээлтэй хүн | • Саатaлтай хүн<br>• Сааталд орсон<br>• Сааталд-орсон |
| • Харааны бэрхшээлтэй<br>• Хараагүй | • Сохор<br>• Дүлий |
| • Тэргэнцэр ашигладаг хүн<br>• Тэргэнцэр хэрэглэгч | • Хөдөлгөөнгүй<br>• Хөдөлж чадахгүй |
| • Сэтгэцийн бэрхшээлтэй хүн | • Гажигтай<br>• Солиотой<br>• Сэтгэцийн өвчтэй<br>• Сэтгэцийн гажигтай |
| • Нийгэм, сэтгэцийн бэрхшээлүүдтэй хүн | • Сэтгэцийн хомсдолтой |
| • Сэтгэцийн бэрхшээлтэй хүн | • Солиотой, сэтгэл мэдрэлийн өвчтэй |
| • Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүн | • Сэтгэцийн хомсдолтой |
| • Даун синдромтой хүн | • Монголоид эсвэл Даун синдром |
| • Шизофрени өвчтэй хүн | • Шизофренитэй |
| • Боломжтой тохиолдолд бие махбодын хөгжлийн бэрхшээл гэж ашиглах | • Саажилттай<br>• Хүчгүй<br>• Бие махбодын хязгаарлалттай |
| • Сонсголын бэрхшээлтэй | • Хэлгүй дүлий |
| • Сонсгол муутай<br>• Сонсгол алдагдсан | • Хэлгүй дүлий |
| • Намхан хүн<br>• Жижиг | • Одой<br>• Давжаа |
| • Нэмэлт хэрэгцээ | • Тусгай хэрэгцээ |
| • Хүртээмжтэй зогсоол | • Тахир дутуугийн зогсоол |

## Хүснэгт 8. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг үзэн ядах, туйлширсан үзэл бүхий үг хэллэгийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зарим арга, аргачлалууд

| Ажлын жагсаалт | Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг үзэн ядах, туйлширсан үзэл бүхий үг хэллэгийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зарим арга техникүүд |
|---|---|
| **Ажил** | **Тайлбар** |
| **Хууль тогтоомжийг судлах** | • Үндэсний болон олон улсын түвшинд одоо байгаа хууль тогтоомжийг судлах. Дэлхийн ихэнх улс оронд өргөн нэвтрүүлгийн хууль тогтоомж нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зохицуулах хүрээг тогтоож, хөтөлбөрийн агуулгын талаарх зарим дүрмүүдийг багтаасан байдаг. Эдгээр дүрмүүд нь холбогдох олон улсын зарчим, норматив баримт бичгүүд дээр суурилсан бөгөөд хэрэглэгчдийн санал, гомдол гаргах эрхийг баталгаажуулах, зохицуулах байгууллагуудад нэвтрүүлгийн кодод заасан заалтыг зөрчсөн гэж үзсэн гомдлыг шалгаж, шийдвэр гаргах эрхийг олгох журмыг тогтоох зэрэг зохицуулалтыг ч тусгах тохиолдол бий.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхлын улмаас үйлдсэн гэмт хэргийг шийдвэрлэх бусад хууль байгаа эсэхийг шалгах.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг үзэн ядалттай холбоотой гэмт хэргийн талаарх албан ёсны статистикийг судалж, гэмт хэргийн шалтгаан, төрөл, хүйс, нас, угсаатны байдал, цагаачлалын статус, шашин шүтлэг, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл зэрэгт дүн шинжилгээ хийнэ. |
| **Өөрийн дүрэм журам тогтоож, оролцох** | • Гомдол хүлээн авах болон шийдвэрлэх практик журмыг боловсруулж, хэрэгжүүлэх.<br>• Контентын наад захын стандартыг тогтоож, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дүрслэлд ялгаварлан гадуурхах хэллэгээс зайлсхийх, ингэхдээ дижитал платформ дээрх үзэгчдийн сэтгэгдэл хэсгийг ч (ялгаварлан гадуурхах, үзэн ядах үг хэллэг ашигласан) мөн хянах.<br>• Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, үзэгчдийн санал бодлыг төлөөлдөг зөвлөлүүдтэй хамтран ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон иргэний нийгмийн төлөөлөгчдийг гишүүнээр оруулах. |
| **Зохицуулагчдыг татан оролцуулах** | • Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон бусад хууль ёсны эрх, ашиг сонирхлыг тэнцвэржүүлэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой олон талт байдал болон хэвлэл мэдээллийн төлөөллийг хамгаалах зэрэг үйл ажиллагааг өргөн нэвтрүүлгийн хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх ёстой. Эдгээр үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэвлэл мэдээлэл дэх төлөөлөлд нөлөөлдөг. |
| **Хэвлэл мэдээллийн агуулгад хариуцлага, олон талт байдлыг хүндэтгэхийг харуулах** | • Олон талт байдлыг хэвлэл мэдээлэлд сурталчилж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс төдийгүй нийгмийн олон янз бүлгийн хэрэгцээг хангах.<br>• Хөтөлбөрүүдэд олон янзын үзэл бодлыг багтааж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан агуулгыг хүртээмжтэй болгох.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглэсэн туйлширсан болон үзэн ядах үг хэллэгийн эсрэг өргөн цар хүрээтэй ухуулах кампанит ажлуудыг зохион байгуулж, сурталчилгааны байгууллагууд болон интернэтийн үйлчилгээ эрхлэгчид зэрэг бусад оролцогч талуудтай хамтарсан хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, иргэний боловсролыг дээшлүүлж, мэдээлэл, медиа боловсролын чадамжийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах. |

| | |
|---|---|
| **Одоо байгаа дүрэм журам, удирдамжийг сайжруулах эсвэл шинэчлэх** | • Хэвлэл мэдээллийн байгууллагууд өөрийн контентод хэт туйлширсан болон үзэн ядах үг хэллэгийг хэрхэн шийдвэрлэх талаарх дүрэм журам, удирдамжийг боловсруулах, үүнд дижитал платформ дээрх нээлттэй хэсэг болох үзэгчдийн санал сэтгэгдлүүдийг (ихэвчлэн сэтгэгдлийн хэлбэрээр) ч хамруулах.<br>• Үзэгчдийг хамгаалах, хэт туйлширсан үг хэллэгээс урьдчилан сэргийлэх, эмзэг сэдвээрх асуудлуудад анхаарал хандуулах, мэдээлэлд тэнцвэртэй, алагчлалгүй байхыг шаардсан стандартыг тодорхойлж мөрдөх. Стандартууд нь мөн хэвлэл мэдээллийн ил тод байдал, үзэгчдэд хариуцлагатай байдлаа илэрхийлэхэд тусална.<br>• Зөвхөн олон талт байдал болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдлыг хэт ерөнхий байдлаар авч үзсэн дүрмүүдийг илүү тодорхой болгож шинэчлэх. |
| **Тогтмол шинжилгээ, үнэлгээ хийх** | • Дүрэм, удирдамжийн хэрэгжилтийг хангахын тулд хөтөлбөрт хөндөгдөж буй асуудлуудад хамааралтай үзэгчдийн дунд судалгаа явуулах.<br>• Хэвлэл мэдээллээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дүрслэхэд ашигладаг доромжилсон хэллэг, нэр томьёоны шинжилгээ, судалгааг хийх, мөн хэвлэл мэдээлэл дэх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог судлах.<br>• Ажиллах хүчний олон талт байдлыг дэмжих, байгууллагын дотоод үйл ажиллагаа, менежментийн практикийн нэг хэсэг болгон хэрэгжүүлэх (Гарын авлагын 3-р хэсэгт тусгагдсан). |

## Хүснэгт 9. Гомдлын төрлүүд, тэдгээрийг шийдвэрлэх нь

| Ажлын жагсаалт | Гомдлын төрлүүд, тэдгээрийг шийдвэрлэх нь |
|---|---|
| **Ажил** | **Тайлбар** |
| **Доромжилсон хэллэг болон нэр томьёо** | • Зарим үг хэллэг, доромжилсон утгатай үгс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг зохисгүй дүрсэлсэнтэй холбоотой гомдлуудыг шинжлэх. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс ирдэг хамгийн түгээмэл гомдлын нэг юм.<br>• Хэвлэл мэдээллийн агуулгад анагаах ухааны хандлага болон холбогдох хандлагуудыг болгоомжтой ашиглаж, тодорхой эмнэлгийн нэр томьёо, үгсийг зөвхөн анагаах ухааны мэдлэг өгөх зорилгоор ашиглахыг анхаарах.<br>• Хэвлэл мэдээллийн байгууллагуудад хүртээмжтэй үг, хэллэгийн удирдамжийг нэвтрүүлж, түүнийг бүх төрлийн үйлчилгээнд хэрэгжүүлэх. |
| **Зохисгүй контент болон нэвтрүүлгүүд** | • Нэвтрүүлэг, хөтөлбөрөөр зохисгүй агуулга нэвтрүүлэхгүй байх, мөн зүй бус асуулт, биеийн хэлэмж, байдал үзүүлэхээс зайлсхийх. (жишээ нь, үзвэр үйлчилгээний нэвтрүүлгүүдэд тодорхой өгүүлэмжийн хүрээнд аман хошигнол хийх, эсвэл шинжлэх ухааны хөтөлбөрт жендэрийн ялгаварлан гадуурхалттай яриа оруулах). Нэн ялангуяа хүүхдүүд болон бусад зорилтот бүлэгт зориулсан контентод онцгой анхаарах. |
| **Дүрс болон үйлдэл** | • Яаж дүрслэх вэ гэдэг нь ч бас гомдол гаргах шалтгаан болдгийг санах хэрэгтэй. Ийм дүрслэл, яриа, үйлдлүүд нь ихэвчлэн хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэвшмэл шинж байдлыг (жишээ нь, сэтгэцийн болон бие махбодын хөгжлийн бэрхшээл) дууриах, дүр эсгэх зэрэг байдлаар харуулсан байдаг. |
| **Сэдлийг харгалзан үзэх** | • Асуудлыг шинжлэхдээ түүний учир шалтгааныг үнэлэх. Гомдол нь санаандгүй болсон, нэг удаагийн тохиолдол байж болох бөгөөд энэ нь санамсаргүй, анзааргагүй байдлаас үүдэлтэй байж болно (жишээ нь, нийгэмд хошин шогоор дамжуулж егөөдсөн контент). |
| **Шалгалт ба шийдвэр гаргалт** | • Зохих журмын дагуу гомдлыг хэн, хэрхэн шийдвэрлэхийг тодорхой тусгах. (жишээ нь, шийдвэр гаргагчид уу, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төлөөлдөг иргэний нийгэм).<br>• Шаардлагатай бол агуулгыг доромжилсон эсэхийг тодорхойлох, улмаар хортой контентыг ашиглах, нийтлэх болон түгээх нь зөв байсан эсэхийг шалгах хоёр үе шаттай хяналтын загварыг хэрэгжүүлэх. Үүнд хэд хэдэн асуудлыг харгалзан үзнэ (жишээ нь хор хөнөөлийн түвшин, нэвтрүүлгийн цаг, хөтөлбөрийн хуваарь, урьдчилан анхааруулга, суурь мэдээллийн хүчин зүйлс болон бусад редакцын шийдвэрүүд).<br>• Үр дүнг танилцуулсны дараа зохих дагалдах арга хэмжээг авах (жишээ нь олон нийтээс уучлалт гуйх). |

## Хүснэгт 10. Хөгжлийн бэрхшээлийн тухай эрэн сурвалжлах нь

| Ажлын жагсаалт | Хөгжлийн бэрхшээлийн асуудлыг эрэн сурвалжлах нь |
|---|---|
| **Ажил** | **Тайлбар** |
| **Эрэн сурвалжлах үндэслэл ба таамаглал боловсруулах нь** | |
| **Хөгжлийн бэрхшээлийг авч үзэх** | • Хөгжлийн бэрхшээлийг нийгмийн бүрэлдэхүүн асуудал гэж үзэж, хөгжлийн бэрхшээлтэй хүн ч нийгэмд олон үүрэг гүйцэтгэдгийг санах.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмд оруулж буй хувь нэмэр нь тэдний амьдрах, ажиллах нөхцөлийг дэмжих эсвэл саад болдог бөгөөд хүн ам зүйн, нийгэм-соёлын болон улс төрийн олон хүчин зүйлээс ихээхэн хамаардаг гэдгийг ойлгох.<br>• Өөр хоорондоо холбоогүй байж болох янз бүрийн оролцогч талуудын хоорондын харилцааг тогтоож, түүнийг цаашид эрэн сурвалжлах шаардлагатай эсэхийг авч үзэх. |
| **Олон талт байдлыг авч үзэх** | • Ямар ч төрлийн мэдээ, сурвалжилгад давхардсан саад бэрхшээл байна уу, тэдгээр нь гүнзгий эрэн сурвалжлах шаардлагатай юу гэдгийг харгалзах (жишээ нь, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой асуудал дээр хөгжлийн бэрхшээлтэй хүн ямар хэлбэрээр өртсөн зэрэг).<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн цоорхойг олж тогтоон, судалж, ил тод болгох.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд олон давхаргат буюу олон төрлийн бэрхшээлтэй нэгэн зэрэг тулгардаг тул жендэрийн тэгш байдалд онцгой анхаарал хандуулах. |
| **Харилцан уялдаа холбоог шинжлэх** | • Өөрчлөлтийн стратегитай холбоотой болон одоо байгаа саад бэрхшээл нь (бага орлоготой, бичиг үсгийн боловсролгүй байдал, ажилгүйдэл, гадуурхал, ядуурал, хүрээлэн буй орчны бодлого, гэмт хэрэг, нийтийн зарцуулалт, авлига зэрэг асуудлууд) өөр хоорондоо харилцан хамааралтай байна уу (жишээ нь, мэдээний өнцгийг зөв тодорхойлох) гэдгийг анзаарч үзэх. |
| **Зорилтот үзэгчдийг дахин тодорхойлох** | • Мэдээ бэлтгэхдээ зорилтот үзэгчдийг тодорхойлох. Агуулга нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар биш байсан ч илүү хүртээмжтэй байлгахын тулд зорилтот үзэгчдийг өргөн хүрээнд тодорхойлох нь үр дүнтэй байж болно. |
| **Олон төрлийн эх сурвалжийг авч үзэх** | |
| **Шууд болон анхдагч эх сурвалжуудыг илүүд үзэх** | • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст өөрсдийн түүхээ ярьж, дуу хоолойгоо хүргэх, мөн бусад эх сурвалжуудыг санал болгох боломж олгох.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шууд, найдвартай, үнэн зөв, анхан шатны мэдээллийн эх сурвалж гэж үзэх.<br>• Энэ нь хөгжлийн бэрхшээл дээр төвлөрөөгүй бусад нийтлэг сэдвүүдэд ч хамаарна. Хэрэв тухайн хүн хэлмэрч эсвэл асран хамгаалагчийн тусламжтай харилцдаг бол гол анхаарлыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд төвлөрүүлэхийг анхаарах. |
| **Хүний эрхийн байгууллагад тайлагнасан баримт бичгүүдийг авч үзэх** | • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаар гишүүн улсуудаас бэлтгэн илгээсэн тайлангуудыг судлах.<br>• Хугацаат тайлангуудын дүн шинжилгээ, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх кампанит ажлын үр дүн, үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө, олон улсын өдрүүдийг тэмдэглэх тухай мэдээлэл зэрэг бусад баримт бичгүүдийг шалгах. |

| | |
|---|---|
| **Хүний эрхийн байгууллагад тайлагнасан баримт бичгүүдийг авч үзэх** | • Хүний эрхийн байгууллагуудаас бэлтгэсэн, үйл ажиллагаа хэрэгжсэн эсэхийг баталгаажуулах мэдээлэл агуулсан бусад тайлангууд байдаг гэдгийг ойлгох (жишээ нь, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тусгай илтгэгч эсвэл Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын гишүүн улсуудын Бага хурлын нарийн бичгийн дарга нарын газар болон бусад НҮБ-ын байгууллагууд эсвэл түншлэлүүд, тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын Түншлэл болон НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог дэмжих стратеги).<br>• Хэвлэл мэдээллээр дамжуулан ойлголт, мэдлэгийг дээшлүүлэхтэй холбоотой мэдээллийг агуулсан хугацаат тайлангуудыг шалгах. |
| **Шууд бус болон өөр эх сурвалжуудыг авч үзэх** | • Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Нийтийн мэдээллийн нээлттэй байдлын тухай хууль зэрэг нийтэд ил тод хууль, тогтоомжийг анхаарч үзэх хэрэгтэй (жишээ нь, НҮБ-ын Гэрээт байгууллагуудын мэдээллийн сан, шүүхийн бүртгэл, хууль эрх зүйн баримт бичгүүд, нийтийн бүртгэлийн сангууд, татварын тайлангууд, төсвийн зарцуулалтын тайлангууд, техникийн баримт бичгүүд, эмнэлгийн байгууллагуудын тайлангууд болон орон нутгийн нээлттэй мэдээллийн порталууд). |
| **Олон төрлийн өгөгдлийг авч үзэх** | • Үндэсний тооллого, өрхийн судалгаа, сургуулийн суурь судалгаа, амьдралын түвшин тодорхойлох судалгаа, хөгжлийн бэрхшээлийн судалгаа, тооллогын дараах судалгаа, шууд үнэлгээ болон эмнэлгийн оношилгоо зэрэг янз бүрийн мэдээллийн эх сурвалжуудыг судлах.<br>• Номын сан, архив, онлайн хадгалах газруудаас мэдээлэл авах. |
| **Өгөгдлийн цоорхойг санах** | • Албан ёсны, макро эдийн засгийн болон ерөнхий статистикт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар хүртээмжтэй мэдээлэл хомс байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн статистик мэдээлэл дутуу байх нөхцөлийг үүсгэдэг.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тодорхой статистикт тулгуурлах. |
| **Нийтийн мэдээлэлд хандах эрх хүсэх** | • Иргэдэд төр, олон нийтийн байгууллагын албан ёсны мэдээлэл хүсэх эрх олгодог заалтуудыг ашиглан мэдээлэл олж авах. Хөгжлийн бэрхшээлтэй холбоотой мэдээллийг энэ мэт заалтын дагуу олж, судалж болно. |
| **Гол зарчим, хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэгжүүлэх** | |
| **Хувийн нууцыг хүндэтгэх** | • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн нууц, ялангуяа тэдний эрүүл мэнд, сайн сайхан байдалтай холбоотой мэдээллийг, мөн охид, эмэгтэйчүүдийн эсрэг гэмт хэрэг, хүчирхийлэл, дарамттай холбоотой эмзэг түүхүүдийг ашиглахдаа маш анхааралтай байх.<br>• Мэдээллийг ил тод болгохдоо эсвэл уугуул үндэстэн ястны тухай эмзэг мэдээлэл ашиглахдаа тэдний зөвшөөрлийг авах, сайн дурын үндсэн дээр сурвалжлах. |
| **Мэдээлэл цуглуулах, санал хүсэлт авахдаа тэгш хамруулах** | • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг судалгаа болон ярилцлагад оролцох, үзэл бодол, санал хүсэлтээ хуваалцах боломжийг олгодог, хүртээмжтэй мэдээлэл цуглуулах практик, хэрэгсэл, дагаж мөрдөх дүрэм боловсруулах. Энэ нь зөвхөн эх сурвалжуудад төдийгүй хэрэгжүүлэх арга, хэлбэрийн хувьд ч хүртээмжтэй байх ёстой. Мэдээлэл цуглуулахад хүртээмжтэй байдлыг үл ойшоож, хүртээмжгүй хэрэгслийг (жишээ нь, судалгааны хэрэгслүүд) ашиглах нь буруу, дулимаг, бодитой бус эсвэл төөрөгдүүлсэн ойлголтод хүргэж болзошгүй. |

| | |
|---|---|
| **Гол зарчим, хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэгжүүлэх** | |
| **Бүх зарчмыг хэрэгжүүлэхдээ түгээмэл загварчлалыг ашиглах** | • Мэдээлэл цуглуулах, контент боловсруулах, хэвлэн нийтлэх бүхий л шатанд хүртээмж, оролцооны зарчмуудыг харгалзан үзэх хэрэгтэй. Энэ сурах, ажиллах, амралт чөлөөт цаг гэхчлэн бүхий л зорилгын хүрээнд аливаа нөөц, үйл явц, хүрээлэн буй орчин нь хүн бүрд хүртээмжтэй, ойлгомжтой байх ёстой (нас, байршил, хөгжлийн бэрхшээл үл харгалзан) буюу түгээмэл загварчлалыг ашиглах ёстой үндсэн шалтгаан юм. Ингэж чадвал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрт тухтай хэлбэрээр оролцоогоо хангах боломж бүрдэнэ (жишээ нь, мэдээллийг ихэвчлэн инфографикаар харуулдаг ч энэ нь хүн бүрд ойлгомжтой, хүртээмжтэй байдаггүй.) |
| **Баримт шалгах** | |
| **Мэдээлэл цуглуулах, санал хүсэлт авахдаа тэгш хамруулах** | • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэгш хамруулах судалгаа авах боломжтой судалгааны арга хэлбэр, хэрэгсэл, үйл явцыг боловсруулах, тэднийг судалгаа, ярилцлагад оролцож үзэл бодол, дуу хоолойгоо хүргэх боломжоор хангах. Мөн санал сэтгэгдлээ илэрхийлэх боломжийг ч нээлттэй болгох ёстой. |
| **Баримт шалгах** | • Хөгжлийн бэрхшээлийн асуудлуудын талаарх баримтад тулгуурлах. Судалгааны төлөөллийн бүлгээ зөв тодорхойлох.<br>• Бүтээсэн контентын үнэн зөв байдлыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хуваалцсан үзэл бодол, холбогдох мэргэжилтнүүд болон хөгжлийн бэрхшээлийн салбарын холбогдох байгууллагуудын байр суурийг сонсож шалгаж баталгаажуулах. |
| **Урьдчилж тооцоолоогүй үр дагавруудыг үнэлэх** | |
| **Дүрслэлийн хүртээмжийг хангах** | • Эрэн сурвалжлах мэдээлэл нь интерактив медиа, инфографик, газрын зураг, комикс, зураг, бусад мэдээллийн дүрслэлийн элементүүдийг агуулсан байх нь олонтоо. Гэхдээ эдгээрийг тусгай хэрэгсэл ашиглан ойлгох эсвэл хүртээмжтэй болгоход амаргүй байдаг.<br>• Контентыг уншихад хялбар форматаар танилцуулах буюу дүрслэлээр илэрхийлсэн мэдээллийг хялбар ойлгомжтой болгох арга ашиглах. Шаардлагатай тохиолдолд (жишээ нь, телевизийн хувьд), дэлгэц дээр гарч буй дүрслэл дэх мэдээллийг нэвтрүүлэгч тайлбарлаж хэлэх ёстой. |
| **Сэтгэл түгшээм зураглалаас зайлсхийх** | • Хүнд нөхцөлд байгаа хүмүүс төдийгүй ер нь үзэгчдэд сэтгэл түгшээж, цочроосон дүр дүрслэлийг тухай заавал үзүүлэх нь тухайн мэдээ, сурвалжилгад үнэхээр зайлшгүй юу гэдгийг анхаарч үзэх. Сэтгүүлч, мэргэжилтнүүдийн хувьд ч тэр сэтгэл зүйд хүнд агуулга, дүрслэлүүдийг олон удаа үзэх нь дам байдлаар сэтгэл зүйн дарамт үүсгэж болно.<br>• Шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйн тусламж авахаас битгий цааргалаарай.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ярилцлага хийхдээ сэтгэл зүйн дарамт үүсгэлгүй сурвалжлах аргуудын талаар суралцсан байх. |
| **Сэтгэл зүйд сөрөг нөлөөлөхүйц аудио ашиглахаас зайлсхийх** | • Аудио, дуу шуум нь сэтгэл зүйд сөрөг нөлөөтэй эсэхийг үнэлэх.<br>• Сэтгэл түгшим дүрслэлийг харуулахгүйгээр зөвхөн дууг нь тоглуулж болно. Гэхдээ энэ нь мөн сэтгэл зүйд сөрөг нөлөөтэй байх боломжтой. Хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд болон хөгжлийн бэрхшээлтэй үзэгчид, тухайлбал хараагүй хүмүүс ч мөн ийм төрлийн сөрөг нөлөөнд өртөж болзошгүй. |

## Хүснэгт 11. Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ярилцах нь

| Ажлын жагсаалт | Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ярилцах нь |
|---|---|
| **Ажил** | **Тайлбар** |
| **Ярилцахад тохиромжтой орчныг бүрдүүлэх** | • Хангалттай хугацаа гаргах. Хөгжлийн бэрхшээлтэй зарим хүнтэй харилцахад илүү их хугацаа шаардлагатай байж болно.<br>• Ярилцлага өгөх хүнээс хаана уулзахыг хүсэж байгаа болон түүнд туслалцаа шаардлагатай эсэхийг асуух (жишээ нь, тэргэнцэртэй очих боломжтой газар, ярилцлага хийх чимээгүй орчин, нэмэлт цаг хугацаа эсвэл хэлмэрч). Эдгээрийг ярилцлага хийхээс өмнө тодруулсан байх ёстой. |
| **Зочноо нэн тэргүүнд тавих** | • Хөгжлийн бэрхшээлтэй зочноо мэдээллийн эх сурвалж гэж үзэж, ярилцлагыг тэдний хэмнэлийн дагуу өрнүүлэх.<br>• Хөгжлийн бэрхшээлээс нь илүү тухайн хүний нийгмийн болон мэргэжлийн туршлагад анхаарлаа төвлөрүүлэх. |
| **Харц, нүд тулгарах** | • Ярилцлагад оролцогч руу шууд харж ярих. Хэрэв камертай бол өөрөө ярилцагчийн түвшинд суух, камерыг зочны харааны түвшинд байрлуулах. |
| **Дохионы хэл** | • Ярилцлагын үеэр дохионы хэлмэрч эсвэл аман орчуулагч байж болно.<br>• Сонсголгүй хүнтэй ярилцахдаа хэлмэрч рүү биш гол ярилцагч руугаа төвлөрөх.<br>• Анхаарлыг хэлмэрчид биш, хөгжлийн бэрхшээлтэй хүнд төвлөрүүлэх ёстой. |
| **Өөрийгөө танилцуулах/ тайлбарлах** | • Хараагүй, харааны бэрхшээлтэй эсвэл хараагүй болон сонсголгүй хүнтэй уулзаж байгаа бол өөрийгөө болон хамт байгаа хүмүүсээ танилцуулах.<br>• Хэрэв та нийтийг хамарсан арга хэмжээн дээр байгаа бол ярихын өмнө өөрийгөө болон хэн ярьж байгааг тогтмол танилцуулах хэрэгтэй, ингэснээр хараагүй хүн ч харилцан ярианд идэвхтэй оролцох боломжтой.<br>• Харааны бэрхшээлтэй хүнтэй уулзахдаа өөрийгөө дүрслэн танилцуул (жишээ нь, өндөр, хүйс, нас, хувцаслалт, хөгжлийн бэрхшээл болон бусад хувийн шинж чанарууд).<br>• Тухайн хүний хөгжлийн бэрхшээлийг хэрхэн тодорхойлж, хувийн мэдээллийг нь яаж ашиглаж болох талаар өөрөөс нь асуух. |
| **Хөтөч амьтантай зохих ёсоор харилцах** | • Туслах амьтан болон хөтөч нохой бол ажил, үүргээ гүйцэтгэж байгаа амьтан.<br>• Тийм учраас амьтантай нүдээр харилцаа тогтоох, магтаал хэлэх, ярихаас зайлсхий. Энэ нь амьтан болон эзний анхаарлыг сарниулдаг. |
| **Тусгай орчин хэрэгтэй эсэхийг асуух** | • Нийтийн аливаа арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тусгай зориулалтын орчинд суудаг. Мөн хэлмэрчид өрөөний урд зориулалтын хэсэгт байрладаг. |

## Хүснэгт 12. Энгийн асуултууд

| Ажлын жагсаалт | Энгийн асуултууд |
|---|---|
| •Би тантай илүү тухтай ярилцахын тулд яавал дээр вэ? | |
| •Тантай ярилцахад илүү тохиромжтой санал болгох газар, орчин, тохитой газар бий юу? Цаг хугацааны хувьд хэзээ тохиромжтой вэ? | |
| •Бид аман эсвэл бичгээр гэхчлэн ямар байдлаар ярилцвал танд таатай вэ? | |
| •Та өөрийгөө хэрхэн тодорхойлдог вэ? Өөрийгөө илэрхийлдэг нэр томьёо байгаа юу? | |
| •Таны хөгжлийн бэрхшээлийг хэрхэн тайлбарлахыг хүсэж байна вэ? Энэ нь таны өдөр тутмын амьдралд хэрхэн нөлөөлдөг вэ? | |
| •Таныг зураг, видеонд яаж гаргавал зүгээр вэ? | |

## Хүснэгт 13. Хямралын үед хүртээмжтэй сурвалжлах нь

| Ажлын жагсаалт | Хямралын үед хүртээмжтэй сурвалжлах нь |
|---|---|
| **Ажил** | **Тайлбар** |
| **Үзэгчдэд хамааралтай, шударга байж, алагчлалгүй хандах** | • Хямралт нөхцөл байдал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэрхэн нөлөөлж байгааг авч үзэн, тэдний үзэл бодол, санал, байр суурийг хэвлэл мэдээллийн агуулгад тусгах.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдээллийг орхигдуулахгүй байх. |
| **Хэлэх гэсэн санаагаа зөв гаргах** | • Санаагаа зөв илэрхийлж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон олон нийтийн даван туулах чадварыг онцлон тэмдэглэх.<br>• Олон талт байдал, олон давхар бэрхшээл учирч байх вий гэдгийг анзаарах. |
| **Баримтыг шалгах** | • Хямралын үед буруу мэдээлэл болон худал мэдээлэл давамгайлдаг учир баримтыг бүх талаар шалгах, нягтлах.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг найдвартай, үнэн зөв эх сурвалж гэж үзэх. |
| **Нийтэд хүртээмжтэй мэдээллээр хангах** | • Мэдээллийг олон төрлийн хүртээмжтэй формат болон сувгуудаар, үүнд олон нийтийн сүлжээ зэрэг орчинд хүргэх. Ингэснээр өөр өөр хэрэгцээтэй, өөр өөр нөхцөл байдалтай хүмүүст хүрэх боломжтой болно.<br>• Мэдээллийг хэрэгтэй хүмүүст хүргэхийн тулд бичвэр тайлбар, зохиол, дохионы хэл, нэмэлт текст, өндөр ялгаралтай текст, уншихад хялбар пиктограм, энгийн хэллэг, дохионы хэлмэрч гэх мэт хүртээмжийн хэрэгслүүдийг ашиглах. |
| **Дохионы хэл ашиглах** | • Эрүүл мэнд болон онцгой байдлын мэдээллийг хүргэхдээ чадварлаг дохионы хэлмэрчтэй байх нь чухал |
| **Эмзэг үг хэллэг, дүрслэлүүдийн талаар анхааруулах** | • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүндэтгэлтэй хандаж, жендэрийн мэдрэмжтэй, хэвшмэл ойлголтоос ангид дүрслэлүүдийг сонгох.<br>• Эмзэг контент, дүрслэлүүдийг хуваалцахдаа, үзэгчдэд урьдчилан мэдээлэх, ялангуяа хүүхдүүд болон сэтгэл зүйн хямралд өртсөн хүмүүст.<br>• Үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглэсэн далд үзэн ядалтын үг хэллэгийн утгыг олон нийтийн өмнө нээлттэй шүүмжлэх. |
| **Хэрэглээнд шаардлагатай мэдээлэл өгөх, тухайн контентын бичмэл хувилбарыг хуваалцаж, гол санаагаа давтан хүргэх** | • Хүмүүнлэгийн тусламж, аюулгүй хоргодох байр эсвэл нүүлгэн шилжүүлэх орон байр, хоол хүнс, анхны тусламж, хамгаалалтын арга хэмжээ зэргийг хаанаас олох талаар бодитой мэдээлэл хүргэх.<br>• Газар хөдлөлт зэрэг үйл явдлын дараа хэрэв боломжтой бол төрийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг хэвлэл мэдээлэл, олон нийтийн тусын тулд шууд хүргэх. Эдгээрийг эх мэдэгдлийг сонсоогүй эсвэл мэдээллийг бүрэн авч чадаагүй хүмүүст зориулан дахин давтаж хүргэж байх. |
| **Эрэн сурвалжлах, ил тод байдлыг хангаж хариуцлагатай байх** | • Хямралын үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусламж үзүүлэхэд оролцож буй төрийн байгууллагуудын хариуцлагад хяналт тавих. |
| **Хэвлэл мэдээллийн аль ч хэрэгслээр хүлээж авахад ээлтэй байдлаар тохируулах** | • Контентоо ямар ч төрлийн хэрэгслээр хүргэхэд боломжтой байдлаар бүтээгээрэй. Радио дамжуулалтын дэд бүтэц маш бат бөх бөгөөд бусад харилцаа холбооны технологиуд доголдсон ч ихэнх тохиолдолд хэвийн ажилладаг.<br>• Интернэт холболттой үед, хямралд өртсөн хүн амтай харилцахад чухал хэрэгсэл болох олон нийтийн сүлжээнд зориулж контентоо тохируулах. |

## Хүснэгт 14. Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд хүртээмж нэвтрүүлэх тухай

| Ажлын жагсаалт | Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд хүртээмж нэвтрүүлэх тухай |
|---|---|
| **Ажил** | **Тайлбар** |
| **Шинэ бодлого хэрэгжүүлэх** | • Платформууд, контент, үйлчилгээ үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого, удирдамжийг батлах. Мөн ажлын урсгал, ажлын орчинд нийцтэй бодлого боловсруулах шаардлагатай.<br>• Бодлого нь дангаар хэрэгжих эсвэл өргөн хүрээний стратеги, хөтөлбөрүүдийн хавсарга байдлаар хэрэгжих эсэхийг шийдэж, тодорхой зорилтуудыг дэвшүүлэх. |
| **Хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгчдийг оролцуулах** | • Хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгчидтэйгээ эргэх холбоотой байж тэднийг ажилд авч, шийдвэр гаргахад оролцуулж, хэвлэл мэдээллийн контентын хүртээмжийг тэднээс асууж, шалгах. Үүний тулд шинэ бодлого боловсруулах, эсвэл ажилд авах болон ажилд орох үйл явцыг эргэж харах шаардлагатай байж магадгүй (Гарын авлагын 3-р хэсэгт тусгасан). |
| **Хэвшүүлэх** | • Бүх контент үйлдвэрлэл, хөтөлбөрийн зохион байгуулалт, түгээх үйл явцад түгээмэл загварчлалын зарчмуудыг нэгтгэх. |
| **Зохистой орчин бүрдүүлэх** | • Хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээг харгалзан үзэж тухайн хүн эрх тэгш, бүрэн дүүрэн оролцоход шаардлагатай дүрэм, үйл ажиллагааны нөхцөл, орчин нөхцөлийг хангах. |
| **Төсвийн хуваарилалт хийх** | • Техникийн чадавхыг нэмэгдүүлэх программ хангамж, хэрэгслүүдийг худалдан авах болон ажилтнуудын сургалт, хяналтад зориулсан төсвийн хуваарилалт хийх. |
| **Мэдлэг ойлголтыг дээшлүүлэх** | • Хөгжлийн бэрхшээл болон техникийн стандартуудыг хэрэгжүүлэх хэрэгцээний талаар мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, үүнд шинэ ур чадвар, сургалт шаардлагатай байж болох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй мэргэжилтнүүдийг илтгэгчээр урьж оролцуулах. |
| **Чадавхыг бэхжүүлэх** | • Ажилтнуудыг зохих хэрэгсэл, практикт сургаж дадлагажуулах.<br>• Түгээмэл загварчлал болон дижитал хүртээмжтэй байдалтай холбоотой богино болон урт хугацааны сургалт, чадавхжуулах семинаруудыг зохион байгуулах. |
| **Технологийн дэвшлийг нэгтгэх** | • Технологийн шийдлүүдийг судалж хиймэл оюун ухаанд суурилсан шийдлүүд болон AR, VR технологиудыг ашиглан контентын хүртээмжийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг сайжруулах. |
| **Сайн туршлагыг хуваалцах** | • Ажилтнууд хүртээмжийн талаар мэдээлэл солилцох, хэлэлцэх чат өрөө эсвэл бусад дижитал форумыг бий болгох. |
| **Ахиц дэвшлийг хянах** | • Хүртээмжийн асуудлуудыг хурдан илрүүлэх, засах санал хүсэлтийн систем бий болгох.<br>• Үйл ажиллагааг хүртээмжийн стандарт болон хуульд нийцүүлэн хянаж, шинэчлэх. |

## Хүснэгт 15. Хүртээмжтэй хэвлэмэл контент

| Ажлын жагсаалт | Хүртээмжтэй хэвлэмэл контент |
|---|---|
| **Ажил** | **Тайлбар** |
| **Контентын бүтэц** | • Товьёог, хуудасны дугаар гэх мэт чиглүүлэх хэрэгслийг ашиглах. |
| | • Мэдээллийг жагсаан задалж, гарчиг, дэд сэдэв, жагсаалтуудаар ангилах. |
| | • Нарийн төвөгтэй мэдээллийг хүснэгт, графикаар хуваан харуулах. |
| | • Товьёог, сэдвийн тайлбар, хуудасны дугаар зэрэг чиглүүлэх хэрэгслийг ашиглах. |
| | • Хүснэгтийг энгийн байлгаж, багана эсвэл мөрийн гарчгийг тодруулан, хүрээг тодруулах |
| | • Энгийн хэллэг ашиглаж, техникийн нэр томьёо болон товчлолоос аль болохоор зайлсхийх. |
| **Дизайныг тохиромжтой байдлаар өрөх** | • Arial, Sans Serif эсвэл Verdana гэх мэт фонтуудыг ашиглах, доод тал нь 12-оос дээш хэмжээтэй байх. |
| | • Мөр хоорондын зай (1.5 эсвэл 2) болон бичвэрийг зайг өргөн хийгээрэй. |
| | • Цагаан зай буюу агаар ашигла. |
| | • Өндөр ялгаралтай байлгах, жишээлбэл, цагаан дэвсгэр дээр хар текст. |
| | • Текстийг хэл, бичгийн бүтцээс хамааран зүүн эсвэл баруун талд нь тэгшлэх. |
| **Хэвлэлтийн горимыг тохируулах** | • Мат гадаргуутай цаас ашиглах. |
| | • Хэвлэсэн баримт бичгийг тэгшхэн байлгахад саад учруулах оёдол, хавчуургаас зайлсхийх. |
| **Олон форматаар хүргэх** | • Хэвлэмэл баримт бичгийн хүртээмжтэй дижитал хувилбарыг QR кодтойгоор санал болгох. |
| | • Дижитал түгээлтэд зориулсан хүртээмжтэй PDF хувилбарыг санал болгож, дэлгэц уншигчид тохирохуйц зөв шошгололт, дүрслэлийн алтернатив текст болон зөв бүтэцтэй гарчгуудыг багтаах. |
| | • Хэрэгцээтэй үед хүртээмжтэй PDF, брайл эсвэл том хэмжээтэй хэвлэмэл форматыг санал болгох. |

## Хүснэгт 16. Хүртээмжтэй видео контент

| Ажлын жагсаалт | Хүртээмжтэй видео контент |
|---|---|
| **Ажил** | **Тайлбар** |
| **Тайлбар санал болгох** | • Аудиог текст хэлбэрээр дэлгэцэн дээр үзүүлэх хадмал текст санал болгох. Таны контентыг цацдаг гуравдагч талын сувгууд болон стриминг платформууд мөн хадмал тексттэй байхыг баталгаажуулах.<br>• Мэдээний хөтөлбөрүүд болон улсын орон даяарх шууд дамжуулалтын арга хэмжээнүүдэд дохионы хэлний орчуулга байлгах.<br>• Хөтөлбөрийн хөтчийг хэвлэмэл болон онлайн хэлбэрээр гаргаж, гар утсанд зориулж хүртээмжтэй форматтай болгох.<br>• Хөтөлбөрт хараааны бэрхшээлтэй хэрэглэгчдэд зориулсан аудио тайлбартай хөтөлбөрүүдийг тодорхой заах. |
| **Орчуулга хавсаргах** | • Алдартай хөтөлбөрүүдэд зориулж аудио тайлбар (өөрөөр хэлбэл, зураг эсвэл үзэгдлийн ярьж тайлбарлах) хавсаргах.<br>• Жилд дор хаяж тодорхой тооны хөтөлбөрүүдэд аудио тайлбар оруулах.<br>• Хэлний хүртээмжтэй байдлын үүднээс олон хэлээр хадмал орчуулга болон дуу оруулга хавсаргахыг хичээх.<br>• Тод, ойлгомжтой хурдтайгаар ярих. |
| **Ашиглах тохиргоонуудыг нь сануулах** | • Тоглуулах хурдны янз бүрийн сонголтуудыг санал болгох. |
| **Текстээ тохируулга санал болгох** | • Тод, уншихад хялбар текстийн фонт, хэмжээг сонгох. |
| **Энгийн байлгах** | • Өндөр контрасттай өнгөний хослол болон өнгөний схем ашиглах. |
| | • Яриаг ойлгоход саад учруулж болох арын дуу чимээг багасгах. |
| | • Хөгжлийн бэрхшээлтэй үзэгчдийн хэрэгцээг хангахын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүний байгууллагуудын оролцоог хангах. |
| **Хүртээмжтэй байдлыг шалгаж, шаардлагатай тохиолдол хэрэгслүүд нэмэх** | • Дижитал телевизийн платформуудад хэрэглэгчид дуртай хөтөлбөрүүдээ тэмдэглэн хурдан ухраах боломж олгохын тулд "дуртай хөтөлбөрөө хадгалах" сонголтыг санал болгоорой.<br>• Хайлт хийх хэсгийг хүртээмжтэй болгох.<br>• Аудиог текст хэлбэрээр дэлгэцэн дээр үзүүлэх, хадмал текст санал болгох.<br>• Таны контентыг цацдаг гуравдагч талын сувгууд болон стриминг платформууд мөн хадмал тексттэй байхыг баталгаажуулах. |

## Хүснэгт 17. Хүртээмжтэй аудио контент

| Ажлын жагсаалт | Хүртээмжтэй аудио контент |
|---|---|
| **Ажил** | **Тайлбар** |
| **Транскрипцийг өгөх** | • Радио нэвтрүүлэг болон подкастуудын текстийг өгч, сийрүүлсэн хувилбарт зөвхөн харилцан яриа төдийгүй, дууны эффект, хөгжмийн тайлбар зэргийг багтаасан эсэхийг шалгаарай. |
| **Тайлбар бичнэ үү** | • Дижитал платформ дээрх аудио контентын хувьд хиймэл оюун ухаанд суурилсан автомат тайлбарын хэрэгслийг ашиглах талаар судлаарай. |
| **Энгийн хэллэг хэрэглээрэй** | • Энгийн үгээр, ойлгомжтой ярь. |
| | • Ялангуяа хөтөлбөр эсвэл хэсгийн эхэнд удаан ярь. |
| | • Яриаг бага зэрэг удаашруулахын тулд харилцан ярианд чимээгүй байх хугацааг сунгаж эсвэл харилцан яриа хооронд зай аваарай. |
| | • Тохиромжтой үед визуал элементүүд болон арын дуу чимээг дүрсэлж, эфирт контекст нэмнэ үү. |
| **Өөр гарын авлагуудыг хуваалцаарай** | • Хөтөлбөрийн гарын авлагыг хэвлэмэл болон онлайн хэлбэрээр ашиглах боломжтой болгож, гар утасны төхөөрөмжид ашиглах боломжтой форматаар оновчлоорой. |
| **Олон платформ дээрх хүртээмжээ байнга туршиж, дээшлүүлээрэй** | • Вэбд суурилсан радиогийн хувьд вэб тоглуулагч дээрх тоглуулах товчлууруудыг гараар идэвхжүүлэх боломжтой эсэхийг шалгаарай. |
| | • Товчнууд болон сумнууд дээрээ шошготой байгаа эсэхийг шалгана уу. |
| | • Дижитал радио платформуудад хэрэглэгчид дуртай хөтөлбөрүүдээ тэмдэглэн хурдан буцах боломж олгохын тулд "дуртай хөтөлбөрөө хадгалах” сонголтыг санал болгоорой. |
| | • Хайлтын функц бас хүртээмжтэй байх ёстой. |
| | • Дэлгэц уншигч хэрэглэдэг хүмүүс танай радио хөтөлбөрийг хялбархан сонсож, ашиглаж чадаж байгаа эсэхийг тодруулаарай. |
| | • Тоглуулах хурдыг тохируулах боломжтой байх. |
| **Туршилт хийж, хэрэглэгчдэд зөвлөгөө өгөх** | • Яаралтай мессежний системийн хүртээмжтэй байдлыг туршиж үзээрэй. |
| | • Сонсогчдын хэрэгцээг хангаж байгаа эсэх талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагатай зөвлөлд. |

## Хүснэгт 18. Хүртээмжтэй дижитал контент үйлдвэрлэл

| Ажлын жагсаалт | Хүртээмжтэй дижитал контент үйлдвэрлэл |
|---|---|
| **Ажил** | **Тайлбар** |
| **Хөгжүүлэлтийн эхнээс нь л хүртээмжтэй байдлыг харгалзан үзэх** | • Вэб хуудас бүтээхдээ эхнээс нь хүртээмжийг харгалзан үзэх (дизайн, хуудасны бүтэц төлөвлөх, туршилтын шатуудад). |
| **Нийцтэй байдлыг хангах** | • Бүх функцийг хөдөлгөөний хязгаарлалттай эсвэл дэмжих технологи ашигладаг хүмүүст зориулан гарын товчоор ашиглах боломжтой болгох. |
| **Тайлбар бичих** | • Зураг, товчлуурууд болон холбоосуудад орлуулах текст (алтернатив текст) өгөх. Энэ бол вэбийг хүртээмжтэй болгохын тулд хийх хамгийн энгийн зүйлсийн нэг юм. |
| | • Видеонууд болон шууд дамжуулалтад хадмал текст эсвэл тайлбар нэмэх. |
| **Зохиол хавсаргах** | • Видео болон аудио контентуудыг зөвхөн бичмэл хувилбараар хүлээн авах боломжтой байх. |
| **Ашиглахад хялбар байх** | • Тогтмол, энгийн хэрэглэгчийн интерфейсийг зохиож, дээш, доош гүйлгэх үйлдлийг хялбар болгох. Жишээ нь, дээш, доош гүйлгэх удирдлага эсвэл цэс нь бүх хуудсанд адилхан байршилтай байх ёстой. |
| | • Видеоны автоматаар тоглуулах функцийг унтраах. |
| | • Тоглуулах хурдыг тохируулах сонголтуудыг заавал өгөх. |
| **Өнгө тохируулах** | • Хүртээмжтэй вэбийн удирдамжид дурдсан өнгөний контрастын стандартыг дагах. |
| | • WebAIM Contrast Checker эсвэл Adobe Color Contrast Analyzer зэрэг хэрэгслүүдийг ашиглан өнгөний контраст шаардлага хангаж байгаа эсэхийг шалгах. |
| **Дэлгэцийн зохион байгуулалтыг тохируулах** | • Хүртээмжтэй вэбийн удирдамжид заасан фонтууд, зай болон текстийн хэмжээг дагах. |
| | • Хүснэгтүүд, гарчгууд, догол мөрүүд гэх мэт вэб элементийн тэмдэглэгээнүүдийг дэлгэц уншигчтай нийцтэй болгох. |
| | • Хэрэглэгчдэд фонтуудын хэмжээ, өнгө, харагдах байдлыг өөрчлөх хэрэгслүүдийг өгөх. |
| | • Мобайл төхөөрөмжид зориулан зохион байгуулалтыг тохируулах. |
| **Текстийг тохируулах** | • Урт текстүүдэд зориулан хиймэл оюун ухаанд суурилсан хүний дуу хоолой ашиглан "дуу хоолойгоор унших" функцийг нэвтрүүлэхийг анхаараарай. Энэ нь хэвлэмэл контент уншихад хүндрэлтэй хүмүүст урт бичвэрүүдийг илүү хялбар, ойлгомжтой байдлаар хүлээн авах боломж олгодог. |
| **Хүртээмжийг шалгаж, аудит хийх** | • Вэб сайтын хүртээмж, хэрэглэгдэхүйц байдлыг WAVE, Axe зэрэг автоматжуулсан хэрэгслүүд болон гар аргаар шалгаж үнэлэх. |
| | • Өөр өөр төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгчдээс санал авах. |
| | • Байгууллагад дижитал хүртээмжийн мэргэжилтэн томилох. |

## Хүснэгт 19. DEI Хөтөлбөр эхлүүлэх

| Ажлын жагсаалт | DEI Хөтөлбөр эхлүүлэх |
|---|---|
| **Үе шат** | **Үйл ажиллагаа** |
| **Хамтаараа зөвшилцөж, хам хүрээг тодорхойлох** | Хэрэгжүүлэх арга замтай холбоотойгоор шийдвэр гаргах |
| | • Танай байгууллагад DEI юу болохыг тодорхойлох.<br>• Дээд удирдлага идэвхтэй оролцож, тууштай байхыг баталгаажуулах.<br>• Гүйцэтгэлийн тохиромжтой аргачлалыг сонгож, хамрах хүрээ, үр дүн, үр дагавар, хугацааг тодорхойлох.<br>• Нөөцийг (хүний, санхүүгийн, технологийн) хуваарилах. |
| | Хариуцлага үүрэх болон хариуцах эзнийг томилох |
| | • DEI хариуцсан албан тушаалтан, баг эсвэл төвлөрсөн нэгж (жишээ нь, тодорхой эрх үүрэгтэй этгээд) томилох.<br>• Ажлын байрны тодорхойлолт, албан тушаалын зорилтуудыг тодорхойлж, үүрэг хариуцлагыг шилжүүлэх.<br>• Тайлагналын урсгал, шийдвэр гаргах үйл явцыг тодорхойлох. |
| **Нөхцөл байдлыг судалж, дүгнэж, өгөгдөл цуглуулах** | Одоо хэрэгжиж буй бодлогыг эргэж харах |
| | • Одоогийн бодлого, үйл ажиллагаа, хэрэгслүүд болон үйл явцыг (дотоод, гадаад) зураглах. Үүнд цалинтай болон гэрээт хэвлэл мэдээллийн мэргэжилтэн ажилд авах, ажиллуулах чиглэлээр дотоод удирдамж, журмыг багтаах.<br>• Одоогийн саад бэрхшээлүүд, асуудлууд болон сайжруулах шаардлагатай талуудыг тодорхойлох.<br>• Бүх түвшний ажилтнуудаас (жишээ нь, судалгаа, хэрэглэгчийн туршлага, гомдол, ялгаварлан гадуурхалт болон дарамтын тохиолдлууд) санал авах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар илүү иж бүрэн, төлөөллийг хангахуйц бодлого боловсруулах.<br>• Сайн туршлагуудыг (дотоод, гадаад) цуглуулах. |
| | Одоо дагаж мөрддөг үйл ажиллагаа, явц, нөөц, хэрэгсэлд дүгнэлт хийх |
| | • Оффисын тоног төхөөрөмж, байгууламж, дэд бүтцийг шалгаж, ангилж, бүртгэх.<br>• Хөтөлбөр, үйлчилгээ үзүүлэх ажлын урсгалыг шинжлэх.<br>• Контент бүтээхэд шаардлагатай хэрэгсэл, нөөцүүдийг тодорхойлох.<br>• Одоогийн журам, тэдгээрийн дотор хангамж, гэрээ байгуулах, шинэчлэлт хийх үйл явцын хүртээмжтэй байдлыг хянах, ялангуяа гуравдагч талаас бараа, үйлчилгээ, тоног төхөөрөмж худалдан авахтай холбоотой асуудлыг авч үзэх. |
| **Хөгжүүлэлт** | Баримт бичиг боловсруулах |
| | • Судалгаа, шинжилгээний үр дүнд тулгуурлан баримт бичгийг боловсруулах.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулан холбогдох ажилтнуудыг хамтран үнэлгээ хийхэд урьж оролцуулах.<br>• Ажилтнуудын холбоо, мэргэжлийн холбоо, дотоод ажлын хэсэг, бодлоготой холбоотой хороод болон бусад оролцогч талуудаас (жишээ нь, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага, эрх бүхий байгууллагууд, мэргэжилтнүүд) санал хүсэлт авах.<br>• Баримт бичгийг дээд удирдлагын түвшинд батлах. |

| | |
|---|---|
| | Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөлт |
| | • Зорилгоо хэрэгжүүлэхийн тулд тодорхой зорилтууд, шалгуур үзүүлэлтүүд, гүйцэтгэлийн үзүүлэлтүүд болон холбогдох цаг хугацаа, үйл ажиллагаа, шаардлагатай нөөцүүдийг (жишээ нь, хүний, санхүүгийн, технологийн) багтаасан зохих үйл ажиллагааны төлөвлөгөө (жишээ нь, замын зураглал, ажлын төлөвлөгөө) боловсруулах.<br>• Ажилтнуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлох (жишээ нь, салбар дамнасан багууд).<br>• Өөрчлөлтийг хөтлөх манлайлагчийг ажилтнуудын дунд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын дундаас тодорхойлох.<br>• Харилцаа холбооны стратеги боловсруулах (дотоод болон мэргэжлийн зорилтот бүлгүүдэд зориулсан). |
| | Одоо байгаа бодлого, үйл ажиллагаа, арга барилд нэмэлт өөрчлөлт оруулах |
| | • Одоогийн бодлогуудын баримт бичгийг (жишээ нь, хүний нөөц, худалдан авалт, харилцаа холбоо) хянаж, тохируулах.<br>• Дотоод үйл ажиллагааны мэдээлэл харилцаа, материалуудыг засаж өөрчлөх.<br>• DEI зарчмуудыг одоо байгаа бусад бодлого, журам, практикт уялдуулан нэгтгэх.<br>• Өгөгдөл хамгаалалт, нууцлал, аюулгүй байдал, мэдээлэлд хандах зөвшөөрөл, эрүүл мэндийн бүртгэл, яаралтай дугаар, аюулгүй ажиллагааны протокол, дижитал аюулгүй байдал болон бусад сургалтын хөтөлбөрүүд гэх мэт шинэ бодлого, хэрэгсэл, үйл явцуудыг шинэчлэх эсвэл зохион байгуулах. |
| **Хэрэгжүүлэх** | DEI хөтөлбөрийг ажилтнуудад таниулах, ач холбогдлыг ойлгуулах |
| | • Ажилтнууд болон холбогдох оролцогч талуудад бодлого, хэрэгжүүлэлтийн арга хэмжээнүүдийн талаар мэдээлэх зорилгоор нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулах (жишээ нь, ажилтнуудын уулзалт, удирдах зөвлөлийн хурал).<br>• Ялгаварлан гадуурхалт, дарамт шахалт эсвэл зохистой орчны талаар гаргасан гомдлыг шийдвэрлэх тодорхой бодлого, журмуудыг тогтоох.<br>• Авч байгаа арга хэмжээний талаар явцын мэдээлэл цуглуулах (жишээ нь, санал хүсэлт).<br>• DEI-ийн хэрэгцээ шаардлагыг ажилтнуудын дунд үргэлжлүүлэн таниулах.<br>• Урамшуулалт хөтөлбөр болон туршлага хуваалцах хамтын бүлгүүдийг бий болгох.<br>• Ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээнд DEI зарчмыг тусгах.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах байгууллагууд, үйлчилгээ үзүүлэгчид болон бусад оролцогч талуудтай үнэ цэнтэй түншлэл бий болгох.<br>• Гадны байгууллагуудын DEI бодлогын үр дүнг сурталчлах (жишээ нь, маркетинг болон нийгмийн хариуцлага). |
| | **Гүйцэтгэлд шаардлагатай шинэ нөөц бололцоог хөгжүүлэх** |
| | • Шинэ удирдамж болон баримт бичгүүдийг боловсруулах (жишээ нь, тэгш хамруулах үг хэллэгийн гарын авлага, редакцын бодлого, хөтөлбөрийн болон үйлдвэрлэлийн удирдамж, хэвлэл мэдээллийн контентын хүртээмжийн талаарх удирдамж).<br>• Эдгээр баримт бичгүүдийг ашиглах талаар ажилтнуудад мэдээлэх. |

| | |
|---|---|
- Үндэсний Сонсголын Бэрхшээлтэй Хүмүүсийн Холбоо: Сонсголын бэрхшээлтэй хүмүүсийг хэвлэл мэдээллээр дүрслэх удирдамж: https://www.nad.org/about-us/position-statements/guidelines-for-media-portrayal-of-the-deaf-community/
- АНУ-ын Хууль Зүйн Яамны Иргэний Эрхийн Хэлтэс: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй үр дүнтэй харилцах удирдамж: https://www.ada.gov/topics/effective-communication/

### Хүртээмжтэй байдлыг хангах удирдамжууд

- ЮНЕСКО: Хүртээмжийн нөөцүүд: https://en.unesco.org/themes/access-persons-disabilities
- ЮНЕСКО, Мэдээллийн Технологийн Боловсролын Институт (IITE) болон W3C Вэб Хүртээмжийн Санаачилга (WAI): "Вэб хүртээмжийн танилцуулга" нээлттэй онлайн сургалт: https://www.edx.org/course/web-accessibility-introduction
- BBC Хүртээмжийн Удирдамжууд: https://www.bbc.com/editorialguidelines/guidance/visually-and-hearing-impaired-audiences

## Нэр томьёоны тайлбар

***Хандах боломж (Access):*** Хэвлэл мэдээллийн үйлчилгээ болон агуулгад ойртох, ашиглах эсвэл хэрэглэх эрх, зөвшөөрөл, боломж.

***Хүртээмжтэй байдал (Accessibility):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст орчин нөхцөл, тээврийн үйлчилгээ, мэдээлэл, харилцаа холбоо, үүнд мэдээллийн технологи, систем зэрэгт бусадтай адил тэгш байдлаар нэвтрэх боломжийг хангах нөхцөл байдал. Энэ нь мөн бүтээгдэхүүн, төхөөрөмж, үйлчилгээ эсвэл орчин зэрэг нь аль болох олон хүнд, үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байх хэмжээг тодорхойлдог үзүүлэлт юм.

***Цахим үйлчилгээний хүртээмжтэй байдал (Accessibility of electronic services):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 9-р зүйлд Улс орнуудыг "шинэ мэдээлэл, харилцаа холбооны технологи, систем, үүнд интернэтэд хандах боломжийг дэмжих" болон "тэдгээр технологи, системийг хүртээмжтэй байлгахын тулд эхний үе шатнаас эхлэн зохион бүтээж, хөгжүүлж, үйлдвэрлэж, түгээхийг дэмжих" арга хэмжээ авахыг заадаг.

***Хүртээмжтэй хэлбэрүүд (Accessible formats):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 21-р зүйлд Улс орнуудыг "нийтэд зориулагдсан мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохирсон хэлбэрээр цаг хугацаанд нь, нэмэлт зардалгүйгээр хүргэх," мөн "дохионы хэл, брайл үсэг, нэмэлт болон орлуулалттай харилцааны хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрч, хөнгөвчлөхийг дэмжих" арга хэмжээ авахыг үүрэг болгодог.

***Зохицуулалт, өөрчлөлт (Accommodation):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст аливаа үйлдлийг хийж, гүйцэтгэх эсвэл адил тэгш оролцоотой байхад шаардлагатай өөрчлөлтүүдийг хийх явдал. Хэвлэл мэдээллийн салбарт дэмжлэг үзүүлэх технологи, уян хатан хуваарь, хэлмэрчид зэрэг зохицуулалтууд багтдаг.

***Орлуулалт/Нэмэлт текст буюу Alt текст (Alternative text or Alt text):*** Хараагы бэрхшээлтэй хүмүүст зориулан зургийн утга агуулгыг дүрсэлж уншигч программд уншуулах бичвэр. Мөн хайлтын системд индексжүүлэгддэг.

***Дэмжлэг үзүүлэх технологи (Assistive technology):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нэмэлт хүртээмж олгох тоног төхөөрөмж, жишээлбэл, дэлгэц уншигч, томруулагч болон сонсголын аппарат.

***Аудио тайлбар (Audio descriptions):*** Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулан видео эсвэл телевизийн контентын чухал дүрслэлийг тайлбарлаж өгөх.

***Брайл үсэг (Braille):*** Харааны бэрхшээлтэй хүмүүст товгор цэгүүдээр үсэг үүсгэдэг систем.

**Өргөн нэвтрүүлгийн хэрэгсэл (Broadcast media):** Доод тал нь тайлбар, дохионы хэл эсвэл аудио тайлбараар дамжуулан хүртээмжтэй байлгах боломжтой.

***Тайлбар текст (Captioning):*** Видео эсвэл аудио контентыг ойлгоход шаардлагатай ярианы болон ярианы бус аудио мэдээллийг текстээр харуулах. Энэ нь сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулсан хүртээмжийг хангадаг.

***Конвенц (Convention):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (2006) нь нийгмийн хөгжлийн тодорхой хэмжүүр бүхий хүний эрхийн баримт бичиг юм.. Төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүх эрхийг хүндэтгэж, тэдэнд эрх тэгш байдал олгохыг батагтадаг.

***Хууль дүрмийг мөрдөх байдал (Compliance):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах хуулиуд болон бодлогуудаар тогтоосон стандарт, зохицуулалтыг хангах үйл явц.

***Хямралын үеийн мэдээлэл (Crisis coverage):*** Байгалийн гамшиг, эрүүл мэндийн тахал зэрэг хямралт нөхцөл байдлын үеийн хэвлэл мэдээллийн мэдээлэлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үзэл бодол, дуу хоолойг тусгаж, тэдэнд зориулсан олон улсын стандарт, эрхийн тухай конвенц зэрэг норматив баримт бичигт нийцүүлэн зохицуулах шаардлагатай.

***Олон ургалч байдал, эрх тэгш байдал болон оролцоог хангах (Diversity, equity/equality, and inclusion - DEI):*** DEI бол аливаа ажлын орчныг үнэнч, тэгш, дэмжлэгтэй болгох талаар ярихад ашиглагддаг ерөнхий нэр томьёо юм. DEI бодлого болон үйл ажиллагаа нь байгууллагад (үүнд хэвлэл мэдээллийн байгууллагууд орно) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг орхигдсон бүлгийн төлөөлөл, оролцоо, эрх тэгш байдлыг хангахын тулд зохицуулагдан, нэвтрүүлэгддэг.

***Цахим хүртээмжтэй байдал (Digital accessibility):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст цахим хэрэгслүүдийг үр дүнтэй ашиглах, онлайн мэдээлэлд хандах боломж олгох хүртээмжийн онцлог болон стандартын дагуу нийцсэн чанар.

***Хөгжлийн бэрхшээл (Disability):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь урт хугацааны физик, оюун санааны, оюуны эсвэл мэдрэхүйн бэрхшээлтэй бөгөөд энэ нь янз бүрийн саад бэрхшээлүүдтэй харилцан үйлчилснээр тэдний нийгэмд бүрэн бөгөөд үр дүнтэй оролцох боломжийг хязгаарлах магадлалтай. (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц)

*Бие махбодын (Physical):* Хүний хөдөлгөөн, биеийн үйл ажиллагааг хязгаарладаг бэрхшээл. Жишээ нь тархины саа болон олон хавдар (multiple sclerosis).

*Сэтгэл санааны (Mental):* Хүний оюун санаа, сэтгэл хөдлөл, зан авирт клиникийн саад учруулдаг бэрхшээл. Жишээ нь сэтгэлийн дарамт болон хоёр туйлт сэтгэцийн өвчин.

*Оюуны (Intellectual):* Хүний суралцах чадвар болон өдөр тутмын амьдралдаа гүйцэтгэх чадвар нь хязгаарлагддаг бэрхшээл. Жишээ нь аутизм болон даун синдром.

*Мэдрэхүйн (Sensory):* Сонсгол, хараа, мэдрэмж, үнэр болон амтлах мэдрэхүйд нөлөөлдөг бэрхшээл. Жишээ нь хараагүй, сонсголгүй эсвэл сонсголын бэрхшээл.

***Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголт (Disability awareness):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар ойлголт, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулдаг боловсрол болон сургалтын үйл ажиллагаа. Үүнд тохиромжтой нэр томьёо, хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар, зохицуулалт болон хууль ёсны үүрэг хариуцлага зэрэг ордог.

***Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэгш хамруулах, оролцуулах (Disability inclusion):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон талт байдлыг хүндэтгэн оролцуулж, тэдний эрхийг байгууллагын үйл ажиллагаанд тусган, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг хөндсөн хөтөлбөрүүдийг хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын дагуу оролцоог хангах.

**Хөгжлийн бэрхшээлийн тэгш байдал (Disability equality):** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, боломж, зохицуулалт болон хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа, агуулга, ажиллах хүчний оролцоонд тэдний эрхийг тэгш байдлаар хангах.

***Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх (Disability rights):*** Хүн төрөлхтний нэр хүнд, тэгш байдал, бие даасан байдал, ялгаварлан гадуурхалгүй байдал болон нийгэмд оролцох боломжийг дэмжих эрхүүд бөгөөд үүнд хэвлэл мэдээлэл нь дэмжих үүрэгтэй оролцдог.

***Хөгжлийн бэрхшээлд суурилсан ялгаварлан гадуурхал (Discrimination on the basis of disability):*** Хүний эрх болон үндсэн эрх чөлөөг улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, соёлын болон бусад салбарт ижил тэгш үндсэн эдлэхэд саад учруулдаг, ялгаварлан гадуурхах аливаа ялгаварлал, гадуурхал болон хязгаарлалт. Энэ нь бүх хэлбэрийн ялгаварлалыг хэлэх бөгөөд зохих зохицуулалт хийхээс татгалзахыг ч тооцдог.

***Олон талт байдал (Diversity):*** Ялгаатай байдлыг ойлгож хүлээн авах, чин үнэнээр хүндэтгэх нь олон ургалч байдлын нэгээхэн хэсэг юм. Ардчилсан нийгэм эсвэл систем нь хүний эрх болон нэр төрийг хүндэтгэхийн тулд олон талт байдлыг үнэлж, дэмждэг бөгөөд үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог дэмжин тусгаж өгдөг.

***Редакцын бие даасан байдал болон хүртээмжтэй редакцын бодлого (Editorial independence and inclusive editorial policies):*** Редакторуудыг мэргэжлийн эрх чөлөөтэйгөөр редакцын бодлого болон мэргэжлийн өргөн стандартын хүрээнд редакцын шийдвэр гаргахад нь баталгаа болдог. Үүнд дотоод үйл ажиллагаа, нийтэлж буй агуулга болон редакцын үйл ажиллагаа, удирдлагын дадал зуршилд олон талт байдал, эрх тэгш байдал болон тэгш хамруулах зарчмуудыг тусгаж, хэвлэл мэдээллийн байгууллагын өмчлөгч эсвэл төрийн болон төрийн бус бусад оролцогчдын оролцоогүйгээр шийдвэр гаргадаг.

***Цахим программын хөтөч (Electronic programme guides):*** Энэ хөтөч нь дамжуулах болон цацах хуваарьтай программууд, түүнчлэн шаардлагатай үед олох боломжтой агуулгын жагсаалтуудыг агуулдаг.

***Тэгш байдал (Equality):*** Хүний нас, хүйс, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл болон үндэс угсаанаас үл хамааран бүх хүнд ижил эрх эдлэх боломжийг олгох тухай ойлголт. Энэ нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан суурь зарчим бөгөөд "хүн төрөлхтний нэр хүнд болон тэдний эрх, эрх чөлөөг тэгш үндсэн дээр хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс болон дэлхийн энх тайвны үндэс юм" гэж тодорхойлсон байдаг.

***Уян хатан ажлын зохицуулалт (Flexible working arrangements):*** Уян хатан ажлын зохицуулалтын бодлого нь хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудад ажил, амьдралын шаардлагыг зохицуулахад дэмжлэг үзүүлэх өргөн цар хүрээтэй санаачилгын нэг хэсэг юм. Энэ нь ажлын хуваарьт өөрчлөлт оруулах, алсын зайнаас ажиллах эсвэл байгууллагаас санал болгосон өөр хувилбаруудыг багтаадаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудад зориулсан зохицуулалтыг хангадаг.

***Ажилд авах болон танилцуулах үйл явц (Hiring and onboarding practices):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд оролцуулахад дэмжлэг үзүүлэх зорилготой оролцоотой, уян хатан үйл явц, хэрэгсэл, материал, сургалт болон бусад зохицуулалт багтсан ажилд авах болон танилцуулах үйл явц.

***Хүний эрх (Human rights):*** Хүн төрөлхтний нэр хүнд, өөрийгөө үнэлэх чадварыг хамгаалахад шаардлагатай эрх, хамгаалалтуудын цогц. Эдгээр эрхийг үндэсний болон олон улсын баримт бичгүүдэд тусгасан байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон бусад бүлгийн эрх нь нийгмийн буурай, гадуурхагдсан хүмүүсийг хамгаалах зорилготой байдаг. Хэвлэл мэдээллийн байгууллагууд нь хүний эрхийг зөрчсөн үйлдлийг хөндөж, сурвалжлах үүрэгтэй бөгөөд өөрсдийн үйл ажиллагаа, удирдлагын үйл явцдаа хүний эрхийг хүндэтгэх ёстой.

***Тэгш хамруулах (Inclusion):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хэвлэл мэдээллийн агуулга, ажиллах хүч болон үйл ажиллагаанд тэгш оролцуулах идэвхтэй, зорилтот хүчин чармайлт. Тэгш хамруулах гэдэг нь хүн бүрийг угтан авч, үнэ цэнтэй гэж үзэх орчин буюу орон зай (жишээ нь, байгууллага) бүрдүүлэхийг хэлнэ.

***Хүртээмжтэй хэл (Inclusive language):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг тайлбарлахдаа хэрэглэдэг, тэдний нэр төрийг хүндэтгэн дэмжих, хэвшмэл ойлголтоос зайлсхийх үг, хэллэг, нэр томьёо. Хэвлэл мэдээллийн байгууллагууд үүнийг хэрэглэх ёстой.

***Хүртээмжтэй дүрслэл (Inclusive portrayals):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг олон талт, идэвхтэй хувь хүмүүсийн хувьд харуулж, тэдний чадвар, амжилтыг онцлон, хэвшмэл ойлголтоос зайлсхийсэн сурвалжилга, түүхүүд.

***Олон талт сурвалжилга (Intersectional reporting):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хэвшмэл ойлголтоос зайлсхийж, чадвар, ололт амжилтыг нь онцолж, идэвхтэй, бусдын адил хувь хүн гэдгийг дүрслэх.

***Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо (Involvement of persons with disabilities):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын оршил хэсгийн (о) догол мөрөнд "хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бодлого, хөтөлбөрийн талаарх шийдвэр гаргах үйл явцад идэвхтэй оролцуулах боломжийг олгох ёстой" гэж заасан байдаг.

***Ажлын зохицуулалт (Job accommodation):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажлын байранд үр дүнтэй ажиллах боломжийг хангахын тулд ажлын орчинд өөрчлөлт оруулах. Хэвлэл мэдээллийн байгууллагууд зохих ажлын зохицуулалтыг хангах ёстой.

***Хууль эрх зүйн үүрэг (Legal obligations):*** Хэвлэл мэдээллийн байгууллагуудыг зохист өөрчлөлт хийх, ялгаварлан гадуурхахыг хориглохыг шаарддаг хөгжлийн бэрхшээлийн тухай хууль, бодлогын дагуу хүлээх үүрэг хариуцлага..

***Шууд дэмжлэг (Live assistance):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 9-р зүйлд заасны дагуу "олон нийтийн хүртээлд нээлттэй барилга, бусад байгууламжийг ашиглахад хөтөч, уншигч, мэргэжлийн дохионы хэлний орчуулагч гэх мэт шууд дэмжлэг, зуучлалын хэлбэрүүдийг хангах" арга хэмжээ авах.

***Хэвлэл мэдээлэл (Media):*** Энэ нэр томьёо нь дор хаяж хоёр утгаар ашиглагддаг – нийгмийн байгууллагууд болон мэдээллийн хэрэгслүүдийг хэлнэ. Нийгмийн байгууллагуудын хувьд, жишээлбэл, "хэвлэл мэдээлэл" нь сэтгүүл зүйн үнэт зүйлсийн дагуу редакцын боловсруулсан үнэн бодитой мэдээлэл хүргэдэг байгууллагуудыг хэлж болох бөгөөд үүний хариуцлагыг байгууллага эсвэл хууль ёсны этгээдэд хамааруулдаг. Технологийн хувьд, хэвлэл мэдээлэл гэдэг нь мэдээлэл харилцаанд ашигладаг хэрэгсэл болох цаас, радио долгион, кино болон дижитал дамжуулалтыг илэрхийлдэг.

***Хэвлэл мэдээллийн олон талт байдал (Media diversity):*** Энэ нь нэг хэвлэл мэдээллийн байгууллага эсвэл хэвлэл мэдээллийн салбарт багтах олон янзын дуу хоолой, санал бодол, дүн шинжилгээг хэлнэ. Олон талт байдал нь ихэвчлэн өмчлөл, ажилтнууд болон зорилтот үзэгчдийн нарийвчлал эсвэл өргөн хүрээтэй байдлаар тодорхойлогддог. Хэвлэл мэдээллийн олон талт байдал нь хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг багтаасан нийгэм, соёл, улс төрийн олон талт байдлыг хэрхэн тусгаж байгаатай холбоотой асуудлыг агуулдаг.

***Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа (Media operations):*** Хэвлэл мэдээллийн байгууллагууд контент үйлдвэрлэх, засварлах, нийтлэх үйл ажиллагаандаа ашигладаг процессууд, ажлын урсгалууд, ажиллах хүчний хөгжил, хэрэгслүүд болон системүүд бөгөөд эдгээрт хүртээмжийг хангах үйл ажиллагааг нэгтгэх шаардлагатай.

***Хэвлэл мэдээллийн ажилтан, мэргэжилтнүүд (Media professionals):*** Сэтгүүлчид, редакторууд, гэрэл зурагчид, продюсерууд гэх мэт хэвлэл мэдээллийн салбарт ажилладаг хувь хүмүүс бөгөөд зарим нь өөрсдөө хөгжлийн бэрхшээлтэй байж болно.

***Нээлттэй лиценз (Open licence):*** Энэ нь зохиогчийн эрх эзэмшигчийн оюуны өмчийн эрхийг хүндэтгэн, олон нийтэд контентод нэвтрэх, дахин ашиглах, дахин боловсруулах, дасан зохицуулах, дахин түгээх эрхийг олгодог лиценз юм.

***Хүнийг эрхэмлэсэн үг хэллэг (People-first language):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нэрлэхэд өргөнөөр ашиглагддаг хэллэг. Энэ нь мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод хэрэглэгддэг хэл юм. Хүнийг эхэнд тавих хэллэг нь хөгжлийн бэрхшээлээс нь илүү хүнийг онцолдог. Жишээ нь "альбинизмтай хүүхдүүд", "дислекситэй оюутнууд", "оюуны бэрхшээлтэй эмэгтэйчүүд", мөн "хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс" гэх мэт хэллэгүүдийг ашиглаж болно. Гэхдээ энэ дүрэм бүх төрлийн хөгжлийн бэрхшээлд заавал хамаарахгүй. Жишээлбэл, харааны бэрхшээлтэй хүмүүсийг нэрлэхдээ "хараагүй хүмүүс" эсвэл "харааны бэрхшээлтэй хүмүүс" гэж нэрлэж болно, мөн сонсголгүй эсвэл сонсголын бэрхшээлтэй хүмүүсийг мөн адил нэрлэж болно.

***Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс (Persons with disabilities):*** Удаан хугацааны биеийн, сэтгэцийн, оюуны эсвэл мэдрэхүйн бэрхшээлтэй хүмүүсийг хэлнэ. Эдгээр бэрхшээлүүд нь янз бүрийн саад бэрхшээлүүдтэй харилцан үйлчилж, эдгээр хүмүүсийн нийгэмд бусдын адил бүрэн оролцох, үр дүнтэй оролцох боломжийг хязгаарлаж болзошгүй.

***Энгийн хэл (Plain language):*** Агуулгыг хүртээмжтэй болгохын тулд энгийн хэл ашиглахыг зөвлөсөн заавар, танил үгс, богино өгүүлбэр, цаг хугацаа заах энгийн хэлбэрүүдийг ашиглах арга.

***Хувийн нууцыг хүндэтгэх (Respect privacy):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 22-р зүйлд "оршин суугаа газар эсвэл амьдарч байгаа байрныхаа байршлаас үл хамааран хөгжлийн бэрхшээлтэй ямар ч хүнийг өөрийн нууц, гэр бүл, гэр орон, харилцаа холбоо эсвэл бусад төрлийн харилцаа холбоонд хууль бусаар халдах, нэр төр, алдар хүндэд нь халдахыг хориглоно" гэж заасан байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эдгээр халдлагаас хамгаалагдах хууль ёсны эрхтэй.

***Зохист өөрчлөлт (Reasonable accommodation):*** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 2-р зүйлд "хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын адил бүх хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх боломжийг хангахын тулд тухайн тохиолдолд хэрэгцээтэй, зохистой өөрчлөлт, зохицуулалтыг хийх шаардлагатай" гэж заасан байдаг. Энэ нэр томьёо нь байгууллагын түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш хандах боломжийг хангахын тулд хэрэгжүүлж буй зохицуулалт, өөрчлөлтийг хэлнэ.

***Зохицуулалт болон өөрийн зохицуулалтын механизм (Regulation and self-reulatory mechanisms):*** Байгууллагууд болон оролцогчдын зан төлөвийг хянах, удирдах эсвэл нөлөөлөх оролдлогуудыг дүрэм журам, ёс зүйн, хэм хэмжээний кодоор дамжуулан хэрэгжүүлэхэд чиглэсэн оролдлогуудыг хэлнэ. Эдгээр зохицуулалтуудыг ихэвчлэн ардчиллын зарчимд суурилсан бодлого, хууль эрх зүйн хүрээнд хийгдсэн байх ёстой гэж үздэг. Жишээ нь, шударга өрсөлдөөний эсрэг монопол, спектрийн хуваарилалт, хувийн мэдээллийн нууцлал, зохиогчийн эрх, үзэн ядалтын үг хэллэг зэрэг зохицуулалтуудыг хэлж болно. Шууд тухайн байгууллагаас санаачлан хийдэг зохицуулалт нь өөрийн зохицуулалт эсвэл хамтын зохицуулалт гэж нэрлэгддэг бөгөөд иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан бие даасан үнэлгээ, давж заалдах боломжийг бий болгох ёстой. Жишээ нь, олон нийтийн төлөөллийг оролцуулсан хэвлэл мэдээллийн зөвлөлүүд. Эдгээр механизмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдал, хүртээмжийг хангахын тулд хэвлэл мэдээллийн байгууллагуудын өөрийн дотоод бодлого, үйл явцыг хянах, үнэлэх зохицуулалтууд багтана. Олон нийтийн харилцааны талбар дахь ижил төстэй байгууллага болох Facebook-ийн Хяналтын зөвлөлийг жишээ болгон дурдаж болно. "Хамтын зохицуулалт" нэр томьёо нь ихэвчлэн төр, хувийн хэвшлийн хамтарсан

оролцоог хамарсан системийг (кибер аюулгүй байдал, терроризмын эсрэг үйл ажиллагаа, хүүхэд хамгаалал зэрэгт) илэрхийлдэг.

***Мэргэжлийн багц стандарт (Set of professional standards):*** Хэвлэл мэдээллийн байгууллагуудын ажилтан болон нийгмийн эмзэг бүлгийнхэнтэй харилцахдаа дагаж мөрдөх ёстой олон талт байдал, мэргэжлийн ур чадвар болон шударга харилцааны зарчмуудыг тодорхойлсон удирдамжууд. Мэргэжлийн стандартын багц эсвэл ёс зүйн код нь байгууллагуудад олон нийтийн гомдол, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдийн асуудлыг хөндсөн тайлангуудыг хэрхэн зохицуулах дүрмийг тогтоодог.

***Дохионы хэл (Sign language):*** Дохионы хэл нь ярьдаг хэлнээс бүтцийн хувьд ялгаатай, бие даасан байгалийн хэл юм. Олон улсын дохионы хэл (IS) хэмээн нэрлэгддэг хэл нь сонсголгүй хүмүүсийн олон улсын уулзалтууд болон албан бус аялал, нийгмийн харилцаанд оролцоход ашиглагддаг. Энэ нь байгалийн дохионы хэлнүүд шиг нарийн төвөгтэй биш бөгөөд хязгаарлагдмал үгсийн сантай байдаг. Зарим орнуудад өөрсдийн үндэсний дохионы хэл байдаг бөгөөд засгийн газраас албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн, бусад дохионы хэлнүүдээс ялгаатай байдаг. Гэсэн хэдий ч, ихэнх дохионы хэлнүүд нь үндэсний түвшинд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөөгүй олон нийтийн хэлнүүд юм.

***Дохионы хэлээр дуулах (Sign singing):*** Дууг дохионы хэлээр дуулах үйл явц. Ихэвчлэн дуу тоглуулж байх үед оролцогч нь дууны үгийг дохионы хэлээр илэрхийлэн хүргэдэг. Дохионы хэлээр дуулах нь оролцогчийн гар, бие болон нүүрний илэрхийллээр илэрдэг.

***Богино хугацааны хөгжлийн бэрхшээл (Short-term disability):*** Энэ нь 12 сараас бага хугацаанд үргэлжлэх хөгжлийн бэрхшээлийг хэлнэ.

***Бичлэгийн төрөл зүйлийн удирдамж (Style guide):*** Баримт бичиг бичих, форматлах болон зохион байгуулахад хэрэглэдэг стандартуудын багц. Мөн энэ нь тайлан бичихэд ашиглах үг хэллэгийн хэрэглээ, нийтлэг хэв маягуудыг тогтоож, байгууллагын бичгээр нийтлэх бүх ажилд тогтмол ашигладаг лавлах хэрэгсэл юм.

***Түгээмэл загварчлал (Universal design):*** Бүтээгдэхүүн, орчин, хөтөлбөр, үйлчилгээг бүх хүнд аль болох өргөн цар хүрээтэй, тусгай зохион бүтээлийн шаардлагагүйгээр ашиглах боломжтой байхаар зохион бүтээх үйл явц. "Түгээмэл загварчлал" нь шаардлагатай тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тодорхой бүлгүүдэд туслах хэрэгслийг үгүйсгэдэггүй (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, 2-р зүйл).

***Ажиллах хүчний олон талт байдал (Workforce diversity):*** Хэвлэл мэдээллийн ажиллах орчинд бүх түвшний хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг эмзэг бүлгийн хүмүүсийн төлөөллийг хангах.

***Ажлын байрны хүртээмжтэй байдал (Workplace inclusion):*** Хэвлэл мэдээллийн ажлын орчинд хөгжлийн бэрхшээлтэй ажилчдыг хүлээн зөвшөөрөх, дэмжих, тохируулга хийх орчин, бодлого болон соёл

## Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдлыг хангах талаар түгээмэл асуудаг 20 асуулт

1. Хэвлэл мэдээлэл дэх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдал гэж юу вэ, яагаад чухал вэ?
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдалд ашиглагддаг гол ойлголт, зарчим, хэлний төрлүүд юу вэ?
3. Хэвлэл мэдээллийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдлыг хэрхэн хангах вэ?
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдлыг мэдээ сурвалжилга, хөтөлбөрт тусгах тусгай арга барилууд юу вэ?
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдал болон хэвлэл мэдээллийн талаарх хууль ёсны шаардлага, олон улсын стандартууд юу вэ?
6. Хэвлэл мэдээлэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шударга, тэнцвэртэй, эрх тэгш байдлаар хэрхэн төлөөлөх ёстой вэ?
7. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дүрслэх тохиромжтой арга замууд юу вэ?
8. Хэвлэл мэдээллийн байгууллагууд ямар нэр томьёо, хэллэгийг ашиглах эсвэл зайлсхийх ёстой вэ?
9. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд хэрхэн ярилцаж, харилцах ёстой вэ?
10. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг хүчирхийллийн талаар хэвлэл мэдээлэл хэрхэн мэдээлэх ёстой вэ?
11. Хүртээмжтэй хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа яагаад чухал вэ?
12. Хэвлэл мэдээллийн байгууллагууд хүртээмжтэй контентыг хэрхэн бүтээх вэ?
13. Телевиз, радио, хэвлэл, онлайн хэвлэл мэдээллийн хэрэгслийг илүү хүртээмжтэй болгохын тулд юу хийх ёстой вэ?
14. Хэвлэл мэдээллийн контент, хэрэгсэл, бүтээгдэхүүний хүртээмжийг үнэлэх хэрэгслүүд юу вэ?
15. Хямрал, нүүлгэн шилжүүлэлт, байгалийн гамшиг, хүрээлэн буй орчны нөхцөл байдалд хүртээмжийг хэвлэл мэдээллийн байгууллагууд хэрхэн хангах вэ?
16. Хэвлэл мэдээллийн  байранд тэгш хамралтыг дэмжсэн соёл гэж юу вэ?
17. Хэвлэл мэдээллийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй мэргэжилтнүүдийг хэрхэн ажилд авах вэ?
18. Хэвлэл мэдээллийн байгууллагууд ажлын байранд зохист орчныг хэрхэн хангах вэ?
19. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудад ямар ажиллах орчин болон туслах технологиудыг санал болгох ёстой вэ?
20. Хэвлэл мэдээллийн байгууллагууд менежментийн практиктаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдал, олон талт байдал, тэгш хамралтыг хэрхэн хянах вэ?

## Тэмдэглэл


1 Жанис Гассам Асаре, "Сүүлийн үеийн тоо баримтууд хэвлэл мэдээллийн хэрэгсэл ихэнх нь цагаан хүмүүс хэвээр байгааг харуулж байна." Forbes, 2023 оны 4-р сарын 23. https://www.forbes.com/sites/janicegassam/2023/04/23/recent-figures-show-that-media-is-still-overwhelming-white/?sh=6fac08d55bf4

Financial Times стратеги ба Google News санаачилга, олон янз байдлын боломжийг ашиглах: Мэдээний бизнест өсөлтийг бий болгох нь (Лондон: Financial Times Strategies, 2022). https://www.ftstrategies.com/en-gb/insights/seizing-the-diversity-opportunity-enabling-growth-in-the-news-business/

"Яагаад олон талт байдал нь хэвлэл мэдээлэл, энтэртайнмэнтийн хувьд маш чухал вэ, үүнд хэрхэн хүрэх вэ?" Дэлхийн эдийн засгийн форумыг 2021 оны 9-р сарын 27-нд хамгийн сүүлд өөрчилсөн. https://www.weforum.org/agenda/2021/09/how-diverse-is-media-and-entertainment/

2021 оны 3-р сарын 5-нд нийтлэгдсэн "Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, аудиовизуал салбарын жендэрийн тэнцвэр, олон янз байдал, хүртээмжтэй байдал," News and Views, Европын Комисс. https://digital-strategy.ec.europa.eu/en/news/gender-balance-diversity-and-inclusiveness-media-and-audiovisual-sectors

2 2023 оны 3-р сарын 7-нд шинэчлэгдсэн Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ) "Хөгжлийн бэрхшээл," Мэдээллийн хуудас. https://www.who.int/news-room/fact-sheets/detail/disability-and-health

3 "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдээллийн хуудас" НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал хариуцсан хэлтэс, 2022 он. https://www.un.org/development/desa/disabilities/resources/factsheet-on-persons-with-disabilities.html

4 "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдээллийн хуудас" НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал хариуцсан хэлтэс, 2022 он. https://www.un.org/development/desa/disabilities/resources/factsheet-on-persons-with-disabilities.html

5 2023 оны 6-р сарын 13-нд нийтлэгдсэн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ) Статистикийн газар "ОУХБ-ын шинэ мэдээллийн сан нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрийн зах зээлийн сорилтуудыг онцолж байна." https://ilostat.ilo.org/new-ilo-database-highlights-labour-market-challenges-of-persons-with-disabilities/

6 "Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид" НҮБ-Эмэгтэйчүүд, хамгийн сүүлд 2023 онд өөрчилсөн. https://www.unwomen.org/en/what-we-do/women-and-girls-with-disabilities

7 ЮНЕСКО-гийн 2023 оны 5-р сарын 11-нд шинэчлэгдсэн "Боловсролд хамруулах талаар та юу мэдэх хэрэгтэй вэ?" Боловсролд хамруулах. https://www.unesco.org/en/inclusion-education/need-know

8 “Түүхэн тойм,” Хөгжлийн бэрхшээлтэй холбоотой олон улсын хэм хэмжээ, стандартын шинжээчдийн бүлгийн хурал, НҮБ-аас идэвхжүүлэх, хамгийн сүүлд 2004 онд шинэчилсэн. https://www.un.org/esa/socdev/enable/disberk2.htm

ҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн комиссар Франц, Тараах материал 2 – Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн загвар (Парис: НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар, н.д.). https://www.unhcr.org/fr-fr/en/media/handout-2-models-disability

9 НҮБ-Эмэгтэйчүүд ба НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн түншлэл (UNPRPD), Уулзварын нөөцийн гарын авлага ба хэрэгсэл (Нью-Йорк: НҮБ-Эмэгтэйчүүд, 2021) https://www.unwomen.org/en/digital-library/publications/2022/01/intersectionality-resource-guide-and-toolkit

10 ЮНЕСКО-гийн мэдээ, 2021 оны 12-р сард хэвлэгдсэн "ЮНЕСКО Хятад дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдлыг дэмжих зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх шинэчилсэн гарын авлага." https://www.unesco.org/en/articles/unesco-launches-updated-handbook-media-reporting-promoting-disability-equality-china

11 Жанетт Санчес, Хөгжлийн бэрхшээлийн талаарх сурвалжлага: Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зориулсан удирдамж (Женев: Олон улсын хөдөлмөрийн байгууллага, 2015). https://www.ilo.org/skills/pubs/WCMS_127002/lang--en/index.htm

12 "ТВ-ийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хандалт," Британийн өргөн нэвтрүүлгийн корпораци, хамгийн сүүлд 2023 оны 4-р сард өөрчлөгдсөн. https://www.bbc.co.uk/commissioning/diversity-disability-commitments/

"Удирдамж: Хараагы бэрхшээлтэй болон сонсголын бэрхшээлтэй үзэгчид" Редакцийн удирдамж, Британийн өргөн нэвтрүүлгийн корпораци, 2021 оны 3-р сард шинэчлэгдсэн. https://www.bbc.com/editorialguidelines/guidance/visually-and-hearing-impaired-audiences

“Хөгжлийн бэрхшээлийг өөр өнцгөөр харуулах,” 50:50 Эрх тэгш, British Broadcasting Corporation, 2024 он шинэчлэгдсэн. https://www.bbc.com/5050/reframingdisability

13 Кристиан Курц, "Дэлхийн үзэгчид дэлгэцэн дээр илүү сайн төлөөлөлтэй байхыг хүсдэг" Paramount Insights, 2021 оны 10-р сарын 29-нд хэвлэгдсэн. https://insights.paramount.com/post/global-audiences-want-better-representation-on-screen/

14 Чөлөөт хэвлэлд Хязгааргүй “Жендэрийн мэдрэмжтэй сурвалжлага”, Хэвлэл мэдээллийн контент дахь жендэрийн тэгш байдал, Хязгааргүй чөлөөт хэвлэл, 2022 онд шинэчлэгдсэн. https://kq.freepressunlimited.org/themes/gender-equality/gender-in-media-content/gender-sensitive-reporting/

15 НҮБ-Эмэгтэйчүүд,Уулзвар хоорондын нөөцийн гарын авлага ба багаж хэрэгсэл: Хэнийг ч орхигдуулахгүй оглтолцох арга(Нью Йорк: НҮБ-Эмэгтэйчүүд, 2021). https://www.unwomen.org/en/digital-library/publications/2022/01/intersectionality-resource-guide-and-toolkit

16 Анн-Мари Импе, Эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийн тухай сурвалжлага: Сэтгүүлчдэд зориулсан гарын авлага (Парис: ЮНЕСКО, 2019). https://www.unesco.org/en/articles/reporting-violence-against-women-and-girls

17 ЮНЕСКО, Хэвлэл мэдээллийн жендэрийн мэдрэмжтэй үзүүлэлтүүд: Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа, контент дахь жендэрийн мэдрэмжийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийн хүрээ (Парис: ЮНЕСКО, 2012). https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000217831

18 Дина Делигиоргис, Манал Бенкиран, Том яриа: Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шийдвэрлэх гарын авлага (Парис: ЮНЕСКО, Нью-Йорк: НҮБ-Эмэгтэйчүүд, 2019). https://www.unesco.org/en/articles/big-conversation

19 Флорин Марин, Хүйсээ ярьцгаая: Хөгжлийн төлөөх жендэрт нийцсэн харилцааны арван зарчи (Нью-Йорк: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, 2018). https://rm.coe.int/10-principles-of-gender-responsive-communications/1680a4cbb4

20 Мэдээллийн өмчийн мэдээллийн сан (2023),” Онлайн мэдээний холбоо, 2023 оны 5-р сарын 12-нд нийтлэгдсэн. https://journalists.org/resources/information-equity-database-2023/

21 НҮБ, Хүртээмжтэй харилцаа холбоо: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харилцах, тэдний талаар болон тэдэнд зориулсан гарын авлага (Нью-Йорк: НҮБ, 2021). https://www.un.org/sites/un2.un.org/files/2021/10/un_disability_inclusion_strategy_communication_guidelines_etr.pdf

22 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хэлний заавар: Хавсралт I,” НҮБ-ын Женев дэх төлөөлөгчийн газар. https://www.ungeneva.org/en/about/accessibility/disability-inclusive-language/annex-i

23 Аризона мужийн их сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгүүлзүйн үндэсний төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэлний хэв маягийн гарын авлага (онлайн эх сурвалж). https://cronkite.asu.edu/news/2021/ncdj-releases-updated-disability-language-style-guide

24 “Тэ Рео Хапай. Баяжуулах хэл: Сэтгэцийн эрүүл мэнд, донтолт, хөгжлийн бэрхшээлийн салбарт хэрэглэгддэг маори хэлийг шинэчлэх, бий болгох," Те Поу, хамгийн сүүлд 2024 онд шинэчилсэн. https://www.tepou.co.nz/initiatives/te-reo-h%C4%81pai-the-language-of-enrichment

25 "Олон нийт ба соёл - Түгээмэл асуултууд," Сонсголгүй иргэдийн үндэсний холбоо, хамгийн сүүлд 2024 онд шинэчилсэн. https://www.nad.org/resources/american-sign-language/community-and-culture-frequently-asked-questions/

26 Оксфордын Интернет хүрээлэн, Нийгмийн сүлжээн дэх үзэн ядалтын хэллэгийг шийдвэрлэх нь: Орчин үеийн сорилтууд (Парис: ЮНЕСКО, 2021). https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000379177

27 Игинио Гаглиардоне, Данит Гал, Тиаго Алвес, Габриела Мартинез, Онлайн үзэн ядалтын үг хэллэгийг эсэргүүцэх нь (Парис, ЮНЕСКО, 2015), х. 29. https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000233231/PDF/233231eng.pdf.multi “Фэйсбүүк нийгэмлэгийн стандартууд,” Policies,Meta, 2024 онд шинэчлэгдсэн. https://www.facebook.com/communitystandards

28 Европын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн форум, "Үзэн ядсан үг хэллэг, үзэн ядалт гэмт хэргийн талаарх ЕХ-ны санаачилгын талаархи EDF зөвлөмжүүд" (Марин Улдригийн албан тушаалын баримт бичиг), 2021 оны 4-р сар. https://www.edf-feph.org/content/uploads/2021/04/EDF-position-and-recommendation-on-hate-speech-and-Hate-crime.pdf

29 НҮБ-ын Хүүхдийн сан (ЮНИСЕФ), Хөгжлийн бэрхшээлийг хамарсан мэдээлэл үйлдвэрлэх нь: Энэ яагаад чухал, юу шаардлагатай вэ (Нью-Йорк: ЮНИСЕФ, 2020). https://data.unicef.org/resources/producing-disability-inclusive-data-why-it-matters-and-what-it-takes/

30 "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооны танилцуулга" Гэрээний байгууллагууд, НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын (OHCHR) 2023 онд хандсан. https://www.ohchr.org/en/treaty-bodies/crpd/introduction-committee

31 "Хүртээмжтэй байдлын статистик," Канадын статистик, хамгийн сүүлд 2017 онд өөрчлөгдсөн. https://www.statcan.gc.ca/en/topics-start/accessibility

32 Колумбын Их Сургуулийн Сэтгүүлзүйн Сургуулийн Дарт Сэтгүүл зүй, Гэмтлийн Дарт Төв, 2021 оны 6-р сарын 22-нд хэвлэгдсэн "Гэмтлийн мэдээлэлтэй сэтгүүлзүйн дарт төвийн загварын гарын авлага". https://dartcenter.org/resources/dart-center-style-guide

33 Эмили Валкинс, "Хөгжлийн бэрхшээлтэй асуудлыг судлах гарын авлага", Дэлхийн эрэн сурвалжлах сэтгүүлзүйн сүлжээ,2023 оны 3-р сарын 7-нд нийтлэгдсэн. https://gijn.org/resource/guide-to-investigating-disability-issues-introduction-table-of-contents/

34 Европын сонсголын бэрхшээлтэй сэтгүүл зүй (ЕХ-ны санхүүжилттэй төсөл). https://www.deafjournalism.eu/#about

35 "Үл үзэгдэгчийг илчлэх нь” (төсөл), Tactical Tech, 2019 оны 4-р сард шинэчлэгдсэн. https://kit.exposingtheinvisible.org/en/thekit.html

36 НҮБ, "COVID-19-д хөгжлийн бэрхшээлийг хамарсан хариу арга хэмжээ", НҮБ-ын COVID-19-ийн хариу арга хэмжээ. https://www.un.org/en/coronavirus/disability-inclusion

37 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүмүүнлэгийн үйл ажиллагаанд хамруулах дүрэм (Истанбул: Дэлхийн хүмүүнлэгийн Дээд хэмжээний уулзалт, 2016). https://humanitariandisabilitycharter.org/

38 Невадагийн газар хөдлөлтийн аюулгүй байдлын зөвлөл, Газар хөдлөлтийн дараах олон нийтийн аюулгүй байдлын мэдээллийн скриптүүд (Рено: Невадагийн их сургууль). https://nbmg.unr.edu/_docs/Earthquakes/EQmediascripts.pdf

39 Арва Кооли, "Газар хөдлөлтийн талаар мэдээлэхдээ датаг хэрхэн ашиглах вэ," Al Jazeera сэтгүүлзүйн тойм, 2023 оны есдүгээр сарын 19, https://institute.aljazeera.net/en/ajr/article/2341

40 "Нөөц," Хүртээмжтэй технологи, хүрээлэн буй орчны дэлхийн холбоо (GAATES), https://gaates.org/resources/

41 ITU, Яаралтай тусламжийн радио холбоо, https://www.itu.int/en/ITU-R/information/Pages/emergency.aspx

42 ЕХ-ны вэб хандалтын удирдамж – Стандарт ба уялдуулах https://digital-strategy.ec.europa.eu/en/policies/web-accessibility-directive-standards-and-harmonisation

43 Apple компани 2023 оны 5-р сарын 16-нд нийтэлсэн "Танин мэдэхүйн хүртээмжтэй байдлын шинэ функцуудыг танилцуулж байна. Амьд яриа, хувийн дуу хоолой, томруулагчаар ярьдаг" гэж Apple-аас гаргасан хэвлэлийн мэдээ. https://www.apple.com/newsroom/2023/05/apple-previews-live-speech-personal-voice-and-more-new-accessibility-features/

44 Майкрософт корпорацийн блог, "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоглоомыг өөрчлөх боломжтой хиймэл оюун ухаан" ЕХ-ны бодлогын блог, 2023 оны 7-р сарын 10. https://blogs.microsoft.com/eupolicy/2023/07/10/european-accessibility-summit-disabilities-ai/

45 Патрик Клари, "Lookout: хараагүй болон хараан бэрхшээлтэй хүмүүст хүрээлэн буй орчныхоо талаар суралцахад туслах програм" Түлхүүр үг, 2018 оны 5-р сарын 8 https://blog.google/outreach-initiatives/accessibility/lookout-app-help-blind-and-visually-impaired-people-learn-about-their-surroundings/

46 Энтони Катбертсон, “2023 оны дэлхийн хүртээмжийг таниулах өдөр: Apple болон Samsung нар хиймэл оюуны шинэ боломжуудыг эхлүүлсэн” The Independent, 2023 оны 5-р сарын 17. https://www.independent.co.uk/tech/global-accessibility-awareness-day-2023-apple-samsung-b2340697.html

47 Канадын хүртээмжийн стандарт, "Бидний тухай" хамгийн сүүлд 2023 оны 8-р сарын 10-нд өөрчлөгдсөн. https://accessible.canada.ca/about-us#s4

“CAN/ASC - EN 301549:2024 - МХХТ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийн шаардлага,” Канадын хүртээмжийн стандарт, хамгийн сүүлд 2024 онд өөрчлөгдсөн. https://accessible.canada.ca/en-301-549-accessibility-requirements-ict-products-and-services

48 Европын холбоо, "Европын хүртээмжийн тухай хууль (EAA),"Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудал, оролцоо, Европын комисс, 2019 он. https://ec.europa.eu/social/main.jsp?catId=1202#:~:text=The%20European%20accessibility%20act%20is,EU%20leading%20to%20costs%20reduction

49 Сандра Домейж, “Европын хүртээмжийн тухай хууль 2025 – Бизнесүүд юу хийх ёстой вэ,” Цахим худалдааны дизайн b(лог), VAIMO, 2024 оны 2-р сарын 27-нд шинэчлэгдсэн. https://www.vaimo.com/blog/the-european-accessibility-act-2025-what-businesses-need-to-do/#:~:text=The%20European%20Accessibility%20Act%202025%20is%20a%20call%20to%20action-,compliance%20is%20not%20an%20option

50 "NRK TV - Хүн бүрийн дуртай үзвэрийн үйлчилгээ" Норвегийн өргөн нэвтрүүлгийн корпораци (NRK), 2024 онд шинэчлэгдсэн. https://doga.no/en/tools/inclusive-design/cases/NRK-TV/

51 Хүртээмжтэй хэвлэл мэдээллийн хэрэгсэл хийх (MAM) нь Хамбер коллежийн (Канад), 2016 он, Хэвлэл мэдээлэл, бүтээлч урлагийн факультет (FMCA) боловсруулсан. https://humber.ca/makingaccessiblemedia/

52 Сара Бахр, "Цаг хугацааны дүрслэлийг хүн бүрт хүртээмжтэй болгодог редактор" Times Insider, 2024 оны 3-р сарын 24-нд хэвлэгдсэн. https://www.nytimes.com/2024/03/24/insider/an-editor-who-makes-times-visuals-accessible-to-all.html

53 “Нээлттэй ТВ-ээр LIBRAS [Бразилийн дохионы хэл] дэх мэдээллийн болон соёлын контентод хандах,” Харилцаа холбоо, олон нийтийн ил тод байдал, Бразилийн Засгийн газар, хамгийн сүүлд 2024 оны 3-р сарын 15-нд өөрчилсөн. https://www.gov.br/pt-br/servicos/acessar-conteudos-informativos-e-culturais-em-libras-pela-tv-aberta

54 Хууль эрх зүй, захиргааны мэдээллийн газар (Ерөнхий сайд). Хөгжлийн бэрхшээлтэй байдал: төрийн харилцааны хүртээмжтэй байдлын шинэ дүрэм, 2022 оны 10-р сарын 12. https://www.service-public.fr/particuliers/actualites/A16024?lang=en

55 "Олон нийтийн телевизийн ёс зүйн дүрэм: 70 жилийн ойг тэмдэглэх нь" RTA (Radio y Televisión Argentina) – Аргентин Радио, телевиз, 2021 оны 7-р сар. https://new.tvpublica.com.ar/wp-content/uploads/2021/12/C%C3%B3digo-de-%C3%89tica-versi%C3%B3n-final-1.pdf

56 Нас Кампанелла, "Нас Кампанеллагийн хүч ба шийдэмгий байдал" Ричард Фидлерийн ярилцлага, Харилцан яриа, Австралийн өргөн нэвтрүүлгийн корпораци, 2023 оны 7-р сарын 11, аудио, 51:26. https://www.abc.net.au/listen/programs/conversations/nas-campanella-journalism-reporting-blindness-radio-tv-news/102514072

57 "Хүртээмжтэй контент," Хүртээмжтэй байдал, Радио-Канад, 2024 онд шинэчлэгдсэн. https://ici.radio-canada.ca/contenus-accessibles

"Та радио нэвтрүүлэг, подкастуудынхаа хуулбарыг бичгээр байдаг уу?" CBC тусламжийн төв, Радио шоу, Канадын өргөн нэвтрүүлгийн корпораци, 2023 оны 10-р сард шинэчлэгдсэн. https://cbchelp.cbc.ca/hc/en-ca/articles/217731887-Do-you-have-written-transcripts-of-your-radio-programs-and-podcasts-

58 ЮНЕСКО-ийн "WRD2024 - 07: Радио ба автомашины үйлдвэрлэл" 2024 оны 2-р сарын 13-нд нийтлэгдсэн. https://www.unesco.org/archives/multimedia/document-6821

59 Францын радиогийн 2021 оны 3-р сарын 31-нд нийтлэгдсэн "Радио Франц хараагүй болон хараан бэрхшээлтэй хүмүүст подкастуудаа ашиглах боломжтой болгохын тулд HumanWare-тэй түншлэлийн гэрээ байгууллаа." https://www.radiofrance.com/presse/radio-france-signe-un-accord-de-partenariat-avec-humanware-pour-rendre-ses-podcasts

60 Talking News Federation (TNF) 2023 онд хэвлэгдсэн. https://tnf.org.uk/

61 Олон улсын Улаан загалмайн хороо (ОУУЗХ), Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбооны хамтарсан төсөл болох Хямралд нэрвэгдсэн хүмүүсийг илүү сайн татан оролцуулахын тулд нийгмийн сүлжээг хэрхэн ашиглах вэ: Хүмүүнлэгийн байгууллагуудад сошиал медиа ашигладаг хүмүүст зориулсан товч гарын авлага. IFRC) болон НҮБ-ын Хүмүүнлэгийн хэрэг эрхлэх газар (OCHA) 2017 оны 9-р сард нийтлэгдсэн. https://communityengagementhub.org/resource/how-to-use-social-media-to-better-engage-people-affected-by-crises-2/

62 ЮНЕСКО, Хүртээмжтэй дижитал баримтат өв: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан баримтат өвийг хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэх заавар (Парис: ЮНЕСКО, 2020). https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374995

63 Канадын өргөн нэвтрүүлгийн корпорацийн "CBC Lite" нь бага зурвасын өргөнтэй вэб сайт нь 2024 оны 3-р сард шинэчлэгдсэн. https://www.cbc.ca/lite/news?sort=editors-picks

64 Номхон далайн хэвлэл мэдээллийн тусламжийн схем (PACMAS), Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хэвлэл мэдээллийн судалгаанд хамруулах (Мельбурн: Австралийн өргөн нэвтрүүлгийн корпораци, 2023). https://www.abc.net.au/abc-international-development/disability-inclusion-in-the-media-study-2023/103179418

65 2017 оны 2-р сарын 21-нд нийтлэгдсэн "Аль Жазира сүлжээний брэнд стратегиа эхлүүллээ". https://network.aljazeera.net/en/pressroom/al-jazeera-launches-its-network-brand-strategy

66 "Хүртээмжийн төлөвлөгөө ба санал хүсэлт," CBC/Radio-Canada, 2024 оны 3-р сард шинэчлэгдсэн. https://cbc.radio-canada.ca/en/accessibility-feedback

67 “CBC Abilicrew-ийн 2024 оны шилдэг хөтөлбөрт хамрагдах элсэлт” Канадын өргөн нэвтрүүлгийн корпораци, 2023 оны 11-р сарын 16-нд шинэчлэгдсэн. https://www.cbc.ca/cape/cbc-abilicrew-placements-for-excellence-program-2024-1.5151448

68 НҮБ-ын бодлогын портал. Боломжит орон сууцны удирдамж (2023 оны 8-р сарын 10). https://policy.un.org/tags/reasonable-accommodation

69 RTVE. Үйл ажиллагааны удирдамж, 2019 оны 11-р сарын 25-нд нийтлэгдсэн. https://www.rtve.es/rtve/20191125/rc-guias/2099981.shtml

70 Европын Зөвлөл, Асуудал ба түрэмгийллийн нөхцөл дэх сэтгүүл зүй: Европын холбогдох зөвлөлөөс гаргаж авсан зарчмууд болон бусад олон улсын стандартууд (Страсбург: Европын зөвлөл, 2022). https://rm.coe.int/compilation-of-coe-standards-relating-to-journalism-in-situations-of-c/1680a5b775

71 ЮНЕСКО болон Америк хоорондын Хүний эрхийн хүрээлэн (IIHR), Сэтгүүлчид, харилцаа холбоочид, хэвлэл мэдээллийн талаархи аюулгүй байдлын хүчний оролцоо ба харилцан үйлчлэлийн загвар протокол (Парис/Уругвай: ЮНЕСКО, 2023). https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000384739_eng

72 IJNET. Сэтгүүл зүй ба сэтгэцийн эрүүл мэндийн хэрэгсэл, хэвлэгдсэн 2024. https://ijnet.org/en/toolkit/mental-health-and-journalism

73 2012 оны 4-р сарын 12-нд батлагдсан Сэтгүүлчдийн аюулгүй байдал ба ялгүйдлийн асуудлаарх НҮБ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө, CI-12/CONF.202/6. https://www.ohchr.org/en/safety-of-journalists/un-plan-action-safety-journalists-and-issue-impunity

74 BBC Авьяас чадварын сангаа өргөжүүлэв. https://pages.beamery.eu/bbcstudios/page/extend

75 УХБ. Аж ахуйн нэгжүүдийг олон талт байдал, хамруулах замаар өөрчлөх нь (2022). https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_dialogue/---act_emp/documents/publication/wcms_841348.pdf

**ЮНЕСКО-гийн ажлын талаар болон Хэвлэл мэдээллийн Олон ургалч үзэл ба Олон талт байдлын талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар зочилно уу:**
https://www.unesco.org/en/media-pluralism-diversity

**ЮНЕСКО-гийн Хэвлэл мэдээлэл дэх Хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлын тухай санаачилгын талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл дараах хаягаар зочилно уу:**
https://www.unesco.org/en/media-pluralism-diversity/media-diversity/disability-equality-media

**Хэрэв та бидэнтэй холбогдож нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар цахим шуудан илгээнэ үү:**
media.pluralism-diversity@unesco.org

unesco

Энэхүү Практик Гарын Авлага нь Хэвлэл Мэдээллийн Хэрэгслээр Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийн Тэгш Байдлыг дэмжих зорилготой. Уг бүтээлд редактор, сурвалжлагч, контент үйлдвэрлэгчид, техникийн баг, хүний нөөцийн ажилтнууд болон менежерүүд зэрэг салбарын бүх талын мэргэжилтнүүдэд зориулсан хэрэгцээтэй зөвлөмжүүдийг багтаалаа. Гарын авлага нь тэгш хамруулах болон эрх тэгш байдлыг эрхэмлэсэн редакцын бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ гэнэтийн яаралтай нөхцөл байдлын үед болон эрэн сурвалжилгын үед ч сөхөж харах боломжтой сурвалж юм. Мөн дижитал шилжилтэд үнэлж баршгүй ач холбогдолтой хүртээмжтэй медиа контент бүтээхэд чиглэсэн удирдамжуудыг хавсаргасан. Эцэст нь, энэхүү гарын авлага нь хэвлэл мэдээллийн салбар дахь мэргэжилтнүүдийн олон талт байдал, эрх тэгш байдал, тэгш хамруулалтыг хангахын тулд инновац, бүтээлч санаачилгыг өдөөхийг зорьсон болно.

ЮНЕСКО нь дэлхийн хүн амын 16 хувийг бүрдүүлж буй мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үзэгч, хэрэглэгч болон мэргэжилтнүүдийн нэг томоохон хэсэг болсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийн Эрхийн Тухай Конвенцод нийцсэн хэвлэл мэдээллийн мэргэжлийн стандартыг сайжруулахад хүчин чармайлт гаргасаар байна.

9 789230 002435